

Соёлын биет бус өвийг
хамгаалах тухай 2003
оны Конвенцийн үр
дүнгийн хүрсэн түвшинг
тодорхойлох удирдамж

**GUIDANCE NOTES
FOR THE OVERALL
RESULTS FRAMEWORK
FOR THE 2003
CONVENTION FOR THE
SAFEGUARDING OF THE
INTANGIBLE CULTURAL
HERITAGE**

ЮНЕСКО-ИЙН 2003 ОНЫ КОНВЕНЦИЙН ҮР ДҮНГ ХАРУУЛАХ ЕРӨНХИЙ ХҮРЭЭ

Конвенцийн Үр дүнг харуулах Ерөнхий Хүрээ (ҮХЕХ)-г боловсруулах үйл явц нь 2013 онд ЮНЕСКО-ийн Соёлын Хэлтсээс стандарт тогтоох ажлын үнэлгээний нэг хэсэг болох ЮНЕСКО-ийн Дотоод Хяналтын Албаны (IOS) Зөвлөмжөөс эхэлсэн юм. Тэр жилдээ Соёлын биет бус өвийг хамгаалах Засгийн газар хоорондын Хорооноос энэхүү ҮХЕХ-г боловсруулахаар шийдсэн (Шийдвэр 8.COM 5.с.1) ба, дараа жил нь Засгийн газар хоорондын нээлттэй ажлын хэсгийг байгуулж ҮХЕХ-г боловсруулах ажилд урьсан болно (Шийдвэр 9.COM 13.e).

Засгийн газар хоорондын ажлын хэсгийн ажлыг эхлүүлэх үүднээс ЮНЕСКО-оос БНХАУ дахь ЮНЕСКО-ийн Үндэсний Комиссын дэмжлэгтэйгээр Бээжин хотноо ЮНЕСКО-ийн VI ангиллын шинжээчдийн уулзалтыг 2016 оны 9-р сарын 7-оос 9-ний өдрүүдэд зохион байгуулсан билээ. Хороо XI хуралдаанаараа тэрхүү шинжээчдийн уулзалтын өндөр дээд зэргийн үр дүнгийн байдалд сэтгэл нэн хангалуун байгаагаа илэрхийлсэн билээ (Шийдвэр 11.COM 14).

БНХАУ-ын Соёлын яам, Чэнду дахь Соёлын биет бус өвийг хамгаалах Төвийн өгөөмөр сэтгэлийн хувь нэмрийн үр ачаар Засгийн газар хоорондын нээлттэй ажлын хэсгийг 2017 оны 6-р сарын 11-13-ны өдрүүдэд БНХАУ-ын Чэнду хотод үүсгэн байгуулсан нь уг үйл явцыг үргэлжлүүлэх боломж олгосон юм. Тэрхүү өндөр түвшний үр дүнд үндэслэн ажлын хэсэг 26 үзүүлэлт тус бүр дээр удаан хугацаанд хэлэлцүүлэг өрнүүлж, үнэлгээ хийх 86 хүчин зүйл бүхий хүрээг боловсруулж чадсан юм. Хороо XII хуралдаанаараа Засгийн газар хоорондын нээлттэй ажлын хэсгийн хуралдааны үр дүнд бий болсон ҮХЕХ-ний төслийг хянаж үзээд, Ерөнхий Ассемблейд 2018 оны VII хуралдаанаараа батлахыг зөвлөмж болгосон (Шийдвэр 12.COM 9).

Хорооны Зөвлөмжийн дагуу Конвенцид оролцогч улсуудын Ерөнхий Ассемблейн VII хуралдаанаар ҮХЕХ-г баталсан билээ (Тогтоол 7.GA.9).

Дээрх шийдвэрүүдийн текстийг Нарийн бичгийн дарга нарын газрын вэбсайтаас авсан болно: <https://ich.unesco.org/en/overall-results-framework-00984>

Ази, Номхон далайн бүс нутгийн олон хэлээр хэвлэн нийтэлж байгаа нь.

Оролцогч улсуудын хугацаат тайланг Ази, Номхон далайн бүсийн хэмжээнд тэдгээр улс орнууд 2024 онд өргөн мэдүүлэхээр тогтсон болно.

ICHCAP нь ҮХЕХ болон түүний Удирдамжийг олон улсын хэл дээр хэвлэн гаргаж, тухайн бүс нутаг дахь Конвенцийн янз бүрийн оролцогч талуудад түгээх, сурталчлах замаар тэдний чадварыг бэхжүүлэх, 2003 оны Конвенцийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхийг зорьж байгаа болно.

Энэхүү хэвлэлийг БНСУ-ын Соёлын өвийн Захиргааны дэмжлэгтэйгээр ЮНЕСКО-ийн ивээлийн Ази, Номхон далайн бүсийн Соёлын биет бус өвийн олон улсын мэдээлэл, сүлжээний Төв (ICHCAP)-өөс эрхлэн гаргав.

2003 ОНЫ КОНВЕНЦИЙН ҮР ДҮНГ ХАРУУЛАХ ЕРӨНХИЙ ХҮРЭЭ

Хүснэгт 1: Тойм үзүүлэлтээр харуулах дээд түвшний хүрээ

Нөлөөллүүд	Өв соёлоо идэвхи зүтгэл, хариуцлагатайгаар өвлөн уламжилж яваа хамт олон, бүлэг, хувь хүмүүс соёлын биет бус өвийг сахин хамгаалж байдаг төдийгүй энх амгалан, бүх нийтийн оролцоот			
Урт хугацаанд хүрэх үр дүн	Соёлын биет бус өвийн оршин байх, өвлөн уламжлах нөхцлийг хангах явдлыг баталгаажуулсан байдал.		Соёлын биет бус өвийн олон төрлийг хүндэтгэн үзэж байгаа байдал (хүрсэн түвшин).	
Дунд хугацаанд хүрэх үр дүн	Өөр өөрийн онцлог бүхий янз бүрийн хамт олон, бүлэг, хувь хүмүүс болон бусад оролцогч талуудын хооронд соёлын биет бус өвийг хамгаалахад чиглэсэн үр ашигтай харилцаа үүсч төлөвшсөн байдал.			
Богино хугацаанд хүрэх үр дүн	Соёлын биет бус өвийг сахин хамгаалахад дэмжлэг үзүүлэх чадавхийг ерөнхийд нь сайжруулсан байдал.			
Хамрах сэдвүүд	Байгууллагын болон хүний чадавхи	Өвлөн уламжлал ба боловсрол	Бүртгэл-мэдээлэл ба судалгаа	Бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнүүд
Үндсэн үзүүлэлтүүд (тойм)	1. Эрх бүхий байгууллагууд СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахыг дэмжиж байгаа байдал	4. Албан болон албан бус боловсрол нь өвлөн уламжлалыг бэхжүүлж, харилцан хүндлэлийг дэмжиж байгаа байдал	7. Бүртгэл-мэдээлэл нь СББӨ-ийн олон төрлийг тусгаж, түүнийг хамгаалахад хувь нэмэр оруулж байгаа байдал	11. Соёлын талаар баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон төрлийг тусгаж, хэрэгжиж буй байдал

нийгэмд хүний сайн сайхан аж байдал, нэр төр, бүтээлч байдлын төлөөх тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж байдаг.

Соёлын биет бус өвийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн, ойлгож ухамсарласан, түүнийг хамгаалах нөхцлийг ханган баталгаажуулсан байдал.	СББӨ-ийг хамгаалахад чиглэсэн бүх түвшинд бүх оролцогч талуудыг хамруулсан үүрэг оролцоо, олон улсын хамтын ажиллагааг байдал.
---	--

Соёлын биет бус өвийн зарим онцгой өвийн зүйлүүдийг хадгалж, хамгаалах арга хэмжээ буюу төлөвлөгөөг янз бүрийн хамт олон, бүлэг, хувь хүмүүс хэрхэн идэвхитэй зохион байгуулж хэрэгжүүлж байгаа байдал.

Соёлын биет бус өвийн зарим онцгой өвийн зүйлүүдийг хамгаалах арга хэмжээ буюу төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулсан байдал.

Нийгэм дэх СББӨ-ийн үүрэг, түүний хамгаалалт	Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	Хамт олон, бүлэг, хувь хүмүүс болон бусад оролцогч талуудын үүрэг, оролцоо	Олон улсын хамтын ажиллагаа
15. Нийгэм дэх СББӨ-ийн ач холбогдлыг өргөнөөр хүлээн зөвшөөрч байгаа байдал	17. Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хамт олон, бүлэг, хувь хүмүүс өргөнөөр оролцож байгаа байдал	21. СББӨ-ийг хамгаалахад оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлсэн байдал	23. Хороо нь ТББ, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, хувь хүмүүсийг оролцуулж байгаа байдал ¹

1. Энэ үзүүлэлт нь зөвхөн олон улсын хэмжээнд хяналт тавих, тайлагнахад хэрэглэгдэнэ.

<p>2. Хөтөлбөрүүд нь СББӨ-ийг хамгаалахад чиглэсэн хүний чадвар, чадавхийг бэхжүүлэхэд хэр зэрэг дэмжлэг үзүүлдэг байдал</p> <p>3. Хамт олон болон соёл, өвийн чиглэлээр ажилладаг хүмүүс сургалтыг удирдан зохион байгуулж байгаа, эсвэл тэдний эрэлт сонирхолд нийцүүлж байгаа байдал</p>	<p>5. СББӨ-ийг бага болон дунд боловсролын хөтөлбөрт нэгтгэсэн байдал</p> <p>6. Дунд сургуулийн дараах шатны боловсролд СББӨ-ийн хамгаалалт, судалгааг дэмжиж байгаа байдал</p>	<p>8. Бүртгэл-мэдээллийн явц нь бүх нийтэд хүртээмжтэй, олон төрлийг хүндэтгэдэг, хамт олон, бүлгүүд СББӨ-өө сахин хамгаалахыг дэмжиж байгаа байдал</p> <p>9. СББӨ-ийн судалгаа, баримтжуулалт нь түүнийг хамгаалахад дэмжлэг үзүүлж буй байдал</p> <p>10. Судалгааны үр дүн нээлттэй, ашиглах боломжтой байгаа байдал</p>	<p>12. Боловсролын талаар баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон төрлийг тусгаж, хэрэгжиж буй байдал</p> <p>13. Соёл, боловсролоос бусад салбарт баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон төрлийг тусгаж, хэрэгжиж байгаа байдал</p> <p>14. Бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь уламжлалт ёс, зан үйл, илэрхийллийг хүндэтгэдэг байх</p>
---	---	--	--

<p>16. Олон түмнийг хамаргах төлөвлөгөө, хөтөлбөрүүд нь СББӨ-ийг хамгаалахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, өөрийгөө болон харилцан хүндлэх явдлыг дэмжиж байгаа байдал</p>	<p>18. Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээлэл оролцож байгаа байдал</p> <p>19. Олон нийтийн мэдээллийн арга хэмжээ нь мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж буй байдал</p> <p>20. Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд ёс зүйн зарчмыг хүндлэн дээдэлж буй байдал</p>	<p>22. Иргэний нийгэм СББӨ-ийн хамгаалалтад хяналт тавихад хувь нэмэр оруулж буй байдал</p>	<p>24. Оролцогч улсууд СББӨ-ийг хамгаалахад хамтран ажиллаж байгаа байдал</p> <p>25. Оролцогч улсууд нь олон улсын сүлжээ, байгууллагуудын хамтын ажиллагаанд оролцож байгаа байдал</p> <p>26. СББӨ-ийн сан нь хамгаалалт ба олон улсын хамтын ажиллагааг дэмжиж байгаа байдал²</p>
---	---	---	--

2. Энэ үзүүлэлт нь зөвхөн олон улсын хэмжээнд хяналт тавих, тайлагнахад хэрэглэгдэнэ.

Хүснэгт 2: Хамрах сэдвүүдэд тохирсон үндсэн үзүүлэлтүүд ба үнэлгэний хүчин зүйлүүд

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Байгууллагын болон хүний чадавхи	1. Эрх бүхий байгууллагууд болон зөвлөлдөх бүтцүүд СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахыг хэр зэрэг дэмжиж байгаа байдал	1.1 СББӨ-ийг хамгаалах нэг буюу хэд хэдэн эрх бүхий байгууллагыг томилсон эсвэл байгуулсан байна. 1.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран ³ СББӨ-ийн онцлог өвийн зүйлүүдийг хамгаалах эрх бүхий байгууллагууд ажиллаж байна. 1.3 Ялангуяа холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүс өргөнөөр хамрагддаг бүх нийтийн ⁴ оролцоо бүхий СББӨ-ийн хамгаалалт, менежмент нь зөвлөлдөх байгууллага эсвэл бусад зохицуулалтын механизмээр дэмжигддэг байна. 1.4 СББӨ-ийг баримтжуулдаг институт, байгууллага болон/эсвэл санал санаачилгууд дэмжигддэг, мөн СББӨ-ийн оршин байх, өвлөн уламжлахад дэмжлэг үзүүлэх зорилгоор баримтжуулсан материалыг ашигладаг байна. 1.5 Соёлын төвүүд, мэргэжлийн төвүүд, эрдэм шинжилгээний институт, музей, архив, номын сан зэрэг байгууллагууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментэд хувь нэмэр оруулдаг болсон байна.
	2. Хөтөлбөрүүд нь СББӨ-ийг хамгаалахад чиглэсэн хүний чадвар, чадавхийг бэхжүүлэхэд хэр зэрэг дэмжлэг үзүүлж байгаа байдал	2.1 Дээд боловсрол эзэмшүүлэх институт, байгууллагууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чиглэлээр бүх нийтэд зориулсан сургалт явуулдаг, мэргэжлийн зэрэг олгодог байна. 2.2 Төрийн байгууллагууд, төвүүд болон бусад байгууллагууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн талаар бүх нийтэд зориулсан сургалт явуулдаг байна. 2.3 Хамт олон, ТББ-д түшиглэсэн санаачилгууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чиглэлээр бүх нийтэд хүртээмжтэй байдлаар сургалт явуулдаг байна.

3. “Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран” гэсэн ишлэлийг “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт эсвэл Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн” гэж ойлгох хэрэгтэй.

4. “Бүх нийтийн”, “бүх нийтэд зориулсан”, эсвэл “бүх нийтэд хүртээмжтэй” гэсэн ишлэлийг “уугуул иргэд, шилжин суурьшигчид, цагаачид, дүрвэгсэд, бүх насны эрэгтэй эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй болон эмээт бүлгийн гишүүд зэрэг нийгмийн бүхий л бүлэг, давхаргыг хамруулах” гэж ойлгох хэрэгтэй (Үйл ажиллагааны Удирдамж 174 ба 194). Эдгээр үйл ажиллагаа, үр дүнгийн талаар мэдээлэх үед оролцогч улсуудыг тухайн мэдээллийн талаар тусгайлан тайлагнах, эсвэл ийм “бүх нийтэд хүртээмжтэй” байдлыг хэрхэн хангаж байгаа талаар тайлбар хийхийг уриалах болно.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Байгууллагын болон хүний чадавхи	3. Хамт олон болон соёл, өвийн чиглэлээр ажилладаг хүмүүс сургалтыг зохион байгуулж байгаа, эсвэл тэдний эрэлт сонирхолд нийцүүлж байгаа байдал	3.1 Хамт олны өөрсдөө удирдан зохион байгуулдаг болон бусад сургалтын хөтөлбөрүүд нь хамт олон, бүлэг, хувь хүмүүсийг тэгш оролцуулах замаар тухайн зорилтот СББӨ-ийг хөгжүүлэх чадавхийг бэхжүүлж байна. 3.2 Сургалтын хөтөлбөрүүд нь соёл болон соёлын өвийн чиглэлээр ажилладаг хүмүүсийг тэгш оролцуулах замаар зорилтот СББӨ-ийг хөгжүүлэх чадавхийг бэхжүүлж байна.
Өвлөн уламжлал ба боловсрол	4. Албан болон албан бус боловсрол нь СББӨ-ийн өвлөн уламжлалыг хэр зэрэг бэхжүүлж, харилцан хүндлэлийг дэмжиж байгаа байдал	4.1 Өвлөн үйлдэгч ба өвлөн уламжлагч ⁵ нар нь СББӨ-ийн боловсролын хөтөлбөрийг төлөвлөн боловсруулахад болон/эсвэл өв уламжлалаа идэвхитгэйгээр таниулах, өвлөн уламжлуулахад адил тэгш оролцдог байна. 4.2 Хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн СББӨ-өө өвлөн уламжлахад хүлээн зөвшөөрөгдсөн дэг жаяг, арга хэлбэрийг сургадаг ба/эсвэл бэхжүүлдэг, мөн албан ба албан бус боловсролын хөтөлбөрт тусган оруулдаг байна. 4.3 Хамт олон, бүлэг, ТББ эсвэл соёлын өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын СББӨ, түүнийг өвлөн уламжлах үйл ажиллагааг бататгахтай холбоотой хэрэгжүүлж буй боловсролын хөтөлбөрүүд, хичээлээс гадуурхи үйл ажиллагаа нь хүртээмжтэй, дэмжигддэг байна. 4.4 Багш нарын сургалтын хөтөлбөр, албан бус боловсрол олгох сургалт эрхлэгчдэд зориулсан хөтөлбөрүүдэд СББӨ, түүнийг хадгалж хамгаалах асуудлыг боловсролын сургалтанд нэгтгэн тусгаж байх арга хандлагыг оруулж өгсөн байна.

5. Энэхүү конвенцид “хамт олон, бүлэг, хувь хүмүүс” гэсэн илэрхийллийг байнга хэрэглэдэг боловч “Үйл Ажиллагааны Удирдамж” зэрэг үнэлгээ хийхэд ашиглагддаг зарим хүчин зүйлүүдэд тухайн СББӨ-ийн зүйлийн хувьд тодорхой үрэг гүйцэтгэдэг зарим гишүүдийг илүү сайн тодорхойлох үүднээс “өвлөн үйлдэгч ба өвлөн уламжлагч” гэсэн илэрхийллийг сонгон хэрэглэж байна.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Өвлөн уламжлал ба боловсрол	<p>5. СББӨ болон түүний хамгаалалтын асуудлыг бага болон дунд боловсролын хөтөлбөрт хэр зэрэг нэгтгэсэн, тохиромжтой хичээлүүдэд хэр зэрэг тусгасан, мөн СББӨ-ийн тухай болон өөрийн болон бусдын СББӨ-ийг хүндэтгэх талаар зааж сургах явдал хэр зэрэг тогтмол болсон байдал</p>	<p>5.1 СББӨ, түүний олон төрөл нь холбогдох мэргэжлийн хичээлүүдийн агуулгад тусгагдсан байна. Энэ нь тухайн хичээлийн агуулгад хувь нэмэр оруулсан буюу/эсвэл бусад сэдвүүдийг тайлбарлах, батлан харуулах арга хэрэгсэл болсон байна.</p> <p>5.2 Сургуулийн сурагчид нь боловсрол, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан өөрсдийн хамт олон, бүлгийн СББӨ болон бусдын СББӨ-ийг хүндэтгэж, харилцан тусган авч суралцдаг болсон байна.</p> <p>5.3 Суралцагчдын эзэмшсэн СББӨ-ийн олон төрөл нь эх хэлээр эсвэл олон хэлээр сургалт явуулах, ба/эсвэл "нүгтийн агуулга"-ыг боловсролын хөтөлбөрт оруулах замаар биеллээ олсон байна.</p> <p>5.4 Боловсролын хөтөлбөрүүд нь СББӨ-ийг илэрхийлэхэд шаардлагатай байгалийн болон соёлын орон зай, дурсгалт газруудыг хамгаалах талаар заадаг болсон байна.</p>
	<p>6. Дунд сургуулийн дараахь шатны боловсролын байгууллага нь СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахыг бататгадаг тийм сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж мэргэжлийн зэрэг (хөгжим, урлаг, гар урлал, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт гэх мэт) олгодог болсон байна.</p> <p>6.2 Дунд сургуулийн дараахь шатны боловсролын байгууллага нь СББӨ, түүний нийгэм, соёлын болон бусад ач холбогдол, хүрээг судалдаг сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж мэргэжлийн зэрэг олгодог болсон байна.</p>	

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Бүртгэл-мэдээлэл ба судалгаа	<p>7. Бүртгэл-мэдээлэл нь СББӨ-ийн олон төрлийг хэр зэрэг тусгаж, түүнийг хамгаалахад хувь нэмэр оруулж байгаа байдал</p>	<p>7.1 СББӨ-ийн олон төрлийг хамгаалах болон тусган харуулахад чиглэсэн бүртгэл-мэдээллийн нэг ба хэд хэдэн тогтолцоог бий болгож ажиллуулсан, түүнийг баталгаажуулснаас хойш шинэчлэн сайжруулсан байна.</p> <p>7.2 Тусгай зориулалтын бүртгэл-мэдээлэл ба/эсвэл янз бүрийн хүрээг хамарсан бүртгэл-мэдээлэл нь СББӨ-ийн олон төрлийг тусган харуулж, түүнийг хамгаалахад хувь нэмэр оруулдаг болсон байна.</p> <p>7.3 Одоо байгаа бүртгэл-мэдээлэл эсвэл бүртгэл-мэдээллүүдийг тайлагнах хугацаанд баяжуулж сайжруулсан, ялангуяа тухайн бүртгэл-мэдээлэлд орсон өвийн зүйлүүдийн одоогийн оршин байх чадварыг тусган харуулсан байна.</p> <p>7.4 СББӨ-ийн зарим зүйлийг үзэж танилцахад дагаж мөрддөг онцлог уламжлал, зан үйлд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ СББӨ-ийн бүртгэл-мэдээллийг нийтэд хүртээмжтэй байх нөхцлийг бүрдүүлэх, хамгаалалтыг бэхжүүлэх зорилгоор түүнийг ашигладаг болсон байна.</p>
	<p>8. Бүртгэл-мэдээллийн явц нь бүх нийтэд хүртээмжтэй, СББӨ-ийн олон төрөл, түүний өвлөн уламжлагчдыг хүндэтгэдэг, холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүс СББӨ-өө сахин хамгаалахыг дэмжиж байгаа байдал</p>	<p>8.1 Хамт олон, бүлгүүд, холбогдох ТББ-үүд нь бүртгэл-мэдээллийн ажилд өргөнөөр оролцдог бөгөөд энэ нь тэдний СББӨ-өө хамгаалах үйл ажиллагааг мэдээллээр хангах, бэхжүүлэхэд тус болдог байна.</p> <p>8.2 Бүртгэл-мэдээллийн явцад СББӨ-ийн олон төрөл, түүнийг эзэмшин үйлдэгч нарыг хүндэтгэн үздэг байна. Ингэхдээ нийгмийн бүх давхарга, эрэгтэй, эмэгтэй болон бүх бүс нутгийн зан үйл, өвийн илэрхийллүүдийг хамруулдаг болсон байна.</p>

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Бүртгэл-мэдээлэл ба судалгаа	9. Шинжлэх ухаан, техник болон урлаг судлалыг оруулаад СББӨ-ийн судалгаа, баримтжуулалт нь түүнийг хамгаалахад хэр зэрэг дэмжлэг үзүүлж байгаа байдал	9.1 Санхүүгийн болон бусад хэлбэрээр үзүүлэх дэмжлэг, туслалцаа нь шинжлэх ухаан, техник болон урлагийн чиглэлээр судалгаа хийх, баримтжуулах ба архивт авах ажлыг дэмждэг, СББӨ-ийг хамгаалахад зорьсон бөгөөд холбогдох ёс зүйн зарчмыг мөрддөг байна. 9.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийг ерөнхийд нь ба СББӨ-ийн зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад чиглэсэн, нөлөө үзүүлэхүйц арга хандлага бүхий судалгааг тэтгэн дэмждэг болсон байна. 9.3 СББӨ-ийг өвлөн үйлдэгчид болон өвлөн уламжлагчид нь аль ч тохиолдолд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр тэднээс дэмжсэн зөвшөөрөл олгосны дагуу шинжлэх ухаан, техник болон урлаг судлалын ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, судалгааны ажлын үр дүнг түгээхэд оролцдог байна.
	10. Судалгааны үр дүн, баримтжуулсан материал нь аль хэр хүртээмжтэй, бодлого боловсруулах үйл ажиллагааг бэхжүүлэх болон хамгаалалтыг сайжруулах зорилгоор хэр зэрэг ашиглагдаж байгаа байдал	10.1 Баримтжуулалт ба судалгааны үр дүн нь СББӨ-ийн зарим зүйлийг үзэж танилцахад дагаж мөрддөг онцгой зан үйлд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ хамт олон, бүлэг, хувь хүмүүст хүртээмжтэй болсон байна. 10.2 СББӨ-ийн талаарх судалгаа, баримт материал, шинжлэх ухаан, техник болон урлагийн судалгааны ажлын үр дүнг салбар бүрт бодлого боловсруулах үйл ажиллагааг бэхжүүлэхэд ашиглаж байна. 10.3 СББӨ-ийн талаарх судалгаа, баримт материал, шинжлэх ухаан, техник болон урлагийн судалгааны ажлын үр дүнг хамгаалалтыг сайжруулах зорилгоор ашиглаж байна.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнүүд	11. Соёлын талаар баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон төрөл, түүнийг хамгаалахын ач холбогдлыг аль хэр тусгаж, хэрэгжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	11.1 СББӨ болон түүний хамгаалалтыг нэгтгэсэн, олон төрлийг нь тусгасан соёлын бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнүүдийг баталсан, эсвэл шинэчлэн боловсруулсан бөгөөд тэдгээр нь одоо хэрэгжиж байна. 11.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран зарим онцгой өвийн зүйлүүдийг хамгаалахад чиглэсэн төлөвлөгөөг хамруулан СББӨ-ийг хамгаалах үндэсний болон бүсийн (орон нутгийн) стратеги ба/эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан, эсвэл шинэчлэн боловсруулсан бөгөөд тэдгээр нь одоо хэрэгжиж байна. 11.3 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийн зүйлүүдийг хамгаалахад чиглэсэн төрийн санхүүгийн болон/эсвэл техникийн дэмжлэг, тусламжийг соёл болон өвийг өргөн цар хүрээнд бүхэлд нь дэмжих зорилгоор тэгш байх зарчмаар хуваарилдаг байна. Ингэхдээ яаралтай хамгаалах шаардлагатай өвийн зүйлсийг нэн тэргүүнд авч үзэж хуваарилсан байна.
	12. Боловсролын талаар баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон төрөл, түүнийг хамгаалахын ач холбогдлыг аль хэр тусгаж, хэрэгжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	11.4 СББӨ ба түүний хамгаалалтыг нэгтгэсэн соёлын бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээний талаар хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн идэвхтэй оролцоотойгоор мэдээлдэг байна. 12.1 Соёлын биет бус өвийг хүлээн зөвшөөрөх, хүндлэн дээдлэх, сайжруулах зорилгоор боловсролын талаар баримтлах бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг баталдаг, эсвэл шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлдэг байна. 12.2 СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлах явдлыг бэхжүүлэх зорилгоор боловсролын талаар баримтлах бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг баталдаг, эсвэл шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлдэг байна.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнүүд	13. Соёл, боловсролоос бусад салбарт баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон төрөл, түүнийг хамгаалахын ач холбогдлыг аль хэр тусгаж, хэрэгжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	13.1 Соёлын биет бус өвийг хамгаалахад ёс зүйн зарчмуудыг хөгжлийн төлөвлөгөө, бодлого, хөтөлбөрт хүндэтгэн үздэг байна. 13.2 Бүх нийтийн оролцоотой нийгмийн хөгжил ⁶ , байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг СББӨ болон түүний хамгаалалтын байдлыг харгалзан үзэж боловсруулан баталдаг, шинэчлэн сайжруулдаг байна. 13.3 Байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг тухайн нөлөөлөлд өртсөн СББӨ-ийг хамруулж, нөлөөлөлд өртсөн хүн ам тэдгээрийг тэсвэрлэн даван гарахад СББӨ-ийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч боловсруулан баталдаг, шинэчлэн сайжруулдаг байна. 13.4 Бүх нийтийн оролцоотой эдийн засгийн хөгжлийн ⁷ талаар баримтлах бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг СББӨ болон түүний хамгаалалтын байдлыг харгалзан үзэж боловсруулан баталдаг, шинэчлэн сайжруулдаг байна. 13.5 СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлах нөхцлийг ханган бүрдүүлэх, эсвэл хөхүүлэн дэмжих, өвийн зүйлийг эзэмшин үйлдэхэд шаардлагатай байгалийн болон бусад нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн болон төсвийн тааламжтай арга хэмжээ, урамшууллын тогтолцоог боловсруулан баталдаг, шинэчлэн сайжруулдаг байна.
	14. Бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь уламжлалт ёс, зан үйл, илэрхийлэлд, ялангуяа тэдгээрийг эзэмшин үйлдэх,	14.1 СББӨ-ийг өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагчид, хамт олны СББӨ-ийг арилжааны болон бусад зорилгоор ашиглах үед тэд нарт оюуны өмчийн эрх, нүүцлалын эрх зэрэг эрх зүйн хамгаалалтуудыг олгодог байна. 14.2 СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахад зайлшгүй шаардлагатай газар, далай, ойн экосистемийг хэрэглэх хамт олон, бүлгүүдийн уламжлалт эрхийн ач холбогдлыг бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнээ хүлээн зөвшөөрч, харгалзан үздэг байна.

6. “Үйл ажиллагааны Үйлдвэмж”-ийн Бүлэг VI-д нийцүүлэн (12-р үзүүлэлт (индикатор)-д оруулсан) “Бүх нийтийн оролцоотой нийгмийн хөгжил” гэдэгт хүнсний аюулгүй байдал, чанартай эрүүл мэндийн үйлчилгээ, жендэрийн эрх тэгш байдал, цэвэр усны хангамж, усны тогтвортой хэрэглээ, боловсролын чанар зэргийг хамаатуулан ойлгоно.

7. “Үйл ажиллагааны Үйлдвэмж”-ийн Бүлэг VI-д нийцүүлэн “Бүх нийтийн оролцоотой эдийн засгийн хөгжил” гэдэгт орлого бүрдүүлэх, тогтвортой амьжиргаа, үр бүтээлтэй ажлын байр, зохистой хөдөлмөр эрхлэлт, аялал жуулчлалын салбарын СББӨ-ийн хамгаалалтад үзүүлэх нөлөө, мөн эсрэгээрээ СББӨ-ийн аялал жуулчлалд үзүүлэх нөлөө зэргийг хамаатуулан ойлгоно.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнүүд	15. Нийгэм дэх СББӨ-ийн ач холбогдол, түүний хамгаалалтыг хамт олон, бүлэг, хувь хүмүүс болон нийгэм бүхэлдээ аль хэр хүлээн зөвшөөрч байгаа байдал (хүрсэн түвшин)	14.3 Бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь маргаанаас урьдчилан сэргийлэх, зөрчил мөргөлдөөнийг энх тайвнаар шийдвэрлэхэд хувь нэмэр оруулж буй соёлын биет бус өвийн илэрхийлэл, зан үйл, төлөөллийг талархан зөвшөөрч дэмждэг байна. 15.1 Хамт олон, бүлэг, хувь хүмүүс СББӨ-өө тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг оруулаад өөрсдийн сайн сайхны төлөө ашигладаг байна. 15.2 Хамт олон, бүлэг, хувь хүмүүс өөрсдийн СББӨ-ийг харилцан ойлголцох, харилцан хүндлэх, зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг бэхжүүлэхэд чиглэсэн яриа хэлэлцээрт ашигладаг байна. 15.3 Хөгжлийн арга хэмжээнүүд нь СББӨ бол нийгэмд түүний өвөрмөц онцлог, залгамж холбоо, мэдлэг, үр чадварын эх ундарга нь болж байдаг ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, тогтвортой хөгжлийг хангах нөөц бололцоо болгон бататган бэхжүүлдэг байна.
Нийгэм дэх СББӨ-ийн үүрэг, түүний хамгаалалт	16. Бүх нийтийн оролцоог хангасан төлөвлөгөө, хөтөлбөрүүд нь СББӨ-ийн ач холбогдол, түүний хамгаалалтыг хүлээн зөвшөөрч, өөрийгөө болон харилцан хүндлэх явдлыг хэр зэрэг дэмжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	16.1 СББӨ-ийн хамгаалалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүд нь нийгмийн бүх салбар, давхаргыг хамардаг байх. Үүнд: <ul style="list-style-type: none"> • нутгийн уугуул иргэд; • өөр хоорондоо онцлог ялгаа бүхий угсаатны бүлгүүд; • шилжин суурьшигчид, цагаачид, дүрвэгсэд; • янз бүрийн насны хүмүүс; • янз бүрийн хүйсийн хүмүүс; • хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс; • эмзэг бүлгийн гишүүд. 16.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран зарим онцгой өвийн зүйлийг ба/эсвэл СББӨ-ийг бүхэлд нь хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн дунд өөрсдийгөө хүндлэх, бие биенээ харилцан хүндлэх харилцаа бий болсон байна.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	17. СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хамт олон, бүлэг, хувь хүмүүс аль хэр өргөнөөр оролцож байгаа байдал (хүрсэн түвшин)	17.1 Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн бүх нийтийн оролцоог боломжийн хэрээр хамгийн өргөн цар хүрээгээр хамруулахаар тусгадаг байна. 17.2 Соёлын биет бус өвийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулахдаа холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсээс тэдэнд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр дэмжсэн зөвшөөрөл авч баталгаажуулдаг байна. 17.3 СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд тухайн хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн эрх, тэдний ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхлыг зохих ёсоор хамгаалдаг байна. 17.4 Залуучууд өөрсдийн хамт олон, бүлгийн соёлын биет бус өвийн талаарх мэдээлэл цуглуулах, түгээх зэрэг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйлсэд идэвхитэй оролцдог болсон байна. 17.5 Хамт олон, бүлэг, хувь хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны технологи, мэдээллийн бүх хэлбэр, ялангуяа шинэ мэдээллийн хэрэгслийг СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд ашигладаг байна.
	18. СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, харилцан ойлголцол болон хүндлэлийг хөгжүүлэхэд зориулагдсан үйл ажиллагаа	18.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн харилцан хүндлэлийг хөгүүлэн дэмждэг байна. 18.2 СББӨ-ийн чиглэлээрх оролцогч талууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хооронд СББӨ-ийн талаарх тодорхой хамтын ажиллагаа тогтоон, хөтөлбөрүүд байгуулж, хэрэгжүүлж, чадавхийг бэхжүүлдэг байна. 18.3 СББӨ-ийн талаарх медиа програмчлал нь бүх нийтэд хүртээмжтэй бөгөөд холбогдох хамт олон, бүлгүүдийн хэлээр, мөн/эсвэл өөр өөр зорилтот бүлгүүдэд зориулан эрхлэн ажиллуулдаг байна. 18.4 Соёлын биет бус өв, түүнийг хамгаалах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээлэл нь Конвенцийн үзэл санаа, нэр томъёог баримталдаг байна.
	19. Олон нийтийн мэдээллийн арга хэмжээ нь СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд зориулагдсан үйл ажиллагаа	19.1 СББӨ-ийг өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагчдыг бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулж өөрсдийг нь оролцуулж олон нийтэд танилцуулан сурталчилж байна. 19.2 СББӨ, түүний ач холбогдол, хамгаалалт, Конвенцийн талаар олон нийтийн арга хэмжээнүүдийг хамт олон, бүлэг, хувь хүмүүс, хүн ам, судлаачид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад оролцогч талуудад зориулан зохион байгуулдаг байна. 19.3 Хамгаалалтын сайн туршлагыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг дэмждэг, тэтгэдэг байна.
	20. СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд нь зүйн зарчмуудыг хэр зэрэг хүндлэн дэмжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	19.4 СББӨ-ийн талаарх олон нийтийн мэдээлэл нь хамт олон, бүлгүүдийн дотор болон хоорондын харилцан хүндлэл, талархлыг дэмждэг байх.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	19. Олон нийтийн мэдээллийн арга хэмжээ нь СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд зориулагдсан үйл ажиллагаа	19.1 СББӨ-ийг өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагчдыг бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулж өөрсдийг нь оролцуулж олон нийтэд танилцуулан сурталчилж байна. 19.2 СББӨ, түүний ач холбогдол, хамгаалалт, Конвенцийн талаар олон нийтийн арга хэмжээнүүдийг хамт олон, бүлэг, хувь хүмүүс, хүн ам, судлаачид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад оролцогч талуудад зориулан зохион байгуулдаг байна. 19.3 Хамгаалалтын сайн туршлагыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг дэмждэг, тэтгэдэг байна.
	20. СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд нь зүйн зарчмуудыг хэр зэрэг хүндлэн дэмжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	19.4 СББӨ-ийн талаарх олон нийтийн мэдээлэл нь хамт олон, бүлгүүдийн дотор болон хоорондын харилцан хүндлэл, талархлыг дэмждэг байх.
	20. СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд нь зүйн зарчмуудыг хэр зэрэг хүндлэн дэмжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	20.1 Соёлын биет бус өвийг хамгаалахтай холбоотой ёс зүйн зарчмуудыг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд хүндэтгэн авч үздэг байх. 20.2 Ёс зүйн зарчмууд, ялангуяа холбогдох мэргэжлийн ёс зүй болон стандартуудад тусгагдсан зарчмуудыг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаандаа хүндэтгэн авч үздэг байх.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Хамт олон, бүлэг, хувь хүмүүс болон бусад оролцогч талуудын үүрэг, оролцоо	21. СББӨ-ийг хамгаалахад оролцогч талуудын оролцоог хэр зэрэг нэмэгдүүлж байгаа байдал (хүрсэн түвшин)	21.1 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийг ерөнхийд нь болон зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн бүх нийтийн оролцоог боломжийн хэрээр хамгийн өргөн хүрээгээр хамруулдаг байх.
		21.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийг ерөнхийд нь болон зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад ТББ болон иргэний нийгмийн бусад оролцогчид өргөнөөр оролцдог байх.
		21.3 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран хувийн хэвшлийн байгууллагууд СББӨ-ийг хамгаалахтай холбоотой ёс зүйн зарчмыг хүндэтгэн үзсэн үндсэн дээр СББӨ-ийг ерөнхийд нь болон зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад оролцдог байх.
	22. Иргэний нийгэм СББӨ-ийн хамгаалалтад хяналт тавихад хэр зэрэг хувь нэмэр оруулж байгаа байдал (хүрсэн түвшин)	22.1 Холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүс СББӨ-ийн хамгаалалтын хөтөлбөр, арга хэмжээний талаарх шинжлэх ухаан, техник, урлагийн судалгаа хийх, хяналт тавих таатай орчин бүрдсэн байна.
		22.2 ТББ, иргэний нийгмийн бусад байгууллагууд СББӨ-ийн хамгаалалтын хөтөлбөр, арга хэмжээний талаарх шинжлэх ухаан, техник, урлагийн судалгаа хийх, хяналт тавих таатай орчин бүрдсэн байна.
		22.3 Эрдэмтэд, шинжээчид, эрдэм шинжилгээний байгууллагууд, мэргэжлийн төвүүд нь СББӨ-ийн хамгаалалтын хөтөлбөр, арга хэмжээний талаарх шинжлэх ухаан, техник, урлагийн судалгаа хийх, хяналт тавих таатай орчин бүрдсэн байна.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Олон улсын хамтын ажиллагаа	23. Хорооноос зөвлөх болон зөвлөлдөх ажил үүрэгт татан оролцуулж байгаа ТББ, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, хувь хүмүүсийн тоо болон газарзүйн тархалтын байршил ⁸	23.1 Зөвлөх үйлчилгээ үзүүлэх батламжит ТББ-уудын тоо, газарзүйн тархалтын байршил болон СББӨ-ийн аймгууд дахь тэдгээрийн төлөөлөл.
		23.2 Конвенцийн удирдах байгууллагуудын хуралдаан, ажлын хэсэгт оролцож буй ЮНЕСКО-ийн батламжит ТББ-уудын хувь хэмжээ, тэдгээрийн газарзүйн тархалтын байршил.
		23.3 Үнэлгээний механизмээс гадуур зөвлөлдөх зорилгоор Хорооноос батламжит төрийн бус байгууллагуудыг татан оролцуулсан тохиолдол болон үйл ажиллагааны тоо.
		24.1 Ерөнхийдөө СББӨ-ийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс хоёр талт, олон талт, бүс нутгийн эсвэл олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж байна.
	24. СББӨ-ийг хамгаалах талаар бусад Оролцогч улс орнуудтай идэвхтэй хамтран ажиллаж байгаа Оролцогч улс орнуудын хувь хэмжээ (процент)	24.2 СББӨ-ийн зарим онцгой өвийн зүйлс, ялангуяа аюул занал учирч буй, нэгээс олон улсын нутаг дэвсгэрт байгаа болон хил дамнансан өвийн зүйлүүдийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор хоёр талт, олон талт, бүс нутгийн эсвэл олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.
		24.3 Хамгаалалтын сайн туршлагыг багтаасан СББӨ болон түүний хамгаалалтын талаарх мэдээлэл, туршлагыг бусад оролцогч улсуудтай солилцдог байна.
		24.4 Өөр нэг оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа СББӨ-ийн зүйлийн талаарх баримт, мэдээллийг тэр Оролцогч улстай хуваалцдаг байна.

8. Энэ үзүүлэлт нь зөвхөн олон улсын хэмжээнд хяналт тавих, тайлагнахад хэрэглэгдэнэ.

Хамрах сэдвүүд	Үндсэн үзүүлэлтүүд	Дараах хүчин зүйлүүдийн дагуу үнэлгээ хийх
Олон улсын хамтын ажиллагаа	25. Олон улсын сүлжээ, байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд идэвхтэй оролцож байгаа Оролцогч улс орнуудын хувь хэмжээ (процент)	<p>25.1 Оролцогч улс нь арга хэмжээг хүлээн авагч, зохион байгуулагч буюу ач тусыг хүртэгчийн хувьд ЮНЕСКО-ийн СББӨ-ийн 2-р ангиллын Төвүүдийн үйл ажиллагаанд оролцдог байна.</p> <p>25.2 СББӨ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хамт олон, бүлэг, хувь хүмүүс, төрийн бус байгууллагууд, шинжээчид, мэргэжлийн төвүүд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн дунд олон улсын сүлжээг хөхүүлэн дэмжиж ажилладаг байна.</p> <p>25.3 Оролцогч улс нь ЮНЕСКО-оос бусад олон улсын болон бус нутгийн байгууллагуудын СББӨ-тэй холбоотой үйл ажиллагаанд оролцдог байна.</p>
	26. СББӨ-ийн олон улсын Сан нь хамгаалалт ба олон улсын хамтын ажиллагааг дэмжиж ажилладаг байна. ⁹	<p>26.1 Оролцогч улсууд СББӨ-ийн сангаас санхүүгийн болон техникийн туслалцаа хүсч, ийм тусламжийн үр дүнд СББӨ-ийг хамгаалах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.</p> <p>26.2 Оролцогч улсууд эсвэл бусад байгууллагууд ерөнхий болон тодорхой зорилгоор, ялангуяа олон улсын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрт зориулж СББӨ-ийн Санд сайн дураараа нэмж хандив өгдөг байна.</p> <p>26.3 Хөгжиж буй орнуудын СББӨ-ийн мэргэжилтнүүд, батламжит ТББ, төрийн болон хувийн байгууллагууд, Хорооны хүрлүүдэд зөвлөх эрхтэйгээр уригдсан хамт олон, бүлгүүдийн гишүүдийн Конвенцийн удирдах байгууллагуудын хуралдаанд оролцох зардлыг дэмжихэд хэрэглэгддэг байх.</p>

9. Энэ үзүүлэлт нь зөвхөн олон улсын хэмжээнд хяналт тавих, тайлагнахад хэрэглэгдэнэ.

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	1. Эрх бүхий байгууллагууд, институтууд болон зөвлөлдөх бүтцүүд СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахыг хэр зэрэг дэмжиж байгаа байдал	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, хянаж, тайлагнасан улсын-хэмжээний таван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	1.1 СББӨ-ийг хамгаалах нэг буюу хэд хэдэн эрх бүхий байгууллагыг томилсон эсвэл байгуулсан байна.	Зүйл 13(b) ҮАУ 154(a)
	1.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийн онцгой өвийн зүйлүүдийг хамгаалах эрх бүхий байгууллагууд ажиллаж байна.	Зүйл 13(b) ҮАУ 158(a), ҮАУ 162(d)
	1.3 Ялангуяа холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүс өргөнөөр хамрагддаг бүх нийтийн оролцоо бүхий СББӨ-ийн хамгаалалт, менежмент нь зөвлөлдөх байгууллага эсвэл бусад зохицуулалтын механизмаар дэмжигддэг байна.	ҮАУ 80
	1.4 СББӨ-ийг баримтжуулдаг институт, байгууллага болон/эсвэл санал санаачилгууд дэмжигддэг, мөн СББӨ-ийн оршин байх, өвлөн уламжлахад дэмжлэг үзүүлэх зорилгоор баримтжуулсан материалыг ашигладаг байна.	Зүйл 13(d)(iii)
	1.5 Соёлын төвүүд, мэргэжлийн төвүүд, эрдэм шинжилгээний институт, музей, архив, номын сан зэрэг байгууллагууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментэд хувь нэмэр оруулдаг болсон байна.	ҮАУ 79, ҮАУ 109

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь бүхэлдээ 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй уялдан нийцэж байна. СББӨ-ийг хамгаалахад олон нийтийн өргөн оролцоог зохицуулах албан ёсны байгууллагууд, эсвэл механизмүүдыг дэмжсэнээр Үнэлгээ хийх хүчин зүйл 1.3 нь 'бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаатай институтийг хэвшүүлэх' гэсэн ТХЗ-ын Зорилт 16.6-тай, мөн 'бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох' гэсэн Зорилт 16.7-той нийцэж байгаа болно.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэхүү үзүүлэлт нь институт, байгууллагын чадавхид төвлөрдөг бол Үзүүлэлт 2 нь хүний чадавхид төвлөрдөг. Энд ихэвчлэн төрийн байгууллагууд, эсвэл засгийн газрын дэмжлэгтэйгээр байгуулагдсан байгууллагуудыг хамруулах бол ТББ, олон нийтийн холбоод, хувийн хэвшлийн байгууллагуудын нэмэлт үйл ажиллагааг Үзүүлэлт 21-т хамруулан түсгасан болно. Судалгаа болон баримтжуулалтын үйл ажиллагаа, үр дүнг Үзүүлэлт 9, 10-ын хүрээнд авч хэлэлцэх бол энд голчлон байгууллагууд дээр

анхааран төвлөрөх юм. Үзлэг шалгалтын үйл ажиллагаанд оролцдог судалгаа, шинжилгээний байгууллагууд болон мэргэжлийн төвүүдийг Үзүүлэлт 22-т авч хэлэлцэх ба, харин эдгээр байгууллагууд болон төвүүдийн хоорон дахь олон улсын сүлжээний асуудлыг Үзүүлэлт 25-д авч үзэн үнэлэх юм.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Зүйл 13(b)-д Оролцогч улс нь СББӨ-ийг хамгаалж чадах нэг буюу хэд хэдэн эрх бүхий байгууллагыг байгуулах буюу томилох үүрэгтэй болохыг тодорхойлж өгсөн болно. Конвенцид ийм зохион байгуулалтын дэд бүтцийг СББӨ-ийг үр дүнтэй хамгаалах урьдчилсан нөхцөл гэж ойлгодог бөгөөд олон улс оронд ийм байгууллагуудад Конвенцийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх зорилго бүхий тодорхой үүргүүдийг даалгадаг. Энэхүү Конвенц нь хамт олон, бүлэг, хувь хүмүүсийг хамгаалалтын төвд байлгаж, бусад олон оролцогч талуудын оролцоог урьдчилан тооцдог тул улс орнууд ийм оролцоог зохицуулах нэмэлт байгууллага, механизмыг бий болгох нь ихэвчлэн ашигтай гэж үздэг. СББӨ-ийн хамгаалалтад үүрэг гүйцэтгэдэг байгууллага, эсвэл институтүүдэд соёлын төвүүд, мэргэжлийн төвүүд, музей, архив, номын сан болон СББӨ-ийг баримтжуулахад үүрэг гүйцэтгэж чадах бөгөөд мөн хамгаалах, удирдан зохион байгуулахад чухал үүрэгтэй оролцдог бусад эрдэм шинжилгээний байгууллагууд (Зүйл 13(d) (iii)) хамаарна.

Түлхүүр нэр томъёо

- Эрх бүхий байгууллагууд
- СББӨ-ийн зүйлүүд
- Бүртгэгдсэн (бүртгэгдсэн эсэхээс үл хамааран)
- Бүх нийтийн оролцоот / бүх нийтийг хамруулсан
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс
- Зөвлөлдөх байгууллага буюу зохицуулалтын механизм
- Мэргэжлийн төвүүд
- Судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус	Энэхүү үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь Оролцогч улсад СББӨ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын байршил, тархацыг харуулсан зураглал бий болгож, тогтолцооны дутагдал, доголдол, сүл талуудыг олж тогтоон шийдвэрлэхэд тусалдаг. Энэ нь одоо үйл ажиллагаагаа явуулж буй СББӨ-ийг хамгаалах эрх бүхий байгууллагууд нь бусад оролцогч талуудаас гаргаж буй СББӨ-ийг хамгаалах хүчин чармайлтыг үр дүнтэй дайчилж, уялдуулан зохицуулж чадаж байгаа эсэхийг үнэлэхэд тусална. Олон улсын хэмжээнд үзлэг шалгалт нь СББӨ-ийг хамгаалах тогтолцооны дэд бүтцийн ерөнхий байдлыг харуулж, үр дүнтэй болох нь батлагдсан зохицуулалтын механизмын сайн жишээ туршлагүүдийг санал болгож чадах юм.
------------------------------------	---

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах	Ихэнх тохиолдолд үзлэг шалгалт хийх болон тайлагнах асуудал хариуцсан албыг эрхлүүлэхээр үндэсний хэмжээнд СББӨ-ийг хамгаалах болон 2003 оны Конвенцийн хэрэгжилтийг зохицуулах эрх бүхий байгууллагыг томилдог бөгөөд ийм байгууллага нь энд дурдсан үндсэн байгууллагууд, институтууд, механизмүүдийн талаарх бодит мэдээлэл авах, түүнд нэвтрэх боломжтой байдаг. Төрийн бусад байгууллагууд, үндэсний байгууллагууд нь уг эрх бүхий байгууллагатай байнга хамтран ажилладаг түншүүд байх бөгөөд, үүнд соёлоос бусад салбар дахь байгууллагууд мөн хамаарна. Түүнчлэн аймаг, орон нутгийн байгууллагуудын бүртгэлийг тооцож үзэх нь чухал байх ба үүний тулд одоо хэрэглэгдэж буй сүлжээг ашиглах шаардлагатай болдог. Ялангуяа Үнэлгээ хийх хүчин зүйл 1.2 болон СББӨ-ийн онцгой өвийн зүйлүүдийг хамгаалах эрх бүхий байгууллагуудын хувьд Оролцогч улс нь орон нутгийн түвшинд юу болж байгаад үзлэг шалгалт хийхийн тулд тогтмол судалгаа хийх шаардлага гарч болох юм. Хэрэв нөлөө бүхий зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизм байгаа тохиолдолд энэ мэт олон түвшний үзлэг шалгалт хийх нь илүү үр дүнтэй байна.
--	--

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Албан ёсны сонин / сэтгүүл эсвэл хууль, эрх зүйн зохицуулалтын эмхэтгэл
- Соёлын салбар дахь төрийн байгууллага, өвийн институтүүдийн жилийн төсөв, ажлын төлөвлөгөө, тайлан
- Үндэсний хэмжээний зөвлөлдөх байгууллагуудын жилийн тайлан, хурлын тэмдэглэл
- Үндэсний жагсаалт эсвэл ЮНЕСКО-ийн аль нэг жагсаалтад бүртгэгдсэн өвийн зүйлийн талаар Оролцогч улсаас гаргаж өгсөн хугацаат тайлан
- Соёлын байгууллага, өвийн институтүүдийн лавлах, цахим хуудас

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	2. Хөтөлбөрүүд нь СББӨ-ийг хамгаалахад чиглэсэн хүний чадвар, чадавхийг бэхжүүлэхэд хэр зэрэг дэмжлэг үзүүлж байгаа байдал	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	2.1 Дээд боловсрол эзэмшүүлэх институт, байгууллагууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чиглэлээр бүх нийтэд зориулсан сургалт явуулдаг, мэргэжлийн зэрэг олгодог байна.	Зүйл 14(a)(iii) ҮАУ 107(k)
	2.2 Төрийн байгууллагууд, төвүүд болон бусад байгууллагууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн талаар бүх нийтэд зориулсан сургалт явуулдаг байна.	Зүйл 14(a)(iii)
	2.3 Хамт олон, ТББ-д түшиглэсэн санаачилгууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чиглэлээр бүх нийтэд хүртээмжтэй байдлаар сургалт явуулдаг байна.	Зүйл 14(a)(iii)

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь бүхэлдээ 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй уялдан нийцэж байна. Хэрэв хөгжиж буй Оролцогч улс нь чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлт гарган олон улсын дэмжлэгийг авч түүнээс ашиг тус хүртвэл уг үзүүлэлт нь ТХЗ-ын Зорилт 17.9-ийг хангахад мөн дэмжлэг үзүүлэх юм. Энэ зорилт нь ТХЗ-уудын үндэсний хэрэгжилтийг бататгахын тулд ' хөгжиж буй орнуудад үр дүнтэй, зорилтот чадавхи бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон улсын дэмжлэгийг нэмэгдүүлэхэд' анхааран төвлөрдөг. Энэ үзүүлэлт нь ТХЗ-ын суралцагчдад 'тогтвортой хөгжлийг хөхүүлэн дэмжихэд шаардлагатай мэдлэг, үр чадварыг олгох ... [тодруулбал] тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгон үнэлэх' гэсэн агуулгатай Зорилт 4.7-г хэрэгжүүлэхэд мөн хувь нэмрээ оруулж байгаа болно.
--	--

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэ үзүүлэлт нь дунд сургуулийн дараах шатны СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чиглэлээрх мэргэшүүлэх сургалт, зэрэг олгохгүй байж болох богино хугацааны сургалтын боломжуудтай холбоотой бөгөөд ийм боломжуудын олон төрөл, хэлбэр хүртээмжтэй байхад анхаарлаа хандуулдаг. Үзүүлэлт 3 нь ийм сургалтын хөтөлбөрүүд зорилтот хүмүүстэй чиглэж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх асуудлыг хөнддөг. Үзүүлэлтүүд 4, 5, 6 нь ихэвчлэн СББӨ-ийн хамгаалалт, менежментэд бус харин СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахад төвлөрсөн, хүндэтгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн анхан, дунд сургуулийн шатны болон дунд сургуулийн дараах шатны хөтөлбөрүүдийг авч үздэг.

**Үйл ажиллагаа
явуулах
үндэслэл**

СББӨ-ийг хамгаалах чадавхийг бэхжүүлэх асуудал нь Оролцогч улсууд СББӨ-ийг хамгаалах талаар олон жилийн туршлагатай, эсвэл энэ ажлыг саяхнаас санаачлан хэрэгжүүлж эхэлж байгаагаас үл хамааран тэдний хувьд өнөөгийн хэрэгцээ, шаардлага нь болоод байна. Хүний чадавхийг бэхжүүлэх хэрэгцээг коллеж, их дээд сургуулиудын санал болгож буй академик сургалтаар шийдвэрлэх боломжтой боловч төрийн байгууллага, мөн төрийн бус болон хамт олны зэрэг олон төрлийн байгууллагуудаас санал болгож буй богино хугацааны сургалтаар хангаж бас болох юм. СББӨ-ийн хамгаалалт, менежментийн талаарх бүх төрлийн сургалт, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаанд хамт олон, бүлэг, хувь хүмүүсийг аль болох өргөн хүрээгээр хамруулахыг чухалчлан үзэж бүх нийтийн оролцоог хангах нь зайлшгүй хэрэгтэй юм (Зүйл 15).

**Түлхүүр нэр
томъёо**

- Бүх нийтийн оролцоот / бүх нийтийг хамруулсан
- Сургалт
- Төрийн бус / Хамт олонд түшиглэсэн байгууллагууд
- Чадавхийг бэхжүүлэх
- Дээд боловсрол

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

**Үзлэг шалгалт
хийх ашиг тус**

Сургалтын хөтөлбөрүүд болон сургалтын институтуудыг бүхэлд нь авч үзэх нь СББӨ-ийн менежментэд хамаатай чадавхийг бэхжүүлэх эрэлт хэрэгцээний хэр хэмжээ болон цар хүрээг Оролцогч улсад ойлгоход тусалж чадах юм. Энэ нь одоогоор ямар хэрэгцээ шаардлагыг хангаж байгааг үнэлэхэд тусалж, дунд болон урт хугацаанд арилгах доголдол, сул талыг тодорхойлж, улмаар төрөөс боловсон хүчин, хүмүүсийг сургалтын зохих боломж, нөөц бололцоог ашиглах боломжоор хангах юм. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийж, тайлагнаж байх нь олон улсын хамтын ажиллагааны боломж бололцоог тодруулж өгөх бөгөөд үүнд боловсон хүчнүүд гадны улс орнуудад сургалтанд хамрагдах боломжийг ашиглах боломжтой болно. Ингэснээр ЮНЕСКО болон түүний харьяа түнш байгууллагууд, институтууд хамтран дэлхийн хэмжээний чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрөөр дамжуулж сургалтын доголдол болон сул талуудыг тодорхойлж, мөн арилгаж чадах юм.

**Мэдээллийн
эх сурвалж
ба мэдээлэл
цуглуулах**

Боловсролын яам эсвэл дээд боловсролын асуудал хариуцсан яам нь СББӨ-ийн тодорхой чиглэлээр мэргэжлийн зэрэг, мөн итгэмжлэгдсэн хөтөлбөрийн эрх олгох үүрэг хүлээдэг бөгөөд хэрэв тийм бол хаанаас ийм хөтөлбөр санал болгож буй талаарх мэдээллийг хадгалж байх боломжтой (Үнэлгээ хийх хүчин зүйл 2.1). Хэрэв Оролцогч улс нь зөвлөлдөх байгууллага эсвэл хамтын ажиллагааны механизмтай бол (Үзүүлэлт 1-ийг үзнэ үү) төрийн байгууллагууд (Үнэлгээ хийх хүчин зүйл 2.2) эсвэл төрийн бус байгууллагууд, хамт олноос санал болгож байгаагаас үл хамааран боломжит сургалтуудын талаарх мэдээллийг цуглуулж, цааш нь түгээж байж болох юм (Үнэлгээ хийх хүчин зүйл 2.3).

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Боловсролын яам эсвэл Дээд боловсролын бүртгэл, мэдэгдэл
- Коллеж, их сургуулийн сургалтын хөтөлбөр, цахим хуудас
- Соёлын яам эсвэл СББӨ хариуцдаг бусад байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх стратеги
- Зориулалтын сургалтын байгууллага, төвүүд
- СББӨ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын цахим хуудас
- Сургалт, семинар болон бусад боломжит арга хэмээнүүдэд оролцох урилга, элсүүлэх зарлал, мэдэгдэл
- Тийм сургалт, семинарын үйл ажиллагааны талаар цацагдаж буй мэдээ, мэдээлэл
- ЮНЕСКО-ийн чадавхийг бэхжүүлэх төслүүдийн цахим хуудас

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	3. Хамт олон, бүлэг, хувь хүмүүс, мөн соёл болон өвийн чиглэлээр ажилладаг хүмүүс сургалтыг хэр зэрэг зохион байгуулж байгаа, эсвэл тэдний эрэлт сонирхолд аль хэр нийцүүлж байгаа байдал	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний хоёр хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Бүх үзүүлэлтүүдийн нэгэн адил энэ үзүүлэлт ч гэсэн 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй уялдан нийцэж байна. Хэрэв хөгжиж буй Оролцогч улс нь чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлт гарган олон улсын дэмжлэгийг авч түүнээс ашиг тус хүртвэл уг үзүүлэлт нь ТХЗ-ын Зорилт 17.9-ийг хангахад мөн дэмжлэг үзүүлж байгаа юм. Энэ зорилт нь ТХЗ-уудын үндэсний хэрэгжилтийг бэхжүүлэхийн тулд 'хөгжиж буй орнуудад үр дүнтэй, зорилтот чадавх бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон улсын дэмжлэгийг нэмэгдүүлэхэд' анхаарч төвлөрдөг. Үзүүлэлт 2-ын адил энэхүү үзүүлэлт нь ч ТХЗ-ын суралцагчдад 'тогтвортой хөгжлийг хөхүүлэн дэмжихэд шаардлагатай мэдлэг, үр чадварыг олгох ... [тодруулбал] тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгон үнэлэх' гэсэн агуулгатай Зорилт 4.7-г хэрэгжүүлэхэд мөн хувь нэмрээ оруулж байгаа болно.</p> <p>Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Үзүүлэлт 2 нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийг санал болгож буй институт, байгууллагад анхаарлаа төвлөрүүлдэг бол энэ үзүүлэлт нь тухайн хөтөлбөрт хамрагдсан хүмүүст төвлөрдөг. СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чадавхийг бэхжүүлэхэд гол анхаарлыг энд төвлөрүүлж байгаа учир нь энэ Үзүүлэлт СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахад хүндлэлтэй хандах асуудалтай шууд холбогдон хөндөж байгаагаараа Үзүүлэлт 4, 5, 6-аас ялгагдаж байна.</p>	

Үйл ажиллагаа явуулах үндэслэл	Конвенц нь холбогдох хамт олон, бүлэг хүмүүс (Зүйл 14(a)(ii)), СББӨ-ийн хамгаалалт, менежментэд мэргэжлийн оролцоотой хүмүүсийн (Зүйл 14(a)(iii)) аль алиных нь чадавхийг бэхжүүлэхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэжээ. Хэрэв хамт олон, бүлэг, хувь хүмүүс хамгаалалтад аль болох өргөнөөр хамрагдах, менежментэд аль болох идэвхтэйгээр оролцохыг (Зүйл 15) зорих тохиолдолд тэд одоогоор эзэмшээгүй байгаа мэргэжлийн үр чадвар, арга барилыг эзэмших шаардлагатай болно. Үүнтэй адил соёл болон соёлын өвийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд өөрсдийн ажлыг эрхлэн явуулах өргөн мэдлэг, туршлагатай байж болох ч СББӨ-ийн хамгаалалт, менежментэд тохирсон мэргэжлийн арга хандлагын талаар мэдлэг дутмаг байж болно. Чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоог хангах нь ерөнхий ач холбогдолтойг байнга санаж байхын зэрэгцээ СББӨ-ийг хамгаалахад оройлон оролцдог, дэмжигч төлөөлөгч нарыг түшиж байх нь зохистой байж болох юм.
Түлхүүр нэр томъёо	<ul style="list-style-type: none"> • Сургалт • Чадавхийг бэхжүүлэх • Хамт олон, бүлгүүд, эсвэл зарим тохиолдолд хувь хүмүүс • Бүх нийтийн оролцоот / бүх нийтийг хамруулсан

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус	<p>Үзүүлэлт 2 нь чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрүүдийн хүртээмжид анхаарч төвлөрдөг бол энэхүү үзүүлэлт дээрх хөтөлбөрүүд нь хэд хэдэн зорилтот бүлэг төлөөллүүдэд үр дүнтэй хүрч ажиллаж чадаж байгаа эсэх асуудлыг голлон анхаарна. Ийнхүү улсын хэмжээний үзлэг шалгалт хийснээр хөтөлбөрийг зохион байгуулж буй хүмүүс болон төрийн албан тушаалтнуудад (зарим тохиолдолд тэдэнд санхүүжилт олгож буй талуудад) тухайн хөтөлбөрүүд нь зорилтот төлөөллүүддээ хэр зэрэг хүрч байгаа болон өвийн зүйлд голлох үүрэгтэй оролцдог тодорхой төлөөлөгч нарын хэрэгцээ, шаардлагыг илүү бүрэн дүүрэн хангаж өгөхийн тулд аливаа шинэчлэл, тохируулгыг хийх шаардлагатай эсэхийг тодорхойлж өгдөг. Дэлхийн түвшинд үзлэг шалгалт хийх, тайлагнах нь чадавхийг бэхжүүлэх үйлчилгээг үр дүнтэй хүргэх сайн загвар, үлгэр жишээг олж тогтооход тусалж, бусад улс орнууд үр дүнтэй гэдгийг батлан харуулсан тийм арга хандлага, арга барилаас суралцахад нь тус болох юм.</p>
------------------------------------	--

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах	<p>Сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааг хүлээн авсан болон ач тусыг нь хүртсэн бүлэг, хүмүүсийн талаархи задлан ангилсан мэдээлэл нь боломжтой үед мэдээллийн чухал эх сурвалж болдог. Ийм мэдээллийг ихэвчлэн сургалтын хөтөлбөрийн дараа түншүүддээ болон олон нийтэд зориулан гаргаж ирүүлсэн тайлан мэдээллээс авч болно. Ийм тайлан нь сургалтад оролцогчид нь хамт олон, бүлгийн гишүүн (Үнэлгээ хийх хүчин зүйл 3.1) эсвэл соёл, өвийн чиглэлээр мэргэшсэн оролцогч аль нь болохыг тодорхойлж өгсөн байдаг (Үнэлгээ хийх хүчин зүйл 3.2). Бүх нийтийн оролцоог оролцогчдын нас, хүйс, хэл (хамаарах бол), үндэс угсаа зэрэг өгөгдлөөр ялган ангилсан мэдээллийн ачаар шалган мэдэх боломжтой. Боломжтой нөхцөлд сургалтанд оролцогчдыг дунд болон урт хугацаанд үзлэг шалгалтад хамруулж сургалтын хөтөлбөрөөс эзэмшин олж авсан үр чадвар, мэдлэгээ тэд хэр зэрэг ашиглаж байгааг шалгаж мэдэх боломжтой юм.</p>
--	--

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны төслийн тайлан, оролцогчдын жагсаалт
- Сургалтанд оролцогчдоос өгсөн үнэлгээ (сургалтын төгсгөлд, боломжтой бол дараа нь)
- ТББ, хамт олонд түшиглэсэн байгууллагуудаас цуглуулсан мэдээлэл
- Сургалт, семинарын үйл ажиллагааны талаар цацагдаж буй мэдээ, мэдээлэл
- Сургалт, Семинар, үйл ажиллагааны хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх
- Сургалтанд оролцогчдоос тодорхой сургалтаас эзэмшин олж авсан мэдлэг, үр чадвараа хэрхэн ашиглаж байгааг үнэлэх зорилгоор авсан судалгаа

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	4. Албан болон албан бус боловсрол нь СББӨ-ийн өвлөн уламжлалыг хэр зэрэг бэхжүүлж, харилцан хүндлэлийг дэмжиж байгаа байдал	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний дөрвөн хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	4.1 Өвлөн үйлдэгч ба өвлөн уламжлагч нар нь СББӨ-ийн боловсролын хөтөлбөрийг төлөвлөн боловсруулахад болон/ эсвэл өв уламжлалаа идэвхитэйгээр таниулах, өвлөн уламжлуулахад адил тэгш оролцдог байна.	ҮАУ 107(e)
	4.2 Хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн СББӨ-өө өвлөн уламжлахад хүлээн зөвшөөрөгдсөн дэг жаяг, арга хэлбэрийг сургадаг ба/ эсвэл бэхжүүлдэг, мөн албан ба албан бус боловсролын хөтөлбөрт тусган оруулдаг байна.	Зүйл 14(a)(i); Зүйл 14(a)(ii) ҮАУ 180 (a)(iii)
	4.3 Хамт олон, бүлэг, ТББ эсвэл соёлын өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын СББӨ, түүнийг өвлөн уламжлах үйл ажиллагааг бататгахтай холбоотой хэрэгжүүлж буй боловсролын хөтөлбөрүүд, хичээлээс гадуурхи үйл ажиллагаа нь хүртээмжтэй, дэмжигддэг байна.	ҮАУ 109
	4.4 Багш нарын сургалтын хөтөлбөр, албан бус боловсрол олгох сургалт эрхлэгчдэд зориулсан хөтөлбөрүүдэд СББӨ, түүнийг хадгалж хамгаалах асуудлыг боловсролын сургалтанд нэгтгэн тусгаж байх арга зүйг оруулж өгсөн байна.	Зүйл 14

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь, ялангуяа ‘тогтвортой хөгжилд соёлын олон төрөл болон соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгон үнэлэх’-тэй холбоотой боловсрол олгохыг хамарч байгаа тул ТХЗ-ын Зорилт 4.7-той нийцэж байна. Ерөнхий байдлаар энэ үзүүлэлт нь ‘дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах’ гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй мөн уялдаж байна.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Үзүүлэлт 4, 5, 6 нь бүгд СББӨ-ийг өвлөн уламжлах ба боловсрол олгохтой хамаатай боловч тус бүрдээ тодорхой нэг сэдвийг онцлон авч үздэг. Үзүүлэлт 4 нь албан болон албан бус боловсролыг авч хэлэлцэх бөгөөд СББӨ-ийн өвлөн уламжлалыг хэр зэрэг бэхжүүлж, харилцан хүндлэлийг дэмжиж байгаа байдал төвлөрнө. Үзүүлэлт 5 нь бага, дунд боловсрол, СББӨ нь сурах чадварыг хэрхэн бэхжүүлж чадах вэ гэдэгт анхаарлаа төвлөрүүлдэг бол Үзүүлэлт 6 нь дунд сургуулийн дараах шатны боловсрол, ялангуяа тухайн боловсрол нь СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлах байдлыг бэхжүүлэх, СББӨ-ийн нийгэмд эзлэх байр суурийг судлахыг зорьдог. Эдгээр гурван үзүүлэлтийг СББӨ-ийн талаар мэдлэг олж авахад бус харин түүний хамгаалалт, менежментийн үйл ажиллагаанд оролцогч хүмүүсийг сургахад төвлөрсөн

Үзүүлэлт 2, 3-аас ялган авч үзэх хэрэгтэй. Үзүүлэлт 12 нь боловсролын талаар баримтлах бодлоготой холбогддог бол энд хөтөлбөр, үйл ажиллагаанд онцлон анхаарна.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Конвенцид боловсрол нь Оролцогч улсын хувьд СББӨ-ийг улсын хэмжээнд хамгаалахад томоохон байр суурь эзэлдэг үүрэг хариуцлагын нэг юм. Зүйл 14(a)(i)-д олон нийт, ялангуяа залуу үеийнхэнд чиглэсэн боловсролын хөтөлбөрүүдийн ач холбогдлыг онцолж байдаг бол Зүйл 14(a)(ii)-д холбогдох хамт олон, бүлгүүдэд чиглэсэн боловсролын хөтөлбөрийг онцолдог. Мэдлэгийг өвлөн уламжлах албан бус арга хэлбэрийн хамаарлыг Зүйл 14(a)(iv)-д онцлон тэмдэглэдэг. Эдгээр үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд улс орнууд олон төрлийн бүтээлч боловсролын стратеги, арга хандлагыг боловсруулж байдаг. Олон төрлийн үйл ажиллагаа хичээлээс гадуур зохиогддог бөгөөд хүүхэд, насанд хүрэгчдийн аль алинд чиглэсэн байдаг. Эдгээрийг улс орны боловсролын системийн бүрэлдэхүүн хэсэг болгон дэмжих нь элбэг байна. Хамт олон, бүлгүүд, төрийн бус эсвэл бусад байгууллагуудын зүгээс ийм үйл ажиллагааг мөн эрхлэн явуулдаг байж болох ба энэ нь албан ёсны сургалтын хөтөлбөрт тусгагдаагүй байж болох юм. Ийм арга хандлага нь боловсролын тогтолцоог илүү өргөн хүрээнд бэхжүүлж чадах сургалтын шинэ арга зүйг санал болгож байж болох талтай. Ялангуяа өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагч нар ийм хөтөлбөрүүдийг боловсруулж, хүргэж түгээхэд оролцдог, мөн өөрсдийн зааж, сургах онцлог арга ухаанаа хэрэглэж байгаа тохиолдолд илүү үр нөлөөтэй байж болох билээ.

Түлхүүр нэр томъёо

- Албан ёсны боловсрол
- Албан бус боловсрол
- Өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагч
- Бүх нийтийн оролцоот / бүх нийтийг хамруулсан
- Хамт олон, бүлгүүд, эсвэл зарим тохиолдолд хувь хүмүүс
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаа
- Төрийн бус байгууллагууд
- Өвийн байгууллагууд
- Сургалт

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

Энэхүү үзүүлэлт нь Оролцогч улсад өөрийн нутаг дэвсгэр дэх боловсролын шинэлэг хөтөлбөр, стратегиудыг олж тодорхойлох, ажиглаж хянаж байхад тусалж чадна. Төрөл бүрийн санаачилга, түүний үр дүнгийн талаарх нэгдсэн тойм мэдээлэлтэй байх нь төрөөс үр дүнтэй арга хандлага, үлгэр жишээ загваруудыг олж тодорхойлоход тусалж, хараахан нэвтрүүлж амжаагүй байгаа газруудад уг арга хандлагыг нэвтрүүлэх боломжийг зааж өгч болох билээ. Үзлэг шалгалт нь одоогийн үйлчилгээн дэх дагалдах дутагдлыг илрүүлж өгч, цаашдын үйл ажиллагааны талаар мэдээлэхэд мөн тусална. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийж мэдээлж байх нь улс орнуудад амжилттай хэрэгжсэн эсвэл бүтэлгүйтсэн нь нотлогдсон боловсролын хөтөлбөрүүдийн талаар түршлага солилцоход тусалдаг. Ингэхдээ улс орнууд өөрсдийн нөхцөл байдалд нийцүүлэн өөрийн оронд аль арга хандлага нь хамгийн сайн тохирохыг илүү сайн тодорхойлж чадах билээ.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Үзлэг шалгалт хийх, тайлан гаргах үүрэг бүхий хүмүүс Боловсролын яам (Үнэлгээ хийх хүчин зүйл 4.1, 4.2 ба 4.3-ийн хувьд) болон Дээд боловсролын асуудал хариуцсан яам (Үнэлгээ хийх хүчин зүйл 4.4-ийн хувьд)-ны тухайн асуудал эрхэлсэн мэргэжилтэн, газруудтай нягт хамтран ажиллахыг эрмэлзэх нь зүйтэй. Боловсролын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, эсвэл багш бэлтгэх байгууллагууд хөтөлбөр боловсруулах, заах арга зүйн талаар судалгаа хийж, үр дүнг үнэлэх, үзлэг шалгалт явуулах ажлыг хариуцаж байж болно. Багш, албан бус боловсролын сурган хүмүүжүүлэгчдийг сургаж бэлтгэх хөтөлбөрийг ихэвчлэн Дээд боловсролын асуудал эрхэлсэн яамны удирдлага дор багш бэлтгэх байгууллагууд эрхлэн ажиллуулдаг бөгөөд сургалтын хөтөлбөр, арга барил нь нээлттэй хүртээмжтэй байх нь зүйтэй.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Боловсролын сургалтын хөтөлбөр эсвэл сургалтын стандарт
- Багш бэлтгэх байгууллагуудын сургалтын хөтөлбөр, хичээлийн жагсаалт
- Боловсролын болон Дээд боловсролын асуудал эрхэлсэн яамдын хугацаат үзлэг шалгалт болон тайлан
- Боловсролын статистик мэдээлэл, судалгаа, үнэлгээ, боловсролын ололт амжилтын талаарх жилийн эсвэл хугацаат тайлан
- ТХЗ 4, ялангуяа Зорилт 4.7-ийн талаарх тайлан мэдээ
- Боловсролын хөтөлбөр боловсруулах, сурган хүмүүжүүлэх арга барил, хандлагын талаарх судалгааны үр дүн

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	5. СББӨ болон түүний хамгаалалтын асуудлыг бага болон дунд боловсролын хөтөлбөрт хэр зэрэг нэгтгэсэн, тохиромжтой хичээлүүдэд хэр зэрэг тусгасан, мөн СББӨ-ийн тухай өөрийн болон бусдын СББӨ-ийг хүндэтгэх талаар зааж сургах явдал хэр зэрэг тогтмол болсон байдал
-----------------	---

Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний дөрвөн хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	5.1 СББӨ, түүний олон төрөл нь холбогдох мэргэжлийн хичээлүүдийн агуулгад тусгагдсан байна. Энэ нь тухайн хичээлийн агуулгад хувь нэмэр оруулсан буюу/эсвэл бусад сэдвүүдийг тайлбарлах, батлан харуулах арга хэрэгсэл болсон байна.	Зүйл 14(a)(i) ҮАУ 107, ҮАУ 180(a)(ii)
	5.2 Сургуулийн сурагчид нь боловсрол, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан өөрсдийн хамт олон, бүлгийн СББӨ болон бусдын СББӨ-ийг хүндэтгэж, харилцан тусган авч суралцдаг болсон байна.	Зүйл 14(a)(i) ҮАУ 105, ҮАУ 180(a)(i) ЁЗЗ 11
	5.3 Суралцагчдын эзэмшсэн СББӨ-ийн олон төрөл зүйл нь эх хэлээр эсвэл олон хэлээр сургалт явуулах, ба/эсвэл "нутгийн агуулга"-ыг боловсролын хөтөлбөрт оруулах замаар биеллээ олсон байна.	ҮАУ 107
	5.4 Боловсролын хөтөлбөрүүд нь СББӨ-ийг илэрхийлэхэд шаардлагатай байгалийн болон соёлын орон зай, дурсгалт газруудыг хамгаалах талаар заадаг болсон байна.	Зүйл 14(c) ҮАУ 155(e), ҮАУ 180(d) ЁЗЗ 5

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь, ялангуяа 'тогтвортой хөгжилд соёлын олон төрөл болон соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгон үнэлэх'-тэй холбоотой боловсрол олгохыг хамарч байгаа тул ТХЗ-ын Зорилт 4.7-той нийцэж байна. Энэ нь 'тогтвортой хөгжил, байгаль дэлхийтэйгээ зохицон амьдрах амьдралын хэв маяг'-ийг бий болгохыг зорьсон боловсролыг олгох тухай онцолж байгаа тул ТХЗ-ын Зорилт 12.8-тай уялдан нийцэж, үүгээрээ дэлхийн байгаль, соёлын өвийг хамгаалахад хувь нэмрээ оруулж байгаагийн хувьд ТХЗ-ын Зорилт 11.4-тэй мөн холбогдож байна.</p> <p>Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэ үзүүлэлт нь Зүйл 14-ийн бага болон дунд шатны боловсрол, ялангуяа өөрийн болон бусдын СББӨ-ийг ойлгон мэдэх, хүндэтгэхийг дэмжих тухай заалтуудад анхааран төвлөрдөг. Удиртгалд дурдсанчлан энэ үзүүлэлт нь соёлын олон төрөл, тогтвортой хөгжлийг дэмжихэд гүйцэтгэх СББӨ-ийн үүргийн өргөн агуулгатай мөн холбогдож байна. Тиймээс энэ үзүүлэлт СББӨ-ийн хөдөлгөгч гол хүч болох хэлний ач холбогдол болон СББӨ нь өөрөө сургалтын тусгайлсан агуулга, арга зүйгээр хангах чадвартай болохыг хүлээн зөвшөөрдөг. Үзүүлэлт 4 нь харьцуулж үзэхэд СББӨ-ийн</p>
--	--

	өвлөн уламжлалыг бэхжүүлэхэд албан болон албан бус боловсролыг хэрхэн ашиглаж болох вэ гэдэгт түлхүү төвлөрч байгаа бол Үзүүлэлт 6 нь дунд сургуулийн дараах шатны боловсролд анхаарлаа төвлөрүүлж байна. СББӨ ба боловсролын талаарх хууль тогтоомж, бодлогыг Үзүүлэлт 12-т тусгасан болно. Тогтсон хугацаанд явагддаг үйл ажиллагаа буюу чадавхийг бэхжүүлэх семинар зэрэг СББӨ-ийн хамгаалалт, менежментийн сургалтын боломжууд нь Үзүүлэлт 2 ба 3-ын анхаарлын төвд байна.
--	--

Үйл ажиллагаа явуулах үндэслэл	Зүйл 14-т Оролцогч улсуудыг хүн ам, ялангуяа залуу хүмүүст СББӨ гэж юу болох, яагаад үүнийг хамгаалах нь чухал болохыг зааж сургахыг уриалан дууддаг. Үүнд СББӨ-ийг илэрхийлэхэд шаардлагатай байгалийн болон соёлын орон зай, дурсгалт газруудыг хамгаалах хэрэгцээ шаардлага орно. Олон улс оронд ийм хүчин чармайлт гаргахад анхан, дунд шатны боловсролын тогтолцоо хамгийн чухал нөхцөл нь болдог. Энэ чиглэлээр хэрэгжүүлж болох арга хэмжээнүүд нь оюутан сурагчдын СББӨ болон бусдын СББӨ-ийг хамт зааж, сургахад оршдог. Ингэснээрээ сурган хүмүүжүүлэгчид СББӨ-ийг хүндлэх, оюутан суралцагчдынхаа харилцан хүндлэлийг бий болгон дэмжиж чадна. Математик, байгалийн ухаан, уран зохиол зэрэг бусад хичээлийг заах, суралцахад СББӨ-ийн агуулга, арга зүйг ашигласнаар сургуулиуд СББӨ-ийн ач холбогдлыг өдөр тутмын амьдралд онцлон тэмдэглэж, сурагчдын сонирхлыг төрүүлж, хамгаалалтыг хөхүүлэн дэмжих боломжтой болохын хамт сургалтыг илүү сонирхолтой, хүртээмжтэй болгож байгаа нь туршлагаас харагдаж байна.
---------------------------------------	--

Түлхүүр нэ томъёо	<ul style="list-style-type: none"> ● Албан ёсны боловсрол ● СББӨ-ийг хүндэтгэх ● Эх хэлний боловсрол ● Олон хэлний боловсрол ● Нутгийн агуулга ● Дурсгалт газрууд ● Анхан шатны боловсрол ● Дунд шатны боловсрол
--------------------------	--

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

Улсын хэмжээнд хийсэн үзлэг шалгалт нь тухайн улс СББӨ-ийн хүндэтгэл, ойлголтыг баталгаажуулах, мөн сургалтын үр нөлөөг сайжруулахад үр дүнтэй байгааг нотлон харуулсан боловсролын арга хандлага, арга зүйн давуу талыг хэрхэн бүрэн дүүрэн ашиглаж чадаж байгааг тодорхойлоход тусална. Энэ нь залуу хүмүүсийн дунд өөрсдийн болон бусдын бүлэг хамт олны хоорондох харилцан хүндлэлийг улам өргөхөд тус дэм болно. Дэлхийн хэмжээний үзлэг шалгалт нь ийм хандлага, арга зүйг бэхжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, олон улсын түвшинд түршлага солилцох боломжийг тодорхойлоход тусалдаг.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Үзүүлэлт 5 нь анхан болон дунд шатан дахь албан боловсролд анхаарал төвлөрүүлдэг. Аливаа улс орон СББӨ-ийн удирдлагууд болон Боловсролын яамны зөвшилцөлд үзлэг шалгалт хийж, тайлагнах шаардлагатай. Энэхүү мэдээллийг Боловсролын яамны тогтмол хийдэг үзлэг шалгалтын үр дүнгээс олж авах боломжтой юм. Тогтвортой хөгжлийн боловсрол, дэлхийн иргэний боловсрол, уугуул иргэдийн боловсрол, эх хэлний боловсрол, олон хэлний боловсрол, соёл хоорондын боловсрол, хамт олны боловсрол зэрэг соёлын биет бус өвийг боловсролын салбарт нэгтгэхтэй холбоотой мэдээллийн эх сурвалжуудтай холбогдож зөвлөлдөх нь зүйтэй. Тодруулбал, ТХЗ-ын Зорилт 4.7 ба 12.8-д үзлэг шалгалт хийх зорилгоор цуглуулсан мэдээлэл энд хамаарч болох юм.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Сургалтын зорилтууд ба хүлээж буй үр дүн бүхий үндэсний болон орон нутгийн хэмжээний боловсролын хөтөлбөрүүд
- Боловсролын статистик мэдээлэл, судалгаа, үнэлгээ, боловсролын ололт амжилтын талаарх жилийн эсвэл хугацаат тайлан
- Боловсрол дахь ялгаварлан гадуурхах явдлын эсрэг зөвлөмж болон 1960 оны Конвенцийн хэрэгжилтийн талаар, ялангуяа боловсролын цөөнхийн хэлний талаар ЮНЕСКО-д гаргаж өгсөн Оролцогч улсын тайлан
- Хүний эрх, үндсэн эрх чөлөөнд хамаарах олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, энх тайван, боловсролын талаархи 1974 оны Зөвлөмжийн хэрэгжилтийн талаар ЮНЕСКО-д гаргаж өгсөн Оролцогч улсын тайлан
- 1966 оны Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар НҮЭЭНЗ-д гаргаж өгсөн Оролцогч улсын тайлан
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагад 169 дүгээр Конвенцийн хэрэгжилт, ялангуяа VI хэсэг, Боловсрол, харилцаа холбооны хэрэгслүүдийн талаар гаргаж өгсөн Оролцогч улсын тайлан

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт

6. Дунд сургуулийн дараах шатны боловсролд СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахыг, мөн түүний нийгэм, соёл болон бусад ач холбогдлын судалгааг хэр зэрэг дэмжиж байгаа байдал

Үнэлгээ хийх хүчин зүйлүүд

Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний хоёр хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:

6.1 Дунд сургуулийн дараах шатны боловсролын байгууллага нь СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахыг бататгадаг тийм сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж мэргэжлийн зэрэг (хөгжим, урлаг, гар урлал, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт гэх мэт) олгодог болсон байна.	Зүйл 14
6.2 Дунд сургуулийн дараах шатны боловсролын байгууллага нь СББӨ, түүний нийгэм, соёлын болон бусад ач холбогдол, хүрээг судалдаг сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, мэргэжлийн зэрэг олгодог болсон байна.	Зүйл 14

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахыг онцлон тэмдэглэж байгаагаараа 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-т хувь нэмэр оруулж байна. Энэ үзүүлэлт нь, ялангуяа СББӨ-ийн нийгэм, соёлын болон бусад ач холбогдлыг судалж байгаа нь 'тогтвортой хөгжилд соёлын олон төрөл болон соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгон үнэлэх' гэсэн ТХЗ-ын Зорилт 4.7-г хөхүүлэн дэмжиж байна. Бүгдэд зориулсан үр бүтээлтэй ажлын байр, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж буй ТХЗ-ын Зорилт 8 зэрэг бусад зорилгуудад, ялангуяа ТХЗ-ын Зорилт 8.9-д оруулж буй хувь нэмэр нь энэ үзүүлэлтэд хамаарч байна.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэ үзүүлэлт нь СББӨ-ийн үр чадвар, мэдлэгийг өвлөн уламжлах, эсвэл СББӨ-ийн талаар нийгэмд мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх талбар бүхий дунд шатны боловсролд төвлөрнө. Үзүүлэлт 4-тэй адил СББӨ-ийг өвлөн үйлдэх, өвлөн уламжлуулахтай холбоотой боловч энэхүү үзүүлэлтэд дээд боловсролыг онцгойлон авч үзнэ. Түүнчлэн, энэ Үзүүлэлт нь Үзүүлэлт 5-ын анхан, дунд шатны боловсролд анхаарал төвлөрүүлснийг дэмжихийн хамт дээд боловсролд бас төвлөрч байна. Нийгэм дэх СББӨ-ийг судлах хөтөлбөрийг (Үнэлгээ хийх хүчин зүйл 6.2) ихэвчлэн СББӨ-ийн хамгаалалт, менежментийн үр чадварыг бэхжүүлэх хөтөлбөртэй хослуулдаг (Үнэлгээ хийх хүчин зүйл 2.1). Боловсролын талаар баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээний талаар Үзүүлэлт 12-т авч үзнэ.

**Үйл ажиллагаа
явуулах
үндэслэл**

Конвенцийн 14-р зүйлд зөвхөн анхан, дунд шатны боловсрол эзэмшиж буй сурагчдыг хамруулаад зогсохгүй мөн дээд боловсролыг ч оруулан авч үздэг. Зарим улс оронд СББӨ-ийг өвлөн үйлдэхэд хэрэглэдэг мэдлэг, ур чадварыг Урлагийн академи, хөгжим, бүжгийн консерваторууд болон үүнтэй адил төстэй дунд сургуулийн дараах шатны сургалтын байгууллагуудын сургалтын хөтөлбөртэй нэгтгэсэн байдаг. Түүнчлэн техникийн болон мэргэжлийн сургууль, төвүүд нь дунд болон дунд сургуулийн дараах шатны алинд ч бай СББӨ-ийн төрөл бүрийн айн ангилал болон салбар (гар урлал, язгуур урлаг гэх мэт)-ын хүрээнд нэн чухал сургалтуудыг явуулж байдаг. Олон улс оронд дунд шатны боловсролын дараахь хөтөлбөрүүдэд антропологи, түүх, социологи, соёл судлал, ардын аман зохиол судлал болон бусад холбогдох хичээлүүдээр СББӨ-ийг судалж байдаг. Сүүлийнх нь ихэвчлэн СББӨ-ийн хамгаалалт, менежментийн судалгаатай холбогдож байдаг.

**Түлхүүр нэр
томъёо**

- Албан боловсрол
- Сургалт
- Дунд боловсролын дараах шатны боловсрол
- Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

**Үзлэг шалгалт
хийх ашиг тус**

СББӨ-ийн хамаатай дунд шатны боловсролын хөтөлбөрийн хүртээмж болон хэрэглээнд улсын хэмжээний үзлэг шалгалт хийж байх нь СББӨ-ийг өвлөн үйлдэх, өвлөн уламжлах явдлыг бататган бэхжүүлэх эх үүсвэр болсон дээд боловсролын давуу талыг хэр зэрэг ашиглаж байгааг үнэлэхэд нь Оролцогч улсад тус болно. Энэ нь дээд боловсрол СББӨ-ийн талаарх мэдлэг, түүний нийгэм, соёлын болон бусад ач холбогдлыг хэр зэрэг гүнзгийрүүлж байгааг үнэлэхэд мөн тусална. Үзлэг шалгалт хийж байх нь боловсролын байгууллагуудыг өргөн хүрээгээр хамруулах замаар тийм төрлийн боловсролыг бэхжүүлэх, мөн СББӨ-ийг урлагийн, техникийн болон мэргэжлийн сургалтанд илүү нэгтгэх боломжийг олж тодорхойлоход бас дэмжлэг болно. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийхээр зарим улс орнуудад аль хэдийнээс хэрэглэгдэж байгаа сайн туршлагыг олж тогтоож чадах бөгөөд судалгаа, сургалтын хөтөлбөр боловсруулах, сурган хүмүүжүүлэх арга зүйн чиглэлээрх олон улсын хамтын ажиллагаа нь улс тус бүрийн чадавхийг хэрхэн бэхжүүлж болохыг харуулж байдаг юм.

**Мэдээллийн
эх сурвалж
ба мэдээлэл
цуглуулах**

Боловсролын Яам юмуу, дээд боловсролын асуудал эрхэлсэн яам нь ихэвчлэн дунд сургуулийн дараах шатны боловсролын байгууллагуудын статистик болон бусад мэдээллийг хадгалж хөтөлдөг. Зарим тохиолдолд цол, зэрэг олгох хөтөлбөрийг ийм яамнаас зөвшөөрөл олгосон байх ёстой бөгөөд тэдэнд аль байгууллага ямар чиглэлээр ямар зэрэг олгож байгаа талаарх бэлэн мэдээлэл байж болно. Ийм тогтолцоо байхгүй тохиолдолд үзлэг шалгалт хийх, тайлагнах үүрэг бүхий хүмүүс нь боловсролын байгууллага, сургалтын төвүүдээс судалгаа авах, эсвэл тэдний цахим хуудсуудаар орж холбогдох зэрэг, сургалтын хөтөлбөр санал болгож буй эсэх талаар мэдээлэл цуглуулах шаардлагатай.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Боловсролын яам эсвэл дээд боловсролын асуудал эрхэлсэн яамнаас дунд сургуулийн дараах шатны янз бүрийн байгууллагаас олгодог зөвшөөрөгдсөн мэргэжлийн зэрэгтэй холбоотой тайлан, мэдээлэл
- Дунд сургуулийн дараах шатны боловсролын байгууллагуудын цахим хуудсууд, сургалтын хөтөлбөр, олгох мэргэжлийн зэрэг бүхий жагсаалт
- Холбогдох салбар дахь мэргэжлийн холбоод, лавлахууд
- Урлагийн болон шинжлэх ухааны холбогдох салбар дахь мэргэжлийн сүлжээ

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	7. Бүртгэл-мэдээлэл нь СББӨ-ийн олон төрлийг тусгах, түүнийг хамгаалахад хэр зэрэг хувь нэмэр оруулж байгаа байдал	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний дөрвөн хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	7.1 СББӨ-ийн олон төрлийг хамгаалах болон тусган харуулахад чиглэсэн бүртгэл-мэдээллийн нэг ба хэд хэдэн тогтолцоог бий болгож ажиллуулсан, түүнийг баталгаажуулснаас хойш шинэчлэн сайжруулсан байна.	Зүйл 11, 12 УАҮ 1, УАҮ 2
	7.2 Тусгай зориулалтын бүртгэл-мэдээлэл ба/эсвэл янз бүрийн хүрээг хамарсан бүртгэл-мэдээлэл нь СББӨ-ийн олон төрлийг тусган харуулж, түүнийг хамгаалахад хувь нэмэр оруулдаг болсон байна.	Зүйл 12
	7.3 Одоо байгаа бүртгэл-мэдээлэл эсвэл бүртгэл-мэдээллүүдийг тайлагнах хугацаанд баяжуулж сайжруулсан, ялангуяа тухайн бүртгэл-мэдээлэлд орсон өвийн зүйлүүдийн одоогийн оршин байх чадварыг тусган харуулсан байна.	Зүйл 12 УАҮ 1, УАҮ 2
	7.4 СББӨ-ийн зарим зүйлийг үзэж танилцахад дагаж мөрддөг онцлог уламжлал, зан үйлд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ СББӨ-ийн бүртгэл-мэдээллийг нийтэд хүртээмжтэй байх нөхцлийг бүрдүүлэх, хамгаалалтыг бэхжүүлэх зорилгоор түүнийг ашигладаг болсон байна.	Зүйл 13(d)(ii) УАҮ 85

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): СББӨ-ийн бүртгэл-мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгоход чиглэсэн энэхүү үзүүлэлт нь ‘Үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн олон нийтийг мэдээлэл олж авах боломжоор хангах, үндсэн эрх чөлөөг хамгаалах’ гэсэн ТХЗ-ын Зорилт 16.10-г дэмжиж байна. Бусад үзүүлэлтүүдийн нэгэн адил ‘дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах’ гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй мөн нийцэж байна.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Үзүүлэлтүүд 7 ба 8 нь бүртгэл-мэдээллийн үйл ажиллагаатай хамаатай бол Үзүүлэлт 9 ба 10 нь судалгаа, баримтжуулалтыг хөндөн авч үздэг. Тэрчлэн бүртгэл-мэдээлэл нь ихэвчлэн судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг багтааж нэг буюу хэд хэдэн хэлбэрийн баримт материалын үр дүнг бий болгодог учир эдгээр үзүүлэлтүүд нь өөр хоорондоо уялдаатай байна. Энд бүртгэл-мэдээллийн бүтээгдэхүүн, бүртгэлжүүлэлт, тэдгээрийг СББӨ-ийн хамгаалалтад хувь нэмэр оруулахад хэрхэн ашиглаж байгаа талаар гол анхаарлаа хандуулдаг. Үзүүлэлт 8 нь бүртгэл-мэдээлэл хийх үйл явц, түүний хүртээмжтэй байдалд анхаарлаа төвлөрүүлдэг. Үзүүлэлт 9 нь хамрах хүрээг өргөжүүлж, бүртгэл-мэдээллээс гадуур хийх шаардлагатай бусад судалгааны хэлбэрийг

	онцлон авч үздэг бол Үзүүлэлт 10 нь бүртгэл-мэдээллээс бусад судалгааны үр дүн хүртээмжтэй байх тал дээр анхаарал хандуулж байгаагаараа Үнэлгээ хийх хүчин зүйл 7.4-ийг нөхөж байгаа болно.
Үйл ажиллагаа явуулах үндэслэл	Бүртгэл-мэдээлэл нь Оролцогч улс бүрийн хувьд үндсэн үүрэг хариуцлага мөн бөгөөд Зүйл 11(b)-д Оролцогч улс ‘хамт олон, бүлэг болон төрийн бус холбогдох байгууллагуудын оролцоотойгоор өөрийн нутаг дэвсгэр дээрх соёлын биет бус өвийн төрөл зүйлийг таньж тогтоон тодорхойлно’ гэсэн шаардлагыг тусгасан байдаг. Мөн цаашлаад Зүйл 12.1-д ‘Оролцогч Улс бүр соёлын биет бус өвийг хамгаалах зорилгоор түүнийг таньж тогтоохдоо тухайн нөхцөл байдлаас шалтгаалж нутаг дэвсгэртээ байгаа соёлын биет бус өвийн нэг буюу хэд хэдэн бүртгэлийг хөтөлнө. Тухайн бүртгэлийг тогтмол шинэчилж байна.’ гэж дэлгэрүүлэн тусгажээ. Оролцогч улсууд цаашид өвийн зүйлийг уламжлалт тогтсон журмыг хүндэлж мөрдсөний үндсэн дээр үзэж танилцах явдлыг хангаж ажиллахыг эрхэмлэх нь зүйтэй (Зүйл 13(d)(ii)).
Түлхүүр нэ томъёо	<ul style="list-style-type: none"> • Бүртгэл-мэдээлэл • Олон төрөл (СББӨ ба түүнийг өвлөн үйлдэгч нарын) • Оршин амьдрах чадвар • СББӨ-ийн зүйлүүд • Уламжлалт зан үйл • Ай (СББӨ-ийн) • Үзэж танилцах боломж • Захиалгын зарчим • Бүртгэх шалгуур үзүүлэлтүүд • Тусгай төрөлжсөн бүртгэл-мэдээлэл

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

‘Энэхүү Конвенцийн хүрээнд авч хэрэгжүүлсэн хууль зүй, зохицуулалтын болон бусад арга хэмжээний тухай’ (Зүйл 29) тайлагнах ерөнхий шаардлагаас гадна Оролцогч улсуудаас ‘бүртгэл-мэдээллийнхээ талаар холбогдох мэдээллийг гаргаж өгч байхыг (Зүйл 12.2) тусгайлан хүсдэг билээ. Үзлэг шалгалт хийх нь Оролцогч улсад бүртгэл-мэдээллийн чиглэлээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэх, тайлант хугацаанд бүртгэл-мэдээллээ шинэчилсэн эсэхээ тодорхойлоход тусална. Ийм үзлэг шалгалт нь Оролцогч улсад төрөлжсөн эсвэл янз бүрийн цар хүрээний бүртгэл-мэдээлэл боловсруулж хөгжүүлэх замаар бүртгэл-мэдээллээ бэхжүүлэх нэмэлт боломжууд байгаа эсэхийг олж мэдэхэд тусална. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь шилдэг сайн туршлагыг олж тогтоон, ялангуяа хамгаалалтыг сайжруулах зорилгоор бүртгэл-мэдээллийг ашиглах, улмаар улс хоорондын хамтын ажиллагааны болон техникийн туслалцаа үзүүлэх боломжийг илрүүлэхэд тусалж чадна.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Олон улс оронд Соёлын яам эсвэл бусад эрх бүхий байгууллага нь бүртгэл-мэдээллийн ажлыг өөрсдөө хариуцан хийж гүйцэтгэх эсвэл бусдын бүртгэл-мэдээллийн үйл ажиллагааг удирдан зохицуулах үүрэгтэй байдаг. Тэд бүртгэл-мэдээллийн шинэчлэлт, түүний нөхцөл байдлын талаар хамгийн сүүлийн үеийн тойм мэдээллийг хадгалж байдаг. Бүртгэл-мэдээлэлд СББӨ-ийг хамруулсан байх нь тухайн өвийн зүйлийг Яаралтай хамгаалах Жагсаалт эсвэл Төлөөллийн Жагсаалтад нэр дэвшүүлэх урьдчилсан нөхцөл болдог гэдгийг харгалзан Оролцогч улс эдгээр нэр дэвшүүлэх үйл явцад оролцож байгаа тохиолдолд бүртгэл-мэдээлэлд байгаа мэдээллийг авах боломжтой байна. Өмнө нь хүргүүлж байсан хугацаат тайлан нь бүртгэл-мэдээллийн талаар, ялангуяа Конвенцийн жагсаалтад хэдийнээ бүртгэгдсэн өвийн зүйлүүдийн талаархи үнэ цэнтэй мэдээллийг агүүлж байдаг. Хэрэв Оролцогч улс нь зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизмтай бол эдгээр нь мэргэжлийн байгууллагуудын хийж гүйцэтгэсэн эсвэл орон нутгийн түвшинд хийгдсэн бүртгэл-мэдээллийн ажлын талаарх мэдээллийн эх сурвалж болно.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Соёлын яам болон бусад бүртгэл-мэдээлэл хариуцсан эрх бүхий байгууллагын вэбсайт
- Бүртгэл-мэдээлэлд оролцдог төрөлжсөн мэргэжлийн байгууллагуудын вэбсайт
- Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад бүртгүүлэхээр бэлтгэсэн нэр дэвшүүлэх баримт материалууд
- Конвенцийн хэрэгжилт, Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөлөгчдийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн зүйлүүдийн төлөв байдлын талаарх өмнө нь хүргүүлж байсан тайлангууд
- Архивын байгууллага эсвэл бүртгэл-мэдээлэл эзэмшигч бусад байгууллагын нийтийн хүртээл болгох бодлого, журам

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт

8. Бүртгэл-мэдээллийн явц нь бүх нийтэд хүртээмжтэй, СББӨ-ийн олон төрөл, түүний өвлөн уламжлагчдыг хүндэтгэдэг, холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүс СББӨ-өө сахин хамгаалахыг дэмжиж байгаа байдал

Үнэлгээ хийх хүчин зүйлүүд

Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний хоёр хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:

8.1 Хамт олон, бүлгүүд, холбогдох ТББ-ууд нь бүртгэл-мэдээллийн ажилд өргөнөөр оролцдог бөгөөд энэ нь тэдний СББӨ-өө хамгаалах үйл ажиллагааг мэдээллээр хангах, бэхжүүлэхэд тус болдог байна.	Зүйл 11 YAU 1, YAU 2 ЁЗЗ 1, ЁЗЗ 6, ЁЗЗ 8, ЁЗЗ 10
8.2 Бүртгэл-мэдээллийн явцад СББӨ-ийн олон төрөл, түүнийг эзэмшин үйлдэгч нарыг хүндэтгэн үздэг байна. Ингэхдээ нийгмийн бүх давхарга, эрэгтэй, эмэгтэй болон бүх бүс нутгийн зан үйл, өвийн илэрхийллүүдийг хамруулдаг болсон байна.	Зүйл 11

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-т хувь нэмэр оруулдаг.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Бүртгэл-мэдээлэл, судалгаа хийхтэй холбоотой дөрвөн үзүүлэлт тус бүр нь (Үзүүлэлт 7-10) бусад үзүүлэлтүүдийг нэмэлт хэлбэрээр нөхөж байдаг. Энд бүртгэл-мэдээлэл нь бүх нийтийн оролцоотой байх болон хамгаалалахад хувь нэмэр оруулж байгаа эсэхээс үл хамааран бүртгэл-мэдээллийн ажлын явцын чанарт голлон анхаарч төвлөрч байдаг. Үзүүлэлт 7 нь бүртгэл-мэдээлэл нь шинэчлэгдсэн эсэх, бүх нийтийн оролцоог хангасан болон хүртээмжтэй байгаа эсэхээс үл хамааран бүртгэл-мэдээллийн бүтээгдэхүүнд анхаарч төвлөрдөг. Үзүүлэлт 9 ба 10 нь бүртгэл-мэдээллээс тусдаа бие дааж хийгдэж болох судалгаа, баримтжуулалтад төвлөрч анхаарна.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Үзүүлэлт 7-д тэмдэглэсэнээр, бүртгэл-мэдээлэл нь Оролцогч улс бүр ‘хамт олон, бүлэг болон холбогдох төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор өөрийн нутаг дэвсгэр дээрх соёлын биет бус өвийн төрөл зүйлийг таньж тогтоон тодорхойлно’ гэж шаардсан Зүйл 11(b)-д заасан Оролцогч улс бүрийн хүлээх үндсэн үүрэг хариуцлагын нэг юм. Зүйл 15-д СББӨ-ийн хамгаалалт, менежментэд хамт олон, бүлгүүд, шаардлагатай бол хувь хүмүүсийн оролцоог аль болох өргөнөөр хангахыг ерөнхийд нь дэмжиж, энд Конвенцоос бүртгэл-мэдээллийн үйл ажиллагаанд хамт олон, бүлгүүд, холбогдох төрийн бус байгууллагууд оролцдог байх шаардлагыг тавьж байна. Түүнээс гадна, ‘зарим СББӨ...’ бус харин ‘нутаг дэвсгэр дээрх СББӨ’ гэж илэрхийлсэн нь Конвенц бүртгэл-мэдээллийн үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоог хангасан байх, СББӨ-ийн олон төрөл зүйл, түүний өвлөн үйлдэгч нарыг хүндэтгэхийг шаардаж байгаа хэрэг юм.

Түлхүүр нэр томъёо

- Бүртгэл-мэдээлэл
- Бүх нийтийн оролцоот / бүх нийтийг хамруулсан
- Олон төрөл (ССБӨ ба түүний өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагч нарын)
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс
- ТББ
- Нийгмийн бүх салбар, бүх бүс нутгийн олон янз байдал
- Нийгмийн салбар, давхарга

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

Үзүүлэлт 7-той холбогдуулан тэмдэглэсний дагуу Конвенц нь Оролцогч улсуудыг тайлагнах үүргийнхээ хүрээнд ‘өөрсдийн бүртгэл-мэдээллийн талаарх холбогдох мэдээллийг өгөх’ (Зүйл 12.2)- ийг үүрэг болгодог (Зүйл 29). Одоогийн үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь Оролцогч улсын бүртгэл-мэдээлэл хийх явцад хамт олон, бүлгүүд, холбогдох төрийн бус байгууллагуудын оролцоог хэр зэрэг үр дүнтэй хангаж байгааг тодорхойлоход тусалдаг. Бүртгэл-мэдээлэл нь бүх нийтийн оролцоот үйл явц гэсэн шаардлагыг үзэж шалгах нь Оролцогч улсын хүчин чармайлтанд санамсаргүй орхигдуулсан нь системийн алдаа дутагдал байж болох эсэхийг тодруулж, ийм орхигдлыг арилгахад илүү их анхаарал хандуулах шаардлагатайг харуулна. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь үр дүнтэй гэдгээ нотлон харуулсан оролцоо, хамруулалтын хандлагуудад олны анхаарал татахын зэрэгцээ улс орнуудад бүсдын жишээнээс суралцах боломжийг олгодог.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Энэ үзүүлэлтийн хувьд мэдээллийг Үзүүлэлт 7-д заасантай ижил аргаар авах боломжтой. Олон улс оронд нэг байгууллага дангаар үзлэг шалгалт хийх, тайлагнах, түүнчлэн бүртгэл-мэдээллийн ажлыг өөрсдөө хариуцан хийж гүйцэтгэх эсвэл бүсдын бүртгэл-мэдээллийн үйл ажиллагааг удирдан зохицуулах үүрэгтэй ажилладаг. Тухайн байгууллага нь бүртгэл-мэдээллийн үйл ажиллагаа болон бүх нийтийн оролцоо, хамруулалтыг ямар арга замаар хэрэгжүүлсэн, бүртгэл-мэдээлэл нь СББӨ-ийг хамгаалахад хэр зэрэг хувь нэмэр оруулж байгаа талаарх хамгийн сүүлийн үеийн нэгдсэн тойм мэдээлэлтэй байдаг. Оролцогч улс нь зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулах механизмтай тохиолдолд түүний бүрэлдэхүүнд ТББ, хамт олонд түшиглэсэн байгууллагын төлөөллийг хамруулсан бөгөөд тэдгээр нь бүртгэл-мэдээллийн ажил болон түүнд хэрхэн оролцсон тухай мэдээлэлтэй байж болно.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Соёлын яам болон бусад бүртгэл-мэдээлэл хариуцсан эрх бүхий байгууллагын цахим хуудас
- Бүртгэл-мэдээлэлд оролцдог төрөлжсөн мэргэжлийн байгууллагуудын цахим хуудас
- Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад бүртгүүлэхээр бэлтгэсэн нэр дэвшүүлэх баримт материалууд
- Конвенцийн хэрэгжилт, Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөлөгчдийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн зүйлүүдийн төлөв байдлын талаарх өмнө нь хүргүүлж байсан тайлангууд
- Төрийн бус байгууллагуудын цахим хуудас эсвэл ТББ-ын сүлжээ, СББӨ-ийн бүртгэл-мэдээллийн ажилд оролцсон хамт олны сүлжээ

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	9. Шинжлэх ухаан, техник болон урлаг судлалыг оруулаад СББӨ-ийн судалгаа, баримтжуулалт нь түүнийг хамгаалахад хэр зэрэг дэмжлэг үзүүлж байгаа байдал							
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	<p>Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:</p> <table border="1"> <tr> <td data-bbox="363 524 1081 706">9.1 Санхүүгийн болон бусад хэлбэрээр үзүүлэх дэмжлэг, туслалцаа нь шинжлэх ухаан, техник болон урлагийн чиглэлээр судалгаа хийх, баримтжуулах ба архивт авах ажлыг дэмждэг, СББӨ-ийг хамгаалахад зорьсон бөгөөд холбогдох ёс зүйн зарчмыг мөрддөг байна.</td> <td data-bbox="1093 524 1263 706">Зүйл 13(с) ҮАУ 173, ҮАУ 175</td> </tr> <tr> <td data-bbox="363 713 1081 857">9.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийг ерөнхийд нь ба СББӨ-ийн зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад чиглэсэн, нөлөө үзүүлэхүйц арга хандлага бүхий судалгааг тэтгэн дэмждэг болсон байна.</td> <td data-bbox="1093 713 1263 857">Зүйл 13(с) ҮАУ 162</td> </tr> <tr> <td data-bbox="363 864 1081 1033">9.3 СББӨ-ийг өвлөн үйлдэгчид болон өвлөн уламжлагчид нь аль ч тохиолдолд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр тэднээс дэмжсэн зөвшөөрөл олгосны дагуу шинжлэх ухаан, техник болон урлаг судлалын ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, судалгааны ажлын үр дүнг түгээхэд оролцдог байна.</td> <td data-bbox="1093 864 1263 1033">ҮАУ 109(а), ҮАУ 109(е), ҮАУ 153(б)(ii), ҮАУ 175 ЁЗЗ 1, ЁЗЗ 7</td> </tr> </table>		9.1 Санхүүгийн болон бусад хэлбэрээр үзүүлэх дэмжлэг, туслалцаа нь шинжлэх ухаан, техник болон урлагийн чиглэлээр судалгаа хийх, баримтжуулах ба архивт авах ажлыг дэмждэг, СББӨ-ийг хамгаалахад зорьсон бөгөөд холбогдох ёс зүйн зарчмыг мөрддөг байна.	Зүйл 13(с) ҮАУ 173, ҮАУ 175	9.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийг ерөнхийд нь ба СББӨ-ийн зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад чиглэсэн, нөлөө үзүүлэхүйц арга хандлага бүхий судалгааг тэтгэн дэмждэг болсон байна.	Зүйл 13(с) ҮАУ 162	9.3 СББӨ-ийг өвлөн үйлдэгчид болон өвлөн уламжлагчид нь аль ч тохиолдолд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр тэднээс дэмжсэн зөвшөөрөл олгосны дагуу шинжлэх ухаан, техник болон урлаг судлалын ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, судалгааны ажлын үр дүнг түгээхэд оролцдог байна.	ҮАУ 109(а), ҮАУ 109(е), ҮАУ 153(б)(ii), ҮАУ 175 ЁЗЗ 1, ЁЗЗ 7
9.1 Санхүүгийн болон бусад хэлбэрээр үзүүлэх дэмжлэг, туслалцаа нь шинжлэх ухаан, техник болон урлагийн чиглэлээр судалгаа хийх, баримтжуулах ба архивт авах ажлыг дэмждэг, СББӨ-ийг хамгаалахад зорьсон бөгөөд холбогдох ёс зүйн зарчмыг мөрддөг байна.	Зүйл 13(с) ҮАУ 173, ҮАУ 175							
9.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийг ерөнхийд нь ба СББӨ-ийн зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад чиглэсэн, нөлөө үзүүлэхүйц арга хандлага бүхий судалгааг тэтгэн дэмждэг болсон байна.	Зүйл 13(с) ҮАУ 162							
9.3 СББӨ-ийг өвлөн үйлдэгчид болон өвлөн уламжлагчид нь аль ч тохиолдолд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр тэднээс дэмжсэн зөвшөөрөл олгосны дагуу шинжлэх ухаан, техник болон урлаг судлалын ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, судалгааны ажлын үр дүнг түгээхэд оролцдог байна.	ҮАУ 109(а), ҮАУ 109(е), ҮАУ 153(б)(ii), ҮАУ 175 ЁЗЗ 1, ЁЗЗ 7							
ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй нийцэж байна. Илүү өргөн утгаараа СББӨ ба түүний хамгаалалтын талаарх судалгаа, баримтжуулалт нь тогтвортой хөдөө аж ахуй эрхлэлт (ТХЗ 2), эрүүл мэнд, сайн сайхан аж байдал (ТХЗ 3), усны тогтвортой хэрэглээ (ТХЗ 6), биологийн олон янз байдал (ТХЗ 15) болон бусад ТХЗ-үүдэд нөлөө үзүүлж болно.</p> <p>Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэ үзүүлэлтийг Үзүүлэлт 10-тай хамтатган авч үзэх хэрэгтэй. Энд анхаарлын гол сэдэв нь судалгаа, баримтжуулалтын үйл явц, тэдгээрийг Конвенцийн үзэл санаа, зорилгод нийцүүлэн хэрхэн явуулж, дэмжих ёстой вэ гэдэгт төвлөрч байна. Үзүүлэлт 10 нь судалгаа, баримтжуулалтын үр дүн, өгөөж болон эдгээр үр дүнг СББӨ-ийн хамгаалалтыг сайжруулах, бодлого боловсруулах ажлыг бэхжүүлэх зорилгоор хэрхэн хэрэглэж болох талаар анхаарч авч үзнэ. Судалгаа, баримтжуулалтын үйл явц, үр дүнд анхаарал төвлөрүүлэхдээ эдгээр хоёр үзүүлэлт нь баримтжуулалтыг дэмжих байгууллагуудтай холбоотой Үзүүлэлт 1, баримт материалыг хуваалцах замаар олон улсын хамтын ажиллагааг дэмжихтэй холбоотой Үзүүлэлт 24-т тус тус нэмэлт нөлөө үзүүлж байна. Үзүүлэлт 22 нь шинжлэх ухаан, техник, урлагийн судалгаатай мөн холбоотой боловч судлах зорилго нь СББӨ өөрөө бус харин СББӨ-ийг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээ юм.</p>							

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Зүйл 2.3-т заасны дагуу хамгаалалтад хамаарах арга хэмжээнүүдийн дотор баримтжуулалт, судалгаа нь чухал байр суурь эзэлдэг. Улс орнуудыг 'үр дүнтэй хамгаалах зорилгоор шинжлэх ухаан, техникийн болон урлагийн судалгаа, түүнчлэн судалгааны арга зүйг хөхүүлэн дэмжих'-ийг бас уриалж байдаг (Зүйл 13(с)). Үйл ажиллагааны удирдамжийн зарим заалтууд нь ийм судалгааны ажлын цар хүрээ, түүнийг хэрхэн яаж хийх ёстой, өвлөн үйлдэгчид болон өвлөн уламжлагчидаас тэдэнд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр дэмжсэн зөвшөөрөл авч баталгаажуулсны дагуу судалгааны үйл ажиллагаанд тэд өргөнөөр, идэвхитэй оролцдог болохыг нарийвчлан тодорхойлж өгчээ. СББӨ-ийн зан үйл, илэрхийллийн талаарх судалгаа, баримтжуулалтыг олон улс оронд, мэдээж хэрэг, олон зууны туршид явуулж ирсэн боловч Конвенцид ийм судалгааны ажлыг хамгаалалтад чиглүүлэх ёстой гэдгийг онцолжээ. Үүнд хамгаалалтын олон янзын стратеги, аргуудын үр өгөөж, нөлөөллийн талаарх судалгааг мөн хамруулж болно.

Түлхүүр нэр томъёо

- Шинжлэх ухаан, техникийн болон урлагийн судалгаа
- Соёлын биет бус өвийг хамгаалах ёс зүйн зарчим
- СББӨ-ийн зүйлүүд
- Бүртгэгдсэн (Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран)
- Өвлөн үйлдэгч ба өвлөн уламжлагч нар
- Оролцоо
- Түгээн дэлгэрүүлэх
- Урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр чөлөөтэй дэмжсэн зөвшөөрөл

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус	<p>Үзлэг шалгалт нь тухайн Оролцогч улсын янз бүрийн судалгаа, баримтжуулалтын байгууллагууд (Үзүүлэлт 1) хамгаалалтад хэр зэрэг үр дүнтэй хувь нэмэр оруулж байгааг үнэлэхэд тусална. Үзлэг шалгалт нь ийм судалгаа, баримтжуулалтын ажлыг дэмжих санхүүгийн эх үүсвэрийн бэлэн байдлыг харуулдаг бөгөөд санхүүжилтийн гачигдал хаана байгааг тодруулж өгдөг. Түүнчлэн судалгаа, баримтжуулалтын явцад холбогдох ёс зүйн зарчмууд, ялангуяа урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр зөвшөөрөл авах зарчмыг хүндэтгэн мөрдөж байгаа эсэхийг тогтооно. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь тодорхой улс орон эсвэл бүс нутагт олон улсын хамтын ажиллагаа, түслэмжийг чиглүүлж болох тодорхой улс орон, бүс нутагт санхүүгийн дутагдал байгааг илрүүлж өгч чадна. Дэлхийн хэмжээний үзлэг шалгалт нь судалгаа, баримтжуулалтын бүх үе шатанд, түүний дотор үр дүнг нь түгээх зэрэгт өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагч нарыг аль болох өргөн хүрээтэй оролцуулахад үр дүнтэй болох нь батлагдсан сайн туршлага, шинэлэг стратегиудыг тодорхойлж өгөхөд тус болдог.</p>
------------------------------------	---

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах	<p>Хэрэв Төрөөс судалгаа, баримтжуулалтын үйл ажиллагааг дэмжихэд зориулж санхүүжилт олгодог бол тухайн санхүүжилтийн бүртгэлд нэвтрэх боломжтой байх; хэрэв зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизм байгаа тохиолдолд гуравдагч этгээдийн санхүүжилтийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг мөн авах боломжтой байж болох юм. Санхүүжилтийн удирдамж, судалгааны стратеги нь судалгаа, баримтжуулалтын үйл явцад өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагч нарын оролцоог аль болох өргөн хүрээнд хамруулж шийдвэрлэх боломжтой. Хэрэв судалгаа, баримтжуулалтын үр дүнг хэвлэл мэдээлэл, үзэсгэлэн, хурал эсвэл бусад олон нийтийн илтгэл, арга хэмжээгээр дамжуулж гаргавал тухайн мэдээллийг авах боломжтой байдаг. Судалгааны журам, тэмдэглэл эсвэл бодлогод нэвтрэхэд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр зөвшөөрөл авах шаардлагатайг зааж өгч болох бөгөөд зөвлөлдөх боломжтой.</p> <p>Судалгааны дүрэм журам, тэмдэглэл, эсвэл бодлого нь урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр дэмжсэн зөвшөөрөл авах эрэлт шаардлагыг ялган тодотгож болох бөгөөд магадгүй зөвлөлдөх боломж гарч болно.</p> <p>Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд</p> <ul style="list-style-type: none"> • Соёлын яамны төсөв, тайлан эсвэл судалгаа, баримтжуулалтыг дэмжих бусад санхүүжилтийн эх үүсвэр • Санхүүжүүлэгчдийн зар сурталчилгаа, санхүүжүүлэх удирдамж • Судалгааны үйл ажиллагааг зохицуулах журам, протокол, ялангуяа хүний сэдэвтэй холбоотой • Ном зүй, хэвлэн нийтлэгчдийн каталог эсвэл хэвлэгдсэн бүтээлүүдийн тойм • Үзэсгэлэнгийн каталог, хурлын хөтөлбөр болон хэлэлцүүлэг, эсвэл бусад олон нийтийн танилцуулга, үйл явдлыг дүрсэлсэн баримт бичиг • Олон нийтийн оролцоотой судалгаа, баримтжуулалтын хөтөлбөр, үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн мэдээ, мэдээлэл
--	---

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	10. Судалгааны үр дүн, баримтжуулсан материал нь аль хэр хүртээмжтэй, бодлого боловсруулах үйл ажиллагааг бэхжүүлэх болон хамгаалалтыг сайжруулах зорилгоор хэр зэрэг ашиглагдаж байгаа байдал	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	10.1 Баримтжуулалт ба судалгааны үр дүн нь СББӨ-ийн зарим зүйлийг үзэж танилцахад дагаж мөрддөг онцгой зан үйлд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ хамт олон, бүлэг, хувь хүмүүст хүртээмжтэй болсон байна.	Зүйл 13(d)(ii) ҮАУ 85, ҮАУ 101(c), ҮАУ 153(b)(iii) ЁЗЗ 5
	10.2 СББӨ-ийн талаарх судалгаа, баримт материал, шинжлэх ухаан, техник болон урлагийн судалгааны ажлын үр дүнг салбар бүрт бодлого боловсруулах үйл ажиллагааг бэхжүүлэхэд ашиглаж байна.	ҮАУ 153(b)(ii)
	10.3 СББӨ-ийн талаарх судалгаа, баримт материал, шинжлэх ухаан, техник болон урлагийн судалгааны ажлын үр дүнг хамгаалалтыг сайжруулах зорилгоор ашиглаж байна.	Зүйл 2.3 ба 13(c)
ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь олон нийтийн мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангахад чиглэж байгаагаараа ТХЗ-ын Зорилт 16.10-ыг дэмжиж, мөн тогтвортой хөгжлийн бодлогын үялдаа холбоог сайжруулж буйгаараа ТХЗ-ын Зорилт 17.14-ийг дэмжиж байна. Үзүүлэлт нь 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй мөн нийцэж байна.</p> <p>Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэ үзүүлэлт нь судалгаа, баримтжуулалтын үр дүн, үр нөлөөг, ялангуяа хамгаалалт, бодлого боловсруулалтыг бэхжүүлэхэд хэрхэн ашиглаж болохыг онцлон тэмдэглэдэг. Энэ нь судалгаа, баримтжуулалтын үйл явц, тэдгээрийг хэрхэн хамгийн сайн гүйцэтгэх ёстой вэ гэдэгт чиглэсэн Үзүүлэлт 9-ийг дэмжин нөхөж байна. Эдгээр хоёр үзүүлэлт нь баримтжуулалтыг дэмжих байгууллагуудад хамааралтай Үзүүлэлт 1, баримт материалыг хуваалцах замаар олон улсын хамтын ажиллагааг дэмжихтэй холбоотой Үзүүлэлт 24-т тус тус нэмэлт нөлөө үзүүлж байна. Нэмж дурдахад энэ нь соёл, боловсролын салбар зэрэг янз бүрийн салбарт бодлого боловсруулахад чиглэсэн Үзүүлэлтүүд 11, 12, 13-ыг дэмжин дэмжлэг нөлөө үзүүлж байна.</p>	

**Үйл ажиллагаа
явуулах
үндэслэл**

Конвенц нь судалгаа, баримтжуулалтыг СББӨ-ийг хамгаалах арга хэмжээ болгон тусгайлан сурталчилж байна (Зүйл 2.3). Эдгээр бүх арга хэмжээнүүдийн адилаар тэд хамт олон, бүлгүүд, хувь хүмүүсийн оролцоог аль болох өргөнөөр хамруулах ёстой (Зүйл 15). Олон жишээн дээр ийм оролцогчид өөрсдийн зан үйлээ үйлдэх, өвлөн уламжлахыг бэхжүүлэхийн тулд одоо байгаа судалгаа, баримтжуулалтыг хэрхэн ашигласныг харуулж байдаг. Тиймээс Конвенц нь хамт олны өөрийнх нь СББӨ-ийн зарим онцгой зүйлийг үзэж танилцахад дагаж мөрддөг онцлог уламжлал, зан үйлд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ судалгааны үр дүнг өргөн хүрээнд хүртээмжтэй байхыг хөхүүлэн дэмждэг. Судалгаа, баримтжуулалт, түүнчлэн шинжлэх ухаан, техник, урлагийн судалгаа нь бодлого боловсруулах, ялангуяа хамгаалах янз бүрийн санаачилгын үр нөлөө, ашиг тусыг судлах замаар мэдээллээр хангах чухал нөөц бололцоо юм.

**Түлхүүр нэр
томъёо**

- Нэвтрэх/үзэж танилцах боломж
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс
- Уламжлалт зан үйл
- Шинжлэх ухаан, техникийн болон урлагийн судалгаа
- Янз бүрийн салбар дамнасан бодлого боловсруулах

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

**Үзлэг шалгалт
хийх ашиг тус**

Улсын хэмжээнд үзлэг шалгалт хийх нь тухайн улс оронд хамт олон, бүлгүүд, хувь хүмүүс өөрсдийн СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлах түршлагыг бататган бэхжүүлэхийн тулд судалгаа, баримтжуулалтаас хэр зэрэг ашиг тус хүртэж болохыг үнэлэхэд тусалж чадна. Ийм үзлэг шалгалт нь бодлого боловсруулагчид холбогдох бодлогыг боловсруулж гаргахдаа судалгаа, баримтжуулалтаас адилхан ашиг тус хүртэж чадаж байгаа эсэхийг олж мэдэх боломжтой. Энэ нь бодлогоор, эсвэл хамт олны түршлагаар дамжуулан хамгаалалтыг бэхжүүлэх илүү боломж бололцоо байгаа эсэхийг тодорхойлж өгнө. Цаашилбал, үзлэг шалгалт хийх нь судалгаа шинжилгээнд санхүүжилт олгож дэмжлэг үзүүлдэг байгууллагуудыг бодлого боловсруулахад илүү хөрөнгө оруулбал үр ашигтай байж болох тийм салбаруудын талаар мэдээллээр хангах боломжийг олгодог. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь тодорхой Оролцогч улсын эрэлт хэрэгцээнд нийцүүлж болохуйц сайн түршлагыг олж тогтоож чадах бөгөөд мөн олон улсын хамтын ажиллагааны бололцоог илрүүлэн тодорхойлоход ач тустай.

**Мэдээллийн
эх сурвалж
ба мэдээлэл
цуглуулах**

Судалгаа, баримтжуулалт хийдэг байгууллагуудын тайлан, нийтлэлүүд нь энэ үзүүлэлтэд хэрэгтэй мэдээллийн чухал эх сурвалж болдог. Сүлжээ эсвэл судлаачдын мэргэжлийн холбоод нь мэдээллийн товхимол, эмхэтгэл эсвэл тогтмол уулзалтуудтай байж, түүгээрээ дамжуулан үйл ажиллагааныхаа талаар мэдээлж, өөрсдийн олсон мэдээлэлтэй өргөнөөр танилцахад дэмжлэг үзүүлж байж болно. Хэрэв Оролцогч улс нь бодлого боловсруулагчид, шинжээчид, хамт олны гишүүдийг нэгтгэдэг зөвлөлдөх байгууллага эсвэл хамтын ажиллагааны механизмтай бол энэ нь судалгаа, баримтжуулалт, түүнчлэн шинжлэх ухаан, техник, урлагийн судалгааг хэрхэн ашиглаж байгаа болон нөлөөлөл нь хэр байгааг үзэж шалгаж хэлэлцүүлэг хийж болох юм.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Холбогдох судалгаа, баримтжуулалтын байгууллагуудын тогтмол тайлан
- Үндэсний судалгааны жилийн төсөв, үндэсний санхүүжүүлэгч байгууллагуудын тайлан
- Мэргэжлийн холбоодын мэдээллийн товхимол, эмхэтгэл эсвэл цахим хуудас, судлаачдын сүлжээ
- Үзэсгэлэнгийн каталог, хурлын хөтөлбөр болон хэлэлцүүлэг, эсвэл бусад олон нийтийн танилцуулга, үйл явдлыг тэмдэглэсэн баримт бичиг
- Архивын болон бусад баримтжуулалт хийж гүйцэтгэдэг байгууллагуудын олон нийттэй харьцах бодлого болон дүрэм, журмууд

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	11. Соёлын талаар баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон төрөл, түүнийг хамгаалахын ач холбогдлыг аль хэр тусгаж, хэрэгжиж байгаа байдал	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний дөрвөн хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	11.1 СББӨ болон түүний хамгаалалтыг нэгтгэсэн, олон төрлийг нь тусгасан соёлын бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнүүдийг баталсан, эсвэл шинэчлэн боловсруулсан бөгөөд тэдгээр нь одоо хэрэгжиж байна.	Зүйл 13(a) ҮАУ 153(b)(i), ҮАУ 171(d)
	11.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран зарим онцгой өвийн зүйлүүдийг хамгаалахад чиглэсэн төлөвлөгөөг хамруулан СББӨ-ийг хамгаалах үндэсний болон бүсийн (орон нутгийн) стратеги ба/эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан, эсвэл шинэчлэн боловсруулсан бөгөөд тэдгээр нь одоо хэрэгжиж байна.	ҮАУ 1, ҮАУ 2
	11.3 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийн зүйлүүдийг хамгаалахад чиглэсэн төрийн санхүүгийн болон/эсвэл техникийн дэмжлэг, тусламжийг соёл болон өвийг өргөн цар хүрээнд бүхэлд нь дэмжих зорилгоор адил тэгш байх зарчмаар хуваарилдаг байна. Ингэхдээ яаралтай хамгаалах шаардлагатай өвийн зүйлийг нэн тэргүүнд авч үзэж хуваарилдаг байна.	
	11.4 СББӨ ба түүний хамгаалалтыг нэгтгэсэн соёлын бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээний талаар хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн идэвхтэй оролцоотойгоор мэдээлдэг байна.	Зүйл 15

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Хэрэв соёлыг Тогтвортой хөгжлийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны өсөлтийг тодорхойлогч гэж хүлээн зөвшөөрвөл соёлын бодлого нь ТХЗ-д өргөн хүрээнд нөлөө үзүүлж болох юм. Энэ агуулгын хүрээнд СББӨ-ийн хамгаалалт нь тогтвортой хөдөө аж ахуй эрхлэлт (ТХЗ 2), эрүүл мэнд, сайн сайхан аж байдал (ТХЗ 3), усны тогтвортой хэрэглээ (ТХЗ 6), биологийн олон янз байдал (ТХЗ 15) болон бусад ТХЗ-үүдэд хувь нэмэр оруулж болох юм. Гэсэн хэдий ч энэхүү үзүүлэлт нь 'бүх түвшинд хурдан шүүрхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох' гэсэн ТХЗ-ын Зорилт 16.7, мөн тогтвортой хөгжлийн бодлогын үялдаа холбоог сайжруулахыг уриалсан ТХЗ-ын Зорилт 17.14-ийг тусгайлан дэмжиж байгаа гэж ойлгож болно. Энэхүү үзүүлэлт нь бусад үзүүлэлтүүдийн адил 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй мөн нийцэж байна.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээний талаар нэмэлт дөрвөн үзүүлэлт (11-14) байгаа. Энэхүү Үзүүлэлт 11 нь соёлын салбарт чиглэдэг; Үзүүлэлт 12 нь боловсролын салбарт анхаарлыг хандуулж байна; Үзүүлэлт 13 нь тогтвортой хөгжлийн бусад бүх салбарт хамаатай юм. Багцын дөрөв дэх үзүүлэлт болох Үзүүлэлт 14 нь дээрх бүх салбарт хамаарах бөгөөд эдгээр бүх салбарт баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь уламжлалт ёс, зан үйл, илэрхийллийг хэр зэрэг хүндэтгэж буйг харгалзан үздэг. Энэ үзүүлэлтийн гол сэдэв нь соёлын бодлогод чиглэгддэг бол соёлын байгууллагууд, тэдгээрийн боловсон хүчин, хөтөлбөр, үйл ажиллагаа нь 1-3, 7-10, 15-25 үзүүлэлтүүдийн сэдэв юм. Үзүүлэлт 10 нь судалгаа шинжилгээ, баримтжуулалтыг салбарын хэмжээнд бодлого боловсруулахад хэрхэн ашиглаж байгааг онцгой анхаарч үздэг бол Үзүүлэлт 19 нь өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагч нарыг бодлого, хөтөлбөрөөр дамжуулан хэрхэн талархан хүлээн зөвшөөрч байгааг авч үздэг.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Зүйл 13(a)- д Оролцогч улсуудыг 'Нийгэмд соёлын биет бус өвийн үүргийг дээшлүүлэхэд чиглэсэн ерөнхий бодлого баталж, энэхүү өвийн хамгаалалтыг төлөвлөж буй хөтөлбөрүүдэд тусгах'-ыг уриалдаг бөгөөд ийм бодлого боловсруулалт, төлөвлөлтийг соёлын салбарт хамруулан хийж болох юм. Тэдгээр бодлого, төлөвлөгөө бодитоор хэрэгжиж байгаа эсэх, хэр зэрэг хэрэгжиж байгааг мэдэх нь чухал юм. Эдгээр нь СББӨ-ийг соёлын томоохон бодлогод нэгтгэх ерөнхий арга хэмжээ байж болох (Үнэлгээ хийх хүчин зүйл 11.1) ба, эсвэл СББӨ-ийг ерөнхийд нь буюу онцгой өвийн зүйлийг хамгаалах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө хэлбэрээр хэрэгжүүлж болно (Үнэлгээ хийх хүчин зүйл 11.2). Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран онцгой өвийн зүйлүүдэд анхаарлаа төвлөрүүлснээр Үнэлгээ хийх хүчин зүйл 11.3 нь СББӨ-ийг хамгаалахад Оролцогч улс орнуудад санхүүгийн болон/эсвэл техникийн дэмжлэг үзүүлэхийг уриалж байгаа. Ингэхдээ бүртгэл-мэдээллийн явцад илэрсэн, эсвэл бусад шалтгааны улмаас яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-өөр тодорхойлсон өвийн зүйлүүдэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Эцэст нь Үнэлгээ хийх хүчин зүйл 11.4 нь Зүйл 15-д заасны дагуу хамт олон, бүлгүүд, хувь хүмүүс СББӨ-ийн хамгаалалт, менежментэд хэр зэрэг идэвхтэй оролцож байгааг судалж үзнэ.

Түлхүүр нэр томъёо

- Бодлого
- Хууль эрх зүйн арга хэмжээ
- Захиргааны арга хэмжээ
- Олон төрөл (СББӨ ба түүнийг өвлөн үйлдэгчийн)
- СББӨ-ийн зүйлүүд
- Бүртгэгдсэн (Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран)
- Оролцоо
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг түс	Бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнд үзлэг шалгалт хийх нь тэдгээрийн үр нөлөөг харуулах чухал хэрэгсэл юм. Хэрэгжүүлэлтийн бодит туршлага нь тухайн бодлого бодитой, хэрэгжих боломжтой эсэх, эсвэл өөрчлөн шинэчлэх шаардлагатай эсэхийг харуулна. Тодорхой стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд үзлэг шалгалт хийх нь сайн туршлагыг олж тогтоох эсвэл үр дүнгүй, засварлах шаардлагатай, мөн болих шаардлагатай хүчин чармайлтыг илрүүлэх боломж олгоно. Энэ нь мөн шийдвэрлэх шаардлагатай байж болзошгүй бодлогын алдаа дутагдлыг зааж өгнө. Бодлого боловсруулах үйл явцад үзлэг шалгалт хийх нь өөрөө СББӨ-ийн менежментэд хамт олон, бүлгүүд, хувь хүмүүсийн оролцоог хамгийн өргөн хүрээнд хангахад саад бэрхшээл байгаа эсэхийг илрүүлж, тэдгээрийг арилгах арга замыг зааж өгч болно. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь Конвенцийг Оролцогч улсуудын бодлогын хүрээнд хэр зэрэг уялдуулж байгааг шалгаж үзэх ийм интеграцийн сайн үлгэр жишээ загваруудыг олж тодорхойлох боломжтой юм.
------------------------------------	--

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах	Соёлын яам нь ихэвчлэн соёлын салбарт баримтлах бодлого, эрх зүй, захиргааны арга хэмжээг боловсруулдаг байгууллага болж байдаг. Ийм арга хэмжээнүүд нь үндэсний соёлын өвийн тухай хуулиас (эсвэл ялангуяа соёлын биет бус өвийн тухай) авахуулаад захиргааны янз бүрийн зохицуулалтын арга хэмжээг багтаасан байж болно. Бодлогыг ерөнхийдөө ийм хууль тогтоомжийн дагуу болон төлөвлөлтийн тогтсон мөчлөг тохируулан боловсруулдаг (жишээлбэл, таван жилийн төлөвлөгөө, арван жилийн төлөвлөгөө г.м). Онцгой өвийн зүйлүүдийн төлөвлөгөөг багтаасан СББӨ-ийг хамгаалах үндэсний дэд стратеги буюу үйл ажиллагааны төлөвлөгөөг төв яамны шүүд хяналтаас гадуур ч хэрэгжүүлж болох юм. Хэрэв тухайн улс нь зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизмтай бол (Үнэлгээ хийх хүчин зүйл 1.3) тухайн байгууллага нь мөн хамгаалалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг хянан шалгадаг байх боломжтой. Хэрэв хамгаалалтад төрийн санхүүгийн болон/эсвэл техникийн түслалцаа үзүүлдэг бол санхүүжилт олгосон байгууллага (үүд) бүртгэл хөтөлсөн байдаг. Бодлогын үйл явцад хамт олон, бүлгүүд, хувь хүмүүс хэрхэн идэвхтэй оролцохыг тодорхой удирдамж эсвэл ийм оролцоонд тавигдах шаардлагуудаар зохицуулж болдог ба, эсвэл бодлогын үйл явцыг илүү чанартай ажиглан хянах шаардлага гарч болно.
--	--

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Албан ёсны сонин/сэтгүүл эсвэл хууль, эрх зүйн зохицуулалтын эмхэтгэл
- Соёлын яам эсвэл хууль тогтоох байгууллагын бодлогын баримт бичиг
- Соёлын яам болон/эсвэл СББӨ-ийн хамгаалалтыг дэмжиж ажилладаг бусад санхүүжилтийн байгууллагуудын төсөв, ажлын төлөвлөгөө
- Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад бүртгүүлэхээр бэлтгэсэн өвийн зүйлсийн нэр дэвшүүлэх баримт материалууд
- Хэрэв хамгаалалтын төлөвлөгөөнд шаарддаг бол улсын хэмжээний жагсаалт, эсвэл бүртгэлд оруулахаар санал болгосон өвийн зүйлсийн нэр дэвшүүлэх баримт материалууд
- Бодлогын үйл явц дахь оролцоог үнэлэх зорилгоор хамт олон, бүлгүүд, хувь хүмүүсийн дунд хийсэн судалгаа

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	12. Боловсролын талаар баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон төрөл, түүнийг хамгаалахын ач холбогдлыг аль хэр тусгаж, хэрэгжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	12.1 Соёлын биет бус өвийг хүлээн зөвшөөрөх, хүндлэн дээдлэх, сайжруулах зорилгоор боловсролын талаар баримтлах бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг баталдаг, эсвэл шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлдэг байна.	Зүйл 14(a)(ii)
	12.2 СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлах явдлыг бэхжүүлэх зорилгоор боловсролын талаар баримтлах бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг баталдаг, эсвэл шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлдэг байна.	Зүйл 14(a)(ii)
	12.3 Бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь эх хэлээр сургалт явуулах, олон хэлээр боловсрол олгохыг хөхүүлэн дэмждэг байна.	Зүйл 14(a)(ii) ҮАУ 107

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): СББӨ-ын хамгаалалтыг бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад нэгтгэхийг дэмжсэнээр энэхүү үзүүлэлт нь ТХЗ-ын Зорилго 1 (ядуурлыг бүх хэлбэрээр бүүруулах), ялангуяа ядуурлыг зогсоох хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ТХЗ-ын Зорилт 1.а-д хувь нэмэр оруулж байна. Боловсролын бодлогод чиглэсэн энэхүү үзүүлэлт нь тогтвортой хөгжлийн боловсрол, “тогтвортой хөгжилд соёлын олон төрөл болон соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгон үнэлэх” гэсэн ТХЗ-ын Зорилт 4.7-г шүүд дэмжиж байна. Энэ нь цаашлаад тогтвортой хөгжлийн бодлогын үялдаа холбоог сайжруулахыг уриалсан ТХЗ-ын Зорилт 17.14-ийг дэмжиж, мөн бүх үзүүлэлтүүдийн адил 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй мөн нийцэж байгаа болно.
--	--

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: СББӨ ба бодлогын талаарх дөрвөн үзүүлэлтээс (Үзүүлэлт 11-14) энэ үзүүлэлт нь боловсролын салбар дахь бодлого, хууль эрх зүй болон захиргааны арга хэмжээг хамруулан авч үзэж байна. Бодлогын хэмжүүр дээр анхаарлаа төвлөрүүлснээр энэхүү үзүүлэлт нь боловсролын хөтөлбөр, үйл ажиллагааг шийдвэрлэх Үзүүлэлт 4-6-г мөн дэмжиж байна.

**Үйл ажиллагаа
явуулах
үндэслэл**

Конвенцид боловсрол нь СББӨ-ийг хүндэтгэх, түүний ач холбогдлын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хэрэгсэл болоход онцгой анхаарал хандуулдаг (Зүйл 1) ба, түүнчлэн СББӨ-ийг өвлөн уламжлахыг дэмжих замаар СББӨ-ийг хамгаалах чухал талбар нь болж өгдөг (Зүйл 2.3). Конвенцийн Зүйл 14(а)-д ‘нийгэм дэх соёлын биет бус өвийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, сайжруулах’ хэрэгсэл болгон ‘холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүст зориулж боловсролын болон сургалтын тусгай хөтөлбөрөөр’ хэрэгжүүлэх нь зүйтэй гэж онцолсон байдаг. Холбогдох бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээний багцыг бий болгох нь боловсролын салбарт соёлын биет бус өвийн үр дүнтэй, тогтвортой хөтөлбөр, үйл ажиллагааг загварчлан төлөвлөх, боловсруулах, хүргэх, хэрэгжүүлэхэд чухал хөрс суурь нь болно.

**Түлхүүр нэр
томъёо**

- Бодлого
- Хууль эрх зүйн арга хэмжээ
- Захиргааны арга хэмжээ
- Олон төрөл (СББӨ ба түүнийг өвлөн үйлдэгчдийн)
- Албан боловсрол
- СББӨ-ийг хүлээн зөвшөөрөх
- СББӨ-ийг хүндэтгэх
- СББӨ-ийг сайжруулах
- Эх хэлний боловсрол
- Олон хэлний боловсрол

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

**Үзлэг шалгалт
хийх ашиг тус**

Соёлын салбар дахь бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээний нэгэн адил (Үзүүлэлт 11) боловсролын бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээний үзлэг шалгалт хийх нь тэдгээрийн үнэ цэн, үр нөлөөг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай юм. Цаашилбал, тэдгээрийн бодит хэрэгжилт нь бодлого, арга хэмжээнүүд бодитой бөгөөд хэрэгжих боломжтой эсэх, эсвэл тухайн улсын бодит байдалд илүү нийцүүлэн өөрчлөх эсвэл нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг зааж өгнө. Бодлогын илүү өргөн хүрээнд үзлэг шалгалт хийх нь тэдгээрийн хамрах хүрээний хөтөлбөр, үйл ажиллагаа тус бүр хамгийн их үр дүнд хүрэхэд нь тусалж чадна. Дэлхийн хэмжээнд энэ үзүүлэлт нь янз бүрийн Оролцогч улсын бодлогын онцлог нөхцөл байдалд тохируулан боловсруулж болохуйц сайн үлгэр жишээ загваруудыг тодорхойлж, ийм хүчин чармайлтыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын ажиллагааны хэрэгцээг харуулж чадна.

**Мэдээллийн
эх сурвалж
ба мэдээлэл
цуглуулах**

Үзлэг шалгалт хийх, тайлан гаргах үүрэг бүхий хүмүүс Боловсролын Яам болон/эсвэл Дээд боловсролын асуудал эрхэлсэн яамны мэргэжилтнүүдтэй нягт хамтран ажиллахыг эрмэлзэх нь зүйтэй. Хамгийн дээд түвшинд боловсролын тухай хууль, томоохон бодлогуудыг албан ёсны сэтгүүлд нийтэлдэг байж болох ба; илүү тодорхой хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг холбогдох яамны вэбсайт дээр нийтэлдэг байж болно. Хэрэв тухайн улсад боловсролын салбарын төлөөллүүдийг багтаасан зөвлөлдөх байгууллага буюу зохицуулах механизм байгаа бол тэдгээр нь боловсролын бодлого, арга хэмжээний талаарх мэдээлэлд үнэтэй эх сурвалж болж чадна. Сурган хүмүүжүүлэх болон боловсролын чиглэлээр сургалт явуулдаг боловсролын судалгааны байгууллагууд эсвэл их дээд сургуулиуд боловсролын бодлогын талаар судалгаа хийж, тухайн бодлогын үр дүн, нөлөөг үнэлэх, тухайн салбар дахь хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг хариуцах үүрэгтэй байж болно.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Хууль, эрх зүйн зохицуулалтын албан ёсны сэтгүүл эсвэл эмхэтгэл
- Боловсролын яам, Дээд боловсролын асуудал эрхэлсэн яам болон боловсролын асуудал эрхэлсэн хууль тогтоох байгууллагын бодлогын баримт бичиг
- Боловсролын бодлогыг судалж, эдгээр бодлогын нөлөөллийг шалгаж хянадаг эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд ба/эсвэл сурган хүмүүжүүлэх их сургуулиудын хийсэн судалгаа, тайлан.
- Боловсролын Төлөвлөлтийн Олон Улсын Хүрээлэнгээс эрхлэн ажиллуулдаг ЮНЕСКО-гийн Планиполисын боловсролын төлөвлөгөө, бодлогын портал (<https://planipolis.iiep.unesco.org/>)
- Боловсрол дахь ялгаварлан гадуурхах явдлын эсрэг Зөвлөмж болон 1960 оны Конвенцийн хэрэгжилтийн талаар, ялангуяа боловсролын цөөнхийн хэлний талаар ЮНЕСКО-д гаргаж өгсөн Оролцогч улсын тайлан
- Хүний эрх, үндсэн эрх чөлөөнд хамаарах олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, энх тайван, боловсролын талаархи 1974 оны Зөвлөмжийн хэрэгжилтийн талаар ЮНЕСКО-д гаргаж өгсөн Оролцогч улсын тайлан
- 1966 оны Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 13 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар НҮЭЗНЗ-д гаргаж өгсөн Оролцогч улсын тайлан

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	13. Соёл, боловсролоос бусад салбарт баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон төрөл, түүнийг хамгаалахын ач холбогдлыг аль хэр тусгаж, хэрэгжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний таван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	13.1 Бүх нийтийн оролцоотой нийгмийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг СББӨ болон түүний хамгаалалтын байдлыг харгалзан үзэж боловсруулан баталдаг, шинэчлэн сайжруулдаг байна.	YAY 171(c) ЁЗЗ
	13.2 Бүх нийтийн оролцоотой нийгмийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг СББӨ болон түүний хамгаалалтын байдлыг харгалзан үзэж боловсруулан баталдаг, шинэчлэн сайжруулдаг байна.	YAY 171(d), YAY 178, YAY 179, YAY 181, YAY 182, YAY 188-190, YAY 191
	13.3 Байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг тухайн нөлөөлөлд өртсөн СББӨ-ийг хамруулж, нөлөөлөлд өртсөн хүн ам тэдгээрийг тэсвэрлэн даван гарахад СББӨ-ийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч боловсруулан баталдаг, шинэчлэн сайжруулдаг байна.	YAY 188, YAY 191, YAY 196
	13.4 Бүх нийтийн оролцоотой эдийн засгийн хөгжлийн талаар баримтлах бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг СББӨ болон түүний хамгаалалтын байдлыг харгалзан үзэж боловсруулан баталдаг, шинэчлэн сайжруулдаг байна.	YAY 171(d), YAY 183-186
	13.5 СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлах нөхцлийг ханган бүрдүүлэх, эсвэл хөхүүлэн дэмжих, өвийн зүйлийг эзэмшин үйлдэхэд шаардлагатай байгалийн болон бусад нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн болон төсвийн тааламжтай арга хэмжээ, урамшууллын тогтолцоог боловсруулан баталдаг, шинэчлэн сайжруулдаг байна.	YAY 78, YAY 186(b)

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь 2030 хөтөлбөрийн бүх зорилго, зорилтыг биш гэхэд ихэнхи зүйлийг дэмжиж байгаа бөгөөд СББӨ-ийн хамгаалалт нь тогтвортой хөгжлийн бүх зорилгууд биш юмаа гэхэд олонхид нь хувь нэмэр оруулах боломжтой юм. Гэсэн хэдий ч Үзүүлэлт 11, 12-оос ялгаатай нь энэхүү үзүүлэлт нь тогтвортой хөдөө аж ахуй эрхлэлт (ТХЗ 2), эрүүл мэнд, сайн сайхан аж байдал (ТХЗ 3), усны тогтвортой хэрэглээ (ТХЗ 6), биологийн олон янз байдал (ТХЗ 15) зэрэг соёл, боловсролоос бусад салбарт төлөвлөгөө, хөтөлбөрт СББӨ-ийн хамгаалалтыг хэрхэн ашиглахыг тодорхойлохыг эрмэлздэг. Энэ утгаараа энэ үзүүлэлт нь Тогтвортой Хөгжлийн Зорилгод хамгийн өргөн хамааралтай байж болох юм.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Хөгжлийн хэд хэдэн салбарт олон төрлийн бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг авч үздэгээрээ, Үзүүлэлт 13 нь соёлын салбарт чиглэсэн Үзүүлэлт 11, боловсролын салбарт төвлөрсөн Үзүүлэлт 12-ыг дэмжин нөхөж байна. Үзүүлэлт 14 нь эргээд салбар бүрт бодлого, арга хэмжээ авахад шаардагдах тодорхой нөхцлүүдэд анхаарлаа төвлөрүүлдэг. Энэхүү үзүүлэлт нь бодлогын агуулгатай холбоотой бол Үзүүлэлт 15 ба 16 нь эдгээр бодлогыг, ялангуяа тогтвортой хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөөнд анхаарлаа төвлөрүүлдэг.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Конвенц нь Оролцогч улс бүрийг 'нийгэмд соёлын биет бус өвийн үүргийг дээшлүүлэхэд чиглэсэн ерөнхий бодлого баталж, энэхүү өвийн хамгаалалтыг төлөвлөж буй хөтөлбөрүүдэд тусгах'-ыг уриалдаг (Зүйл 13(a)). Үүний хариуд Оролцогч улсууд Үйл Ажиллагааны Удирдамжийн VI бүлгийг баталж, СББӨ-ийн хамгаалалт болон тогтвортой хөгжлийн (YAY 170-197) хоорондын харилцааг зохицуулж, олон хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг уриалж, бодлого, эрх зүй, захиргааны арга хэмжээ авч тэдгээр хөтөлбөр, үйл ажиллагаануудыг удирдан чиглүүлж нөлөөллийг хамгийн их байлгахыг дэмжиж байна. Хэрэв байгаа бол цөөн хэдэн Оролцогч улс энэхүү үзүүлэлт болон холбогдох удирдамжинд тусгагдсан бүх салбарт бодлого боловсруулалтыг нэгэн зэрэг хийж шийдвэрлэх боловч олонх нь энд тодорхойлсон нэг буюу хэд хэдэн салбарыг хамарсан бодлого, эрх зүй, захиргааны арга хэмжээ боловсруулж гаргах, эсвэл шинэчлэн өөрчлөх нь үр ашигтай гэж үзэж байна.

Түлхүүр нэр томъёо

- Бодлого
- Хууль эрх зүйн арга хэмжээ
- Захиргааны арга хэмжээ
- Олон төрөл (СББӨ ба түүнийг өвлөн үйлдэгчийн)
- Соёлын биет бус өвийг хамгаалах ёс зүйн зарчим
- Бүх нийтийн оролцоотой нийгмийн хөгжил
- Бүх нийтийн оролцоотой эдийн засгийн хөгжил
- СББӨ-ийг эзэмшин үйлдэхэд шаардлагатай байгалийн болон бусад нөөц бололцоо

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРГАХ ТАЛААРХ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус	Энэ үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь улс орнууд СББӨ болон түүний хамгаалалтыг тогтвортой хөгжилд чиглэсэн бодлого, эрх зүй, захиргааны арга хэмжээнд хэр зэрэг уялдуулж байгааг тодорхойлоход тусалж чадна. Бусад үзүүлэлтүүд нь ийм бодлоготой уялдуулан хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээг авч үздэг боловч бодлогын агуулгад өөрт нь үзлэг шалгалт хийх, ялангуяа төрийн зүгээс СББӨ-ийг хамгаалахтай холбоотой асуудал, СББӨ-ийг хамгаалах ёс зүйн зарчимд заасан зарчмуудыг тусгаж байгаа эсэхийг үзэж хянах нь чухал юм. СББӨ-ийн хамгаалалт болон тогтвортой хөгжлийн хооронд олон тооны боломжит холбоо хамаарал байж болох бөгөөд үзлэг шалгалт нь төрд бодлого боловсруулах шатанд харахан судлагдаагүй байгаа боломжуудыг тодорхойлоход тусална. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь улс орнууд СББӨ-ийн хамгаалалтыг бодлого боловсруулалтад хэр зэрэг бүтээлчээр нэгтгэж байгааг илрүүлж, түршлага, хэтийн төлөв солилцох боломжтой талбаруудыг зааж өгч чадна.
------------------------------------	---

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах	Улс орнууд хөгжлийн асуудал эрхэлсэн олон төрлийн яамдын төлөөллийг хамруулсан бүх нийтийн оролцоот, олон салбарыг хамарсан зөвлөлдөх байгууллага буюу зохицуулалтын механизмыг байгуулсан байж болох юм. Мөн энэ чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын талаар өргөн хүрээнд үр бүтээлтэй ажилладаг Төлөвлөлтийн яам эсвэл Тогтвортой хөгжлийн яам байж болох юм. Зохицуулах механизм эсвэл тусгай яам байхгүй тохиолдолд үзлэг шалгалт хийх, тайлагнах үүрэг бүхий хүмүүс нь тогтвортой хөгжлийн асуудал эрхэлсэн холбогдох яамдын бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны баримт бичгүүдтэй танилцаж зөвлөлдөх шаардлагатай болно.
--	---

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Хууль, эрх зүйн зохицуулалтын албан ёсны сэтгүүл эсвэл эмхэтгэл
- Тогтвортой хөгжлийн асуудал эрхэлсэн холбогдох яамдын, ялангуяа ҮАУ-ын Бүлэг VI-д дурдсан салбарт идэвхтэй ажилладаг байгууллагууд бодлогын баримт бичиг
- Тогтвортой хөгжилд оролцдог холбогдох яамдын төсөв, санхүүгийн тайлан
- Таван жилийн төлөвлөгөө, арван жилийн төлөвлөгөө гэх мэт үндэсний тогтвортой хөгжлийн стратеги
- Үндэсний болон орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах (ГЭБ) төлөвлөгөө ба эдгээр төлөвлөгөөнд үзлэг шалгалт хийсэн тайлан
- Хөгжлийн бодлогыг судалж буй эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн хийсэн судалгаа, тайлан

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	14. Бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь уламжлалт ёс, зан үйл, илэрхийлэлд, ялангуяа тэдгээрийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахад аль хэр хүндэтгэлтэй хандаж байгаа байдал (хүрсэн түвшин)	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	14.1 СББӨ-ийг өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагчид, хамт олны СББӨ-ийг арилжааны болон бусад зорилгоор ашиглах үед тэд нарт оюуны өмчийн эрх, нууцлалын эрх зэрэг эрх зүйн хамгаалалтуудыг олгодог байна.	ҮАУ 104, ҮАУ 173
	14.2 СББӨ-ийг эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахад зайлшгүй шаардлагатай газар, далай, ойн экосистемийг хэрэглэх хамт олон, бүлгүүдийн уламжлалт эрхийн ач холбогдлыг бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээндээ хүлээн зөвшөөрч, харгалзан үздэг байна.	ҮАУ 178(с)
	14.3 Бодлого ба/эсвэл хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь маргаанаас урьдчилан сэргийлэх, зөрчил мөргөлдөөнийг энх тайвнаар шийдвэрлэхэд хувь нэмэр оруулж буй соёлын биет бус өвийн илэрхийлэл, зан үйл, төлөөллийг талархан зөвшөөрч дэмждэг байна.	ҮАУ 194, ҮАУ 195

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэ үзүүлэлт нь Тогтвортой хөгжлийн хэд хэдэн зорилго, зорилттой нийцэж байна. Уламжлалт мэдлэгийг хамгаалах талаарх Үнэлгээ хийх хүчин зүйл 14.1 нь 'генетикийн нөөц баялаг, уламжлалт холбогдох мэдлэгийг ашигласнаар гарах үр шимийг хүртэх, эрх тэгш, шударга зарчмаар солилцох нөхцөлийг бүрдүүлэх'-ийг дэмжиж буй ТХЗ-ын Зорилт 2.5-тэй нийцэж байгаа бөгөөд үүнтэй ижил утга агуулга бүхий ТХЗ-ын Зорилт 15.6-тай мөн нийцэж байна. Ялангуяа эмэгтэйчүүдийн уламжлалт эрхийг ТХЗ-ын Зорилт 5.а-д оруулсан бөгөөд тэдний 'газар, ... болон байгалийн баялгийг өмчлөх, захиран зарцуулах, хүртэх боломжийг олгох' гэсэн уриалгатай нийцэж байгаа юм. Үнэлгээ хийх хүчин зүйл 14.3 нь 'бүх түвшний чадавхийг бэхжүүлэх ... хүчирхийллээс урьдчилан сэргийлэх' асуудалд чиглэсэн ТХЗ-ын Зорилт 16.а-г дэмжин нөхөж байна. Ерөнхий хүрээнд Үзүүлэлт 14 нь ТХЗ-ын Зорилт 17.14 ('тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа холбоог сайжруулах') ба ТХЗ-ын Зорилт 17.15 ('ядуурлыг арилгах, тогтвортой хөгжлийн бодлого тогтоох, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байгаа аливаа улс орны бодлогын орон зай, манлайллыг хүндэтгэх') дахь асуудлыг хөндөн авч үзэж байна. Энэхүү үзүүлэлт нь 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй мөн нийцэж байна.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэхүү үзүүлэлт нь соёлын салбар (Үзүүлэлт 11), боловсролын салбар (Үзүүлэлт 12) болон тогтвортой хөгжлийн бусад салбаруудад чиглэсэн бодлогын талаар холбогдох бусад салбаруудыг дэмжин нөхөж байна. Үзүүлэлт 15, 16 нь эдгээр бодлогыг, ялангуяа тогтвортой хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөөнд хэрхэн уялдуулж байгаад төвлөрч байгаа бол энд бодлогын агуулга гэхээсээ илүү бодлогын орчин нөхцлийг онцолдог. Үзүүлэлт 17 нь хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн СББӨ-ийн талаархи мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд тэдний эрхийг хамгаалахтай холбогддог.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Энэ үзүүлэлт нь ‘[СББӨ]-ийн хамгаалалтыг төлөвлөлтийн хөтөлбөрт нэгтгэх’ ач холбогдлыг онцлон уриалдаг Конвенцийн Зүйл 13-тай нийцэж байна. Дэлхий даяар олон улс орнууд уламжлалт ёс, зан үйл, илэрхийллийг хууль эрх зүй, бодлогын илүү өргөн хүрээнд нэгтгэх нь илүү ашигтай гэж үзэж, энэ нь илүү эрх тэгш байдал, иргэний оролцоонд хувь нэмэр оруулдаг болохыг онцолжээ. Хамт олон, бүлгүүд өөрсдийн СББӨ-ийн нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрдөг тийм уламжлалт тогтолцоо нь тогтвортой хөгжлийн чухал хөшүүрэг болдог гэж үздэг. Нутгийн уугуул иргэдийн талаарх НҮБ-ын түнхлалд (Зүйл 31) тэдний "соёлын өв, уламжлалт мэдлэг, уламжлалт соёлын илэрхийллийг сахин хадгалах, захиран зарцуулах, хамгаалах, хөгжүүлэх эрх", түүнчлэн тэдгээрийн холбогдох оюуны өмчид онцгой анхаарал хандуулдаг. Олон улс орон болон олон улсын байгууллагууд шударга ёсыг хэрэгжүүлэх, маргааныг шийдвэрлэхэд нутгийн болон албан бус уламжлалыг өөрсдийн бодлого, шударга ёсны тогтолцоонд нэвтрүүлж ирсэн байдаг. Түүнчлэн НҮБ-ын Биологийн олон янз байдлын тухай Конвенцийн Зүйл 8(j)-д биологийн олон янз байдлыг хангахад уугуул болон орон нутгийн иргэдийн мэдлэг, зан үйл болон инновацийн ач холбогдлыг онцлон тэмдэглэдэг.

Түлхүүр нэр томъёо

- Бодлого
- Хууль эрх зүйн арга хэмжээ
- Захиргааны арга хэмжээ
- Уламжлалт эрх
- Уламжлалт зан үйл
- Оюуны өмчийн эрх
- Нууцлалын эрх
- Өвлөн үйлдэгч ба өвлөн уламжлагч нар
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

Энэхүү үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь тухайн Оролцогч улсад уламжлалт ёс, зан үйл, илэрхийлэл нь хууль эрх зүй, бодлогын илүү өргөн хүрээнд үр дүнтэй уялдсан эсэх, хэрэв үгүй бол тэгэж хийх арга замыг тодорхойлж чадах боломжийг олгоно. Ийм үзлэг шалгалт нь хамт олон, бүлэг, хувь хүмүүс өөрсдийнх нь СББӨ-ийг ашиглаж тэднийг шударга бус буюу нөхөн төлбөргүй мөлжлөгт өртөх эрсдэлд оруулах, эсвэл тэд оршин тогтнохын тулд СББӨ-өө эзэмшин үйлдэх, өвлөн уламжлахыг үргэлжлүүлэхэд шаардлагатай экосистемд хамаарах уламжлалт эрхийг сулруулах тийм алдаа дутагдал, доголдлыг илрүүлж тодорхойлоход тус болно. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь янз бүрийн улс орнуудад шинэлэг байдлаар хэрэгжиж ирсэн сайн туршлагыг харуулж, энх тайвны соёлыг төлөвшүүлэхэд СББӨ-ийн ач холбогдлыг нотолж, СББӨ-ийн эрх зүйн хамгаалалтын дэлхийн систем, уламжлалт соёлын илэрхийллийг дэмжиж чадах юм.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Эдгээр салбарт баримтлах бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ нь шударга ёс, хөдөө орон нутгийн хөгжил, хүрээлэн буй орчин, оюуны өмчийг хамгаалах зэрэг асуудал эрхэлдэг яамдын хамрах хүрээнд хамаарч болно. Эдгээр яамдын төлөөллийг оролцуулсан зөвлөлдөх байгууллага буюу зохицуулалтын механизм байж болно. Хэрэв байхгүй бол үзлэг шалгалт хийх эрх бүхий баг холбогдох яамдтай холбоо барьж, ийм бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлж байгаа эсэхийг тодруулах шаардлагатай болж магадгүй юм.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Хууль, эрх зүйн зохицуулалтын албан ёсны сэтгүүл эсвэл эмхэтгэл
- Холбогдох яамдын бодлогын баримт бичиг
- Оролцогч улсаас НҮБ-ын Биологийн олон янз байдлын тухай Конвенцийн Зүйл 8(i)-ын дагуу гаргаж өгсөн тайлан
- Таван жилийн төлөвлөгөө, арван жилийн төлөвлөгөө гэх мэт үндэсний тогтвортой хөгжлийн стратеги
- Хөгжлийн бодлогыг судалж буй эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн хийсэн судалгаа, тайлан

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	15. Нийгэм дэх СББӨ-ийн ач холбогдол, түүний хамгаалалтыг хамт олон, бүлэг, хувь хүмүүс болон нийгэм бүхэлдээ аль хэр хүлээн зөвшөөрч байгаа байдал (хүрсэн түвшин)	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	15.1 Хамт олон, бүлэг, хувь хүмүүс СББӨ-өө тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг оруулаад өөрсдийн сайн сайхны төлөө ашигладаг байна.	
	15.2 Хамт олон, бүлэг, хувь хүмүүс өөрсдийн СББӨ-ийг харилцан ойлголцох, харилцан хүндлэх, зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг бэхжүүлэхэд чиглэсэн яриа хэлэлцээрт ашигладаг байна.	
	15.3 Хөгжлийн арга хэмжээнүүд нь СББӨ бол нийгэмд түүний өвөрмөц онцлог, залгамж холбоо, мэдлэг, үр чадварын эх ундарга нь болж байдаг ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, тогтвортой хөгжлийг хангах нөөц бололцоо болгон бататган бэхжүүлдэг байна.	ҮАУ-ын 170, ҮАУ-ын 173
ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь сайн сайхан аж байдал, тогтвортой хөгжилтэй холбоотой асуудалд төвлөрдөг ба ТХЗ: Зорилго 1 ('ядуурлыг бүх хэлбэрээр бүхэлд нь устгах') ба ТХЗ: Зорилго 3 ('бүх нийтийн насан туршийн эрүүл амьдралыг баталгаажуулж, сайн сайхан байдлыг дэмжих')-ийг бүрэн хангаж байна. Хүний сайн сайхан аж байдлыг ТХЗ: Зорилт 9.1-д дэд бүтцийн хувьд авч үзсэн бол мөргөлдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг тогтоох асуудлыг ТХЗ: Зорилт 16.2-ын "хууль дээдлэхийг дэмжиж, шударга ёсыг хүн бүрт тэгш хүртээмжтэй байлгах" гэсэн хүчин зүйлээр авч үзэж байна. Бүх үзүүлэлтүүдийн нэгэн адил 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-тэй мөн нийцэж байна.</p> <p>Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Үзүүлэлт 11-14 нь бодлогын орчныг авч үзсэн бол Үзүүлэлт 15 нь эдгээр бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг хэр үр дүнтэй хэрэгжүүлж байгааг онцлон харуулдаг.</p>	

Үйл ажиллагаа явуулах үндэслэл	СББӨ-ийн нийгэм дэх ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн энэхүү үзүүлэлт нь СББӨ нь тогтвортой хөгжил, хүний сайн сайхан аж байдалд хэрхэн хувь нэмэр оруулж болохыг харуулсан болно. Энэ нь хүний эрх, нийгмийн шударга ёсны хэмжүүрийг агуулдаг. Конвенцид 'нийгэмд соёлын биет бүс өвийн үүргийг дээшлүүлэхэд чиглэсэн ерөнхий бодлого баталж, энэхүү өвийн хамгаалалтыг төлөвлөж буй хөтөлбөрүүдэд тусгах' тухай өгүүлсэн болно (Зүйл 13(a)). Гэсэн хэдий ч бодлого боловсруулалт, хөгжлийн төлөвлөлт нь оюун санааны хийсвэр бодол дасгал биш, харин хөтөлбөр, үйл ажиллагаанд тусгаж хөрвүүлснээр л үр дүндээ хүрч чадна гэдгийг санах хэрэгтэй. Энд ийм бодлого байж болох эсэх талаар бус, харин СББӨ-ийг хүмүүсийн сайн сайхан аж байдлыг сайжруулах зорилгоор ашиглаж байгаа эсэхэд үнэлгээ хийх нь гол зорилго юм.
Түлхүүр нэр томъёо	<ul style="list-style-type: none"> • Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс • Тогтвортой хөгжил

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

Энэ үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь хамт олон, бүлэг, хувь хүмүүс өөрсдийн сайн сайхан аж байдал, амьдралын чанарыг дээшлүүлэх бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээнүүдээс хэр зэрэг ашиг тусыг хүртэх боломжтой болохыг олж мэдэх боломжтой юм (Үнэлгээ хийх хүчин зүйл 15.1 ба 15.2). Түүнчлэн, Үнэлгээ хийх хүчин зүйл 15.3-т үзлэг шалгалт хийхэд оролцогч улсууд бодит хөгжлийн арга хэмжээ авахдаа бодлогын хүрээнд тодорхойлсон зорилгод нийцэж байгаа эсэх, СББӨ-ийг хэрхэн тогтвортой хөгжлийн эх үүсвэр болгон ашиглаж чадаж байгааг үзэж шалгаж болно. Зэвсэгт мөргөлдөөнтэй байгаа эсвэл тулгарч болзошгүй улс орнуудад энэ үзүүлэлтэд үзлэг шалгалт явуулах нь мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх ба/эсвэл мөргөлдөөний дараахь эвлэрэлд хувь нэмэр оруулах болно. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт явуулах нь дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж буй бүтээлч стратеги, үйл ажиллагааг тодорхойлж, үр дүнтэй сайн туршлагын жишээг санал болгож, улмаар олон улсын хамтын ажиллагаа, солилцооны боломжийг нээж өгөх боломжтой юм.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Үзлэг шалгалт явуулах, тайлан гаргах үүрэг бүхий хүмүүс СББӨ-тэй холбоотой үйл ажиллагааны бодит жишээг олж тодорхойлохын тулд өргөн хүрээнд мэдээллийн эх сурвалжийг хайж олох шаардлагатай болж магадгүй юм. СББӨ-ийг хамгаалах чиглэлийн янз бүрийн оролцогчдын дунд явуулсан судалгаа, эсвэл хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний ажлын тойм зэрэг нь мэдээлэл цуглуулах чухал хэрэгсэл байж болох талтай. Өргөн хүрээг хамарсан зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизм нь энэ үзүүлэлтэд чухал мэдээллийн эх үүсвэр болно.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- ТББ, хамт олны холбоод болон бусад оролцогчдын үйл ажиллагааны талаарх тайлан
- Мэргэжлийн холбоодын мэдээллийн товхимол, эмхэтгэл, цахим хуудас, эсвэл судлаачдын сүлжээ
- Хамт олонд түшиглэсэн санал санаачилга эсвэл бусад хамгаалалтын арга хэмжээний талаар түгээн сурталчилсан хэвлэлийн мэдээ, мэдээлэл

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт

16. Бүх нийтийн оролцоог хангасан төлөвлөгөө, хөтөлбөрүүд нь СББӨ-ийн ач холбогдол, түүний хамгаалалтыг хүлээн зөвшөөрч, өөрийгөө болон харилцан хүндлэх явдлыг хэр зэрэг дэмжиж байгаа байдал (хүрсэн түвшин)

Үнэлгээ хийх хүчин зүйлүүд

Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний хоёр хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:

16.1 СББӨ-ийн хамгаалалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүд нь нийгмийн бүх салбар, давхаргыг хамардаг байх. Үүнд: <ul style="list-style-type: none"> • нутгийн уугуул иргэд; • өөр хоорондоо онцлог ялгаа бүхий угсаатны бүлгүүд; • шилжин суурьшигчид, цагаачид, дүрвэгсэд; • янз бүрийн насны хүмүүс; • янз бүрийн хүйсийн хүмүүс; • хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс; • эмзэг бүлгийн гишүүд. 	<p>ҮАУ 100, ҮАУ 102, ҮАУ 174, ҮАУ 194 ЁЗЗ 1, ЁЗЗ 2, ЁЗЗ 4, ЁЗЗ 9, ЁЗЗ 10</p>
16.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран зарим онцгой өвийн зүйлийг ба/эсвэл СББӨ-ийг бүхэлд нь хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн дунд өөрсдийгөө хүндлэх, бие биенээ харилцан хүндлэх харилцаа бий болсон байна.	<p>Зүйл 1, Зүйл 2, Зүйл 14(а) ҮАУ 100, ҮАУ 107, ҮАУ 155</p>

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Үзүүлэлт 16 нь ТХЗ-ын хэд хэдэн зорилтыг хангаж байгаа бөгөөд, үүнд 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4, 'бүх улс орнуудад хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах' гэсэн Зорилт 11.3 багтаж байна. Үүнээс гадна, 'шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах' гэсэн ТХЗ-ын Зорилт 5.5, 'бүх түвшинд жендерийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжих, бүх охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх'-ийг уриалсан ТХЗ-ын Зорилт 5.с-г хөхүүлэн дэмжиж байна. 'Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриасаа үл хамааран хүн бүрийг нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангаж, дэмжих' гэсэн уриалга бүхий ТХЗ-ын Зорилт 10.2-т бүх нийтийн оролцоог хангаж байгаа нь илүү өргөн хүрээнд тусгагдсан бол ТХЗ-ын Зорилт 10.3-т 'тэгш боломж боллоцоог бүрдүүлж, тэгш бус байдлыг бууруулах' арга замыг эрэлхийлж байна. Эцэст нь ТХЗ-ын Зорилт 10.7-д 'хүмүүсийн зохион байгуулалттай, аюулгүй, байнгын, хариуцлагатай шилжилт хөдөлгөөнийг дэмжих' хэрэгцээ шаардлагыг онцолжээ.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэхүү үзүүлэлт нь хөндлөн огтлолын шинжтэй бөгөөд бүх нийтийн оролцоот байдал, тэгш байдлын ерөнхий зарчмуудыг тодорхойлж, өөрийгөө болон харилцан хүндлэхийг дэмжих үндсэн зорилготой бөгөөд энэ нь хамгаалалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг тэдний хамрах хүрээ, анхаарал төвлөрч буй онцлогоос үл хамаарах үнэт зүйлс гэж үзэж байна. Тиймээс СББӨ-ийг ерөнхийд нь эсвэл СББӨ-ийн онцгой өвийн зүйлийг хамгаалахаас үл хамааран хамгаалалтын төлөвлөгөөтэй холбогдож байгаа учир Үзүүлэлт 11-ийг дэмжиж байна. Нэмж дурдахад Үзүүлэлт 17-20-ийн үндэс суурь болох СББӨ-ийн ач холбогдол, түүний хамгаалалтын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх тухай, мөн СББӨ-ийн хамгаалалтын хөтөлбөрт үзлэг шалгалт хийхэд төвлөрч буй Үзүүлэлт 22-той уялдаж байна.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Энэхүү үзүүлэлт нь Соёлын биет бус өвийг хамгаалах ёс зүйн зарчмуудад тусгагдсан Конвенцийн үндсэн зарчмуудтай холбоотой юм. Конвенц дахь ‘хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн хоорондын харилцан хүндлэл’-ийг хангах гэсэн шаардлага нь Конвенцийн СББӨ-ийн тодорхойлолтод тусгагдсан бөгөөд (Конвенцийн Зүйл 2.1), Конвенцийн зорилгод ‘холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн соёлын биет бус өвийг хүндэтгэх’ (Зүйл 1(б)) гэж дурдсан нь эдгээр хүмүүсийг болон тэдний СББӨ-ийг хүндэтгэхийг хэлж байна. Бүх нийтийн оролцоог хангах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмууд нь ЮНЕСКО болон НҮБ-ын хувьд үндсэн үнэт зүйл нь бөгөөд Үйл Ажиллагааны Удирдамж, Ёс Зүйн Зарчимд дахин дурдсан байдаг. Зүйл 15 нь СББӨ-ийн хамгаалалт, менежментэд ‘хамт олон, бүлгүүд, шаардлагатай бол хувь хүмүүс’-ийг өргөн цар хүрээгээр оролцуулах тухай дурдсан нь мөн адил бүх нийтийг хамруулах зарчмын үнэ цэнийг агуулсан болно.

Үндсэн нэр томъёо

- Бүх нийтийн оролцоот / бүх нийтийг хамруулсан
- Нийгмийн салбар, давхарга
- Уугуул иргэд
- Янз бүрийн угсаатны онцлог бүхий бүлгүүд
- Шилжин суурьшигчид, цагаачид, дүрвэгсэд
- Янз бүрийн хүйсийн хүмүүс
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
- Эмзэг бүлгийнхэн
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс
- СББӨ-ийн зүйлүүд
- Бүртгэгдсэн (Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран)

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

Үзлэг шалгалт нь тухайн улсын СББӨ-ийн хамгаалалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүд нь бүх нийтийн оролцоог хэр зэрэг бүрэн дүүрэн хангаж байгаа, хамт олон, бүлгүүд, эсвэл хувь хүмүүсийн оролцоог хамгийн өргөн хэмжээнд хүргэхэд тулгарч буй саад бэрхшээл байж болох эсэхийг тодорхойлоход тусалдаг. Түүгээр ч зогсохгүй үзлэг шалгалт явуулах нь Оролцогч улсад авч хэрэгжүүлж буй хамгаалалтын үйл ажиллагаа нь Конвенцийн дагуу өөрийгөө болон харилцан хүндлэлд хувь нэмэр оруулж чадаж байгаа эсэхийг тогтооход тусална. Энэ нь Оролцогч улсад хамгаалалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь хүсээгүй болон сөрөг нөлөөтэй байж болзошгүй тохиолдлуудыг олж тогтооход тус болно. Дэлхийн хэмжээнд энэ үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь Оролцогч улсад Конвенцийн хамрах хүрээ, оролцооны тогтолцоонд ямар нэгэн системийн болон хүсээгүй алдаа дутагдал байгаа эсэхийг тодорхойлж өгч, өөрийгөө болон харилцан хүндлэлийг ямар нэг байдлаар бүүруулах бус харин бэхжүүлж байгаа гэдэгт итгэлтэй байхад нь тусалж чадна.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Үзүүлэлт 15-ын адил үзлэг шалгалт хийх, тайлагнах үүрэг бүхий хүмүүс олон улсын мэдээллийн эх үүсвэрийг судалж, СББӨ-ийн хамгаалалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд бүх нийтийн оролцоот байдлыг хэрхэн хангаж байгаа талаар бодит жишээг олж тогтоох хэрэгтэй. СББӨ-ийг хамгаалах чиглэлээр янз бүрийн оролцогчдын дунд явуулсан судалгаа, эсвэл хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний ажлын тойм зэрэг нь мэдээлэл цуглуулах чухал хэрэгсэл байж болох юм. Зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизм нь хэрэв байгаа бол энэ үзүүлэлтэд чухал мэдээллийн эх үүсвэр болно.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Конвенцийн аль нэг жагсаалтад эсвэл үндэсний жагсаалтад бүртгэгдсэн СББӨ-ийн зүйлүүдийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайлан
- ТББ, хамт олны холбоод болон бусад оролцогчдын хамгаалалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн талаарх тайлан
- Мэргэжлийн холбоод, эсвэл судлаачдын сүлжээний мэдээллийн товхимол, эмхэтгэл эсвэл цахим хуудас
- Хамгаалалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн талаарх хэвлэлийн мэдээ, мэдээлэл

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	17. СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хамт олон, бүлэг, хувь хүмүүс аль хэр өргөнөөр оролцож байгаа байдал (хүрсэн түвшин)											
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	<p>Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний таван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:</p> <table border="1"> <tr> <td data-bbox="354 524 1081 675">17.1 Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн бүх нийтийн оролцоог боломжийн хэрээр хамгийн өргөн цар хүрээгээр хамруулахаар тусгадаг байна.</td> <td data-bbox="1093 524 1268 675">YAY 101</td> </tr> <tr> <td data-bbox="354 682 1081 833">17.2 Соёлын биет бус өвийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулахдаа холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсээс тэдэнд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр дэмжсэн зөвшөөрөл авч баталгаажуулдаг байна.</td> <td data-bbox="1093 682 1268 833">YAY 101</td> </tr> <tr> <td data-bbox="354 840 1081 1008">17.3 СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд тухайн хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн эрх, тэдний ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхлыг зохих ёсоор хамгаалдаг байна.</td> <td data-bbox="1093 840 1268 1008">YAY 101(b), YAY 101(d), YAY 104, YAY 171 Ё33 7</td> </tr> <tr> <td data-bbox="354 1015 1081 1130">17.4 Залуучууд өөрсдийн хамт олон, бүлгийн соёлын биет бус өвийн талаарх мэдээлэл цуглуулах, түгээх зэрэг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйлсэд идэвхитэй оролцдог болсон байна.</td> <td data-bbox="1093 1015 1268 1130">Зүйл 14(a)(i) YAY 107(f)</td> </tr> <tr> <td data-bbox="354 1137 1081 1279">17.5 Хамт олон, бүлэг, хувь хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны технологи, мэдээллийн бүх хэлбэр, ялангуяа шинэ мэдээллийн хэрэгслийг СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд ашигладаг байна.</td> <td data-bbox="1093 1137 1268 1279"></td> </tr> </table>		17.1 Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн бүх нийтийн оролцоог боломжийн хэрээр хамгийн өргөн цар хүрээгээр хамруулахаар тусгадаг байна.	YAY 101	17.2 Соёлын биет бус өвийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулахдаа холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсээс тэдэнд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр дэмжсэн зөвшөөрөл авч баталгаажуулдаг байна.	YAY 101	17.3 СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд тухайн хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн эрх, тэдний ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхлыг зохих ёсоор хамгаалдаг байна.	YAY 101(b), YAY 101(d), YAY 104, YAY 171 Ё33 7	17.4 Залуучууд өөрсдийн хамт олон, бүлгийн соёлын биет бус өвийн талаарх мэдээлэл цуглуулах, түгээх зэрэг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйлсэд идэвхитэй оролцдог болсон байна.	Зүйл 14(a)(i) YAY 107(f)	17.5 Хамт олон, бүлэг, хувь хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны технологи, мэдээллийн бүх хэлбэр, ялангуяа шинэ мэдээллийн хэрэгслийг СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд ашигладаг байна.	
17.1 Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн бүх нийтийн оролцоог боломжийн хэрээр хамгийн өргөн цар хүрээгээр хамруулахаар тусгадаг байна.	YAY 101											
17.2 Соёлын биет бус өвийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулахдаа холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсээс тэдэнд урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр дэмжсэн зөвшөөрөл авч баталгаажуулдаг байна.	YAY 101											
17.3 СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд тухайн хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн эрх, тэдний ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхлыг зохих ёсоор хамгаалдаг байна.	YAY 101(b), YAY 101(d), YAY 104, YAY 171 Ё33 7											
17.4 Залуучууд өөрсдийн хамт олон, бүлгийн соёлын биет бус өвийн талаарх мэдээлэл цуглуулах, түгээх зэрэг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйлсэд идэвхитэй оролцдог болсон байна.	Зүйл 14(a)(i) YAY 107(f)											
17.5 Хамт олон, бүлэг, хувь хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны технологи, мэдээллийн бүх хэлбэр, ялангуяа шинэ мэдээллийн хэрэгслийг СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд ашигладаг байна.												
ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-ийг дэмжиж, 'бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох' гэсэн ТХЗ-ын Зорилт 16.7-д хувь нэмэр оруулж байна. Эмэгтэйчүүд нь хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн чухал хэсэг болохыг онцлоод тэдний 'эрх мэдлийг нэмэгдүүлж хүчирхэгжүүлэхэд мэдээлэл, харилцаа холбооны технологийг хэрэглэх явдлыг сайжруулах'-д чиглэсэн ТХЗ-ын Зорилт 5.b-г дэмжиж байна.</p>											

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхтэй холбоотой дөрвөн үзүүлэлтийн нэг болох энэ үзүүлэлт нь Үзүүлэлт 18-20-ыг дэмжиж байна. Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд хамт олон, бүлгүүд, хувь хүмүүсийн өргөн оролцоо, тэдний эрх, ашиг сонирхлыг хамгаалахад энд гол анхаарлаа хандуулж байна. Үзүүлэлт 18 нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэгт анхаарлаа төвлөрүүлдэг бол; Үзүүлэлт 19 нь мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээний агуулга, зорилгыг авч үздэг бөгөөд Үзүүлэлт 20 нь эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэлбэр, ялангуяа холбогдох ёс зүйн зарчимд нийцэж буй байдалтай холбоотой юм.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Конвенцийн дөрвөн зорилгын нэг нь 'соёлын биет бус өв, түүнийг харилцан хүлээн зөвшөөрөхийн чухлыг орон нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд ойлгуулах' явдал юм (Зүйл 1(c)). Нэмж дурдахад улс орнууд 'Нийгэмд соёлын биет бус өвийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэхээс гадна түүний үүргийг нь дараах арга замаар дээшлүүлнэ: (i) 'олон нийтэд, ялангуяа залуучуудад зориулсан боловсрол, ойлголтыг дээшлүүлэх, мэдээллийн хөтөлбөрөөр' хангахыг уриалж байна (Зүйл 14(a)). Конвенц нь 'тухайн өвийг бүтээх, хамгаалах, өвлүүлэх үйлсэд хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүсийг аль болох өргөнөөр оролцуулах'-ыг уриалж байна (Зүйл 15). Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх замаар ийм үр дүнд хэрхэн хүрч болох талаар Үйл Ажиллагааны Удирдамжийн Бүлэг IV-д, ялангуяа 100-117 дугаар удирдамжуудад тусгасан болно. Энэхүү үзүүлэлт нь мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг бүх нийтийн оролцоог хангаж, холбогдох ёс зүйн зарчмыг баримталж хэрхэн авч хэрэгжүүлж хийх ёстойг харуулж байна.

Үндсэн нэр томъёо

- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс
- Оролцоо
- Бүх нийтийн оролцоот / бүх нийтийг хамруулсан
- Урьдчилан мэдээлж ойлгуулсны үндсэн дээр авсан зөвшөөрөл
- СББӨ-ийн зүйлүүд
- Ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхол
- Түгээн дэлгэрүүлэх
- Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХТ)

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

<p>Үзлэг шалгалт хийх ашиг тус</p>	<p>Энэхүү үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь тухайн улс орон СББӨ-ийн ач холбогдлын талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг Конвенц болон Үйл Ажиллагааны Удирдамжид нийцүүлэн хэрхэн явуулж байгааг тодорхойлоход тусална. Үзлэг шалгалт нь ийм үйл ажиллагаа нь хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн оролцоог бүх нийтийн хүрээнд хангаж байгаа эсэх, сайн дурын оролцоотой эсэхийг үнэлэх боломжтой. Энэ нь залуу хүмүүсийг татан оролцуулж, хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн эрх, ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхлыг бүрэн хамгаалахад тусалж чадна. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь энэ чиглэлийн шинэлэг үйл ажиллагаа, хандлагад анхаарлаа хандуулж болно.</p>
<p>Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах</p>	<p>Ихэнх тохиолдолд мэдээллийн чухал эх сурвалж нь мэдээлэл, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн салбар дахь Оролцогч улсын удирдах түвшний байгууллагууд байж болно. Хэрэв Оролцогч улс нь зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизмтай бол үүнд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид эсвэл мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд идэвхтэй бүй бусад хүмүүсийг багтааж болох бөгөөд тэд нэмэлт мэдээлэл өгөх боломжтой. Үнэлгээ хийх хүчин зүйлс 17.2 ба 17.3-т мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх зарчмуудыг тодорхойлсон хэвлэн нийтлэх ёс зүйн дүрэм, удирдамжийг дурдаж болно. Ихэнх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхтэй холбоотой мэдээ, мэдээлэл нь олон нийтэд хандсан шинж чанартай байдаг тул мэдээлэл нь өргөн олдоцтой.</p> <p>Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд</p> <ul style="list-style-type: none"> ● Хэвлэл мэдээлэл, тайлан, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх материалын цуглуулга ● Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд оролцдог хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хэвлэн нийтлэх болон бусад зохицуулалтын ёс зүйн дүрэм, удирдамж ● Оюуны өмчийн талаархи хууль тогтоомж, бодлогын хэрэгслүүд ● Мэдээлэл, харилцаа холбоо, залуучуудын асуудал эрхэлсэн яамд, тэдгээрийн цахим хуудас, тайлан ● Цахим хуудас, блог, видео бүртгэл, олон нийтийн цахим сүлжээгээр байршуулсан мэдээлэл ● Олон нийтийн цахим сүлжээн дэх бүлэг, хамт олнууд

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

<p>Үзүүлэлт</p>	<p>18. СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, харилцан ойлголцол болон хүндлэлийг хөхүүлэн дэмжихэд хэвлэл мэдээлэл хэр зэрэг оролцож байгаа байдал (хүрсэн түвшин)</p>									
<p>Үнэлгээ хийх хүчин зүйлүүд</p>	<p>Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний дөрвөн хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:</p> <table border="1"> <tr> <td data-bbox="1828 529 2540 675"> <p>18.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн харилцан хүндлэлийг хөхүүлэн дэмждэг байна.</p> </td> <td data-bbox="2555 529 2710 675"> <p>ҮАУ 111, ҮАУ 112, ҮАУ 113</p> </td> </tr> <tr> <td data-bbox="1828 684 2540 829"> <p>18.2 СББӨ-ийн чиглэлээрх оролцогч талууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хооронд СББӨ-ийн талаарх тодорхой хамтын ажиллагаа тогтоон, хөтөлбөрүүд байгуулж, хэрэгжүүлж, чадавхийг бэхжүүлдэг байна.</p> </td> <td data-bbox="2555 684 2710 829"></td> </tr> <tr> <td data-bbox="1828 839 2540 984"> <p>18.3 СББӨ-ийн талаарх медиа програмчлал нь бүх нийтэд хүртээмжтэй бөгөөд холбогдох хамт олон, бүлгүүдийн хэлээр, мөн/эсвэл өөр өөр зорилтот бүлгүүдэд зориулан эрхлэн ажиллуулдаг байна.</p> </td> <td data-bbox="2555 839 2710 984"> <p>ҮАУ 112, ҮАУ 113</p> </td> </tr> <tr> <td data-bbox="1828 993 2540 1093"> <p>18.4 Соёлын биет бус өв, түүнийг хамгаалах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээлэл нь Конвенцийн үзэл санаа, нэр томъёог баримталдаг байна.</p> </td> <td data-bbox="2555 993 2710 1093"></td> </tr> </table>		<p>18.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн харилцан хүндлэлийг хөхүүлэн дэмждэг байна.</p>	<p>ҮАУ 111, ҮАУ 112, ҮАУ 113</p>	<p>18.2 СББӨ-ийн чиглэлээрх оролцогч талууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хооронд СББӨ-ийн талаарх тодорхой хамтын ажиллагаа тогтоон, хөтөлбөрүүд байгуулж, хэрэгжүүлж, чадавхийг бэхжүүлдэг байна.</p>		<p>18.3 СББӨ-ийн талаарх медиа програмчлал нь бүх нийтэд хүртээмжтэй бөгөөд холбогдох хамт олон, бүлгүүдийн хэлээр, мөн/эсвэл өөр өөр зорилтот бүлгүүдэд зориулан эрхлэн ажиллуулдаг байна.</p>	<p>ҮАУ 112, ҮАУ 113</p>	<p>18.4 Соёлын биет бус өв, түүнийг хамгаалах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээлэл нь Конвенцийн үзэл санаа, нэр томъёог баримталдаг байна.</p>	
<p>18.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн харилцан хүндлэлийг хөхүүлэн дэмждэг байна.</p>	<p>ҮАУ 111, ҮАУ 112, ҮАУ 113</p>									
<p>18.2 СББӨ-ийн чиглэлээрх оролцогч талууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хооронд СББӨ-ийн талаарх тодорхой хамтын ажиллагаа тогтоон, хөтөлбөрүүд байгуулж, хэрэгжүүлж, чадавхийг бэхжүүлдэг байна.</p>										
<p>18.3 СББӨ-ийн талаарх медиа програмчлал нь бүх нийтэд хүртээмжтэй бөгөөд холбогдох хамт олон, бүлгүүдийн хэлээр, мөн/эсвэл өөр өөр зорилтот бүлгүүдэд зориулан эрхлэн ажиллуулдаг байна.</p>	<p>ҮАУ 112, ҮАУ 113</p>									
<p>18.4 Соёлын биет бус өв, түүнийг хамгаалах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээлэл нь Конвенцийн үзэл санаа, нэр томъёог баримталдаг байна.</p>										
<p>ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал</p>	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах асуудлыг хөндсөн ТХЗ-ын Зорилт 11.4-өөс гадна энэ үзүүлэлт нь 'төр, төр-хувийн хэвшил болон иргэний нийгмийн үр дүнтэй түншлэлийг хөхүүлэн дэмжиж, төлөвшүүлэх' гэсэн ТХЗ-ын Зорилт 17.17-д хариу үзүүлж байна.</p> <p>Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Үзүүлэлт 17 нь хамт олон, бүлэг, хувь хүмүүс, тэдний СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд тэдний үүрэг оролцооны талаар авч үзэж багаа бол энэ үзүүлэлт нь ийм мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хамгийн их анхаарал хандуулдаг салбар болох хэвлэл мэдээллийн үүрэг ролийг голчлон анхаарч байна. Үзүүлэлт 19 нь эргээд мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээний агуулга, зорилгыг авч үздэг бол 20-р үзүүлэлт нь ийм арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэлбэртэй холбоотой юм. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх (Үнэлгээ хийх хүчин зүйл 18.2) нь Үзүүлэлт 2, 3, 4-т тусгагдсан бусад сургалт, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаатай холбоотой үнэлгээнд нэмэлт үүрэг гүйцэтгэдэг. Төрөл бүрийн оролцогчдын хамгаалалтын хамтын ажиллагааг Үзүүлэлт 21-т тусгасан болно.</p>									

**Үйл ажиллагаа
явуулах
үндэслэл**

Үзүүлэлт 17-той холбоотойгоор дурдсан Конвенцийн дөрвөн зорилгын нэг нь ‘соёлын биет бус өв, түүнийг харилцан хүлээн зөвшөөрөхийн чухлыг орон нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд ойлгуулах’ явдал юм (Зүйл 1(с)). Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь хувийн хэвшлийнх ч бай, засгийн газрын ивээл дор ажилладаг ч бай энэ ажилд чухал үүрэг гүцэтгэдэг түншүүд юм. СББӨ-ийн оролцогч талууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаа эсвэл түншлэл нь бие биенээсээ үр чадвар, мэдлэг болон техникийн чадвар чадамжийн хүрээнд харилцан ашиг тусыг хүртэх боломжийг олгож байдаг. СББӨ-ийн талаархи мэдээлэл, түүнийг хамгаалахын ач холбогдлыг аль болох өргөн хүрээнд, нарийвчлалтай хүргэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн оролцоог бүрэн хангаж, өөр өөр хэл бүхий үзэгчдэд өөрсдийнх нь хэлээр хүргэхийг зорих хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн чадавхийг нэмэгдүүлэх нь Конвенц, түүний үзэл баримтлал, нэр томъёоны талаар хангалттай ойлголттой байх, СББӨ-ийг хамгаалах, харилцан хүндлэлийг бэхжүүлж, дэмжихэд үр дүнтэй хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

**Үндсэн нэр
томъёо**

- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс
- Оролцогч талууд
- Бүх нийтийн оролцоот / бүх нийтийг хамруулсан

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

**Үзлэг шалгалт
хийх ашиг тус**

Энэхүү үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь улс орнуудад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь өргөн хүрээний үр нөлөөллийг бий болгох, Конвенц, түүний үнэт зүйлийг үр дүнтэй сурталчлах, эсвэл санамсаргүй байдлаар холимог мессеж дамжуулах, тэр ч байтугай Конвенцид харшлах хандлагыг бий болгох боломж нөхцлүүдийг үнэлэхэд улс орнуудад туслах болно. Тиймээс Оролцогч улс нь Конвенцийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслээс оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх, чадавхийг бэхжүүлэх боломжийг эрэлхийлэх боломжтой болно. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь бусад оронд ижил төстэй хүчин чармайлтыг хөгжүүлэхэд түлхэц болох хамтын ажиллагааны сайн туршлага, загварыг тодорхойлоход тусална.

**Мэдээллийн
эх сурвалж
ба мэдээлэл
цуглуулах**

Олон нийтийн харилцааны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мөн чанараараа хүн амыг өргөн хүрээнд хамруулахыг эрмэлздэг тул үзлэг шалгалт хийх, тайлагнах үүрэг бүхий хүмүүс зорилтот хэрэглэгчдийн тоонд багтдаг тул боломжийн хэмжээний мэдээлэл олон нийтэд нээлттэй, амархан үзэж танилцах боломжтой. Хэрэв оролцогч улс нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөллийг хамруулсан зөвлөлдөх байгууллага буюу хамтын ажиллагааны механизмтай бол энэ нь хамтын ажиллагааны тодорхой тохиолдлуудын талаархи мэдээллийн эх сурвалж байх болно.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Телевиз, радиогийн нэвтрүүлэг, архив
- Сонин сэтгүүл
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудын цахим хуудсууд
- Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн яам, тэдгээрийн цахим хуудас, тайлан
- Хамтын ажиллагааны үйл ажиллагаа, түүний дотор чадавхийг бэхжүүлэх хөтөлбөртэй холбоотой санхүүжилт хүссэн өргөдөл, тайлан

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	19. Олон нийтийн мэдээллийн арга хэмжээ нь СББӨ-ийн ач холбогдол, түүний хамгаалалтын талаарх мэдлэг ойлголтыг аль хэр нэмэгдүүлдэг, харилцан ойлголцол болон хүндлэлийг хэр зэрэг хөхүүлэн дэмжиж байгаа байдал (хүрсэн түвшин)	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний дөрвөн хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	19.1 СББӨ-ийг өвлөн үйлдэгч, өвлөн уламжлагчдыг бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулж өөрсдийг нь оролцуулж олон нийтэд танилцуулан сурталчилж байна.	ҮАУ 105(d)
	19.2 СББӨ, түүний ач холбогдол, хамгаалалт, Конвенцийн талаар олон нийтийн арга хэмжээнүүдийг хамт олон, бүлэг, хувь хүмүүс, хүн ам, судлаачид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад оролцогч талуудад зориулан зохион байгуулдаг байна.	ҮАУ 105(b)
	19.3 Хамгаалалтын сайн туршлагыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг дэмждэг, тэтгэдэг байна.	ҮАУ 106
	19.4 СББӨ-ийн талаарх олон нийтийн мэдээлэл нь хамт олон, бүлгүүдийн дотор болон хоорондын харилцан хүндлэл, талархлыг дэмждэг байх.	Зүйл 14(a)(i)
ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь бусад үзүүлэлтүүдийн адил 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-ийг дэмжиж байна.</p> <p>Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэ үзүүлэлт нь мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, олон нийтэд мэдээлэх арга хэмжээний агуулга, зорилго, тэдгээрийн үр нөлөөг харгалзан үздэг. Үүгээр хамт олон, бүлэг, хувь хүмүүс ийм арга хэмжээнд идэвхтэй оролцохтой холбоотой Үзүүлэлт 17, мөн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүрэг ролийг голчлон харуулсан Үзүүлэлт 18-ыг дэмжин нөхөж байна. Үзүүлэлт 20 нь эсрэгээрээ түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэртэй холбоотой юм. Хамт олонд суурилсан хүчин чармайлт, хамгаалалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн орчин, агуулга дахь харилцан хүндлэл, талархлыг Үзүүлэлт 15, 16-д тусгасан болно. Хамгаалалтын сайн туршлагын талаарх олон улсын мэдээлэл солилцооны асуудлыг Үзүүлэлт 24-т тусгасан байна.</p>	

Үйл ажиллагаа явуулах үндэслэл	Үзүүлэлт 17, 18-д дурдсанчлан Конвенцийн дөрвөн зорилгын нэг нь 'соёлын биет бүс өв, түүнийг харилцан хүлээн зөвшөөрөхийн чухлыг орон нутаг, үндэстний болон олон улсын хэмжээнд ойлгуулах' явдал юм (Зүйл 1(c)). Оролцогч улс, хэвлэл мэдээллийн байгууллагууд эсвэл бусад оролцогчоос шууд хэрэгжүүлж байгаа эсэхээс үл хамааран орон нутгийн болон үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй хүчин чармайлтад энэ үзүүлэлт гол анхаарлаа хандуулж байна. Үйл Ажиллагааны Удирдамж нь олон нийтийн мэдээллийн ийм арга хэмжээ, тэдгээрийг хэрхэн хамгийн сайн хэрэгжүүлэх зарчмуудын асуудлыг тэргүүлэх чиглэлүүдээр тодорхойлсон бөгөөд үүнд: оролцоотойгоор, харилцан хүндлэл, талархлыг дэмжихийг зорих болон бүх нийтийн оролцоог хангасан байх гэсэн хүчин зүйлс хамаарна. Зүйл 19-ийн хүрээнд хамгаалалтын сайн туршлагыг сурталчлахад онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.
Түлхүүр нэр томъёо	<ul style="list-style-type: none"> ● Өвлөн үйлдэгч ба өвлөн уламжлагч ● Бодлого ● Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс ● Оролцогч талууд ● Түгээн дэлгэрүүлэх

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

Үзлэг шалгалт хийх нь олон нийтийн мэдээллийн арга хэмжээ нь зорилгодоо хүрч, хүссэн үр нөлөөгөө хэр зэрэг хангаж байгааг тодорхойлоход тусална. Үзлэг шалгалт нь мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь өвлөн үйлдэгч ба өвлөн уламжлагчдын ач холбогдлыг санамсаргүйгээр үл тоомсорлох, эсвэл харилцан хүндлэлийг сурталчлах бус харин санамсаргүйгээр сулруулж болзошгүй эсэх талаар Оролцогч улсад анхаарахад нь тусална. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх амжилттай стратегиудыг тодорхойлж болох бөгөөд хэрэв улс орнууд орон нутгийн болон үндэсний хэмжээнд хамгаалалтын сайн түршлагыг түгээн хэвшүүлж байгаа бол эдгээр сайн түршлэгүүд нь бусад улс орнуудад урам зориг өгөх эх үүсвэр болж болох юм.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Үзүүлэлт 17-той адилаар мэдээллийн чухал эх сурвалжийг мэдээлэл, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн салбарын эрх бүхий удирдах байгууллагууд эзэмшиж байж болно. Үзлэг шалгалт хийх, тайлагнах үйл ажиллагаанд хамрагдсан хүмүүс арга хэмжээ, түүний үр нөлөөг өөрсдийн түршлага дээр үндэслэн тайлагнах боломжтой. Хэрэв Оролцогч улс нь зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизмтай бол нэмэлт мэдээлэл өгөх чадвар бүхий мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд идэвхтэй оролцдог төлөөллийг бүрэлдэхүүндээ хамруулж болно.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Хэвлэл мэдээлэл, тайлан, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх материалын цуглуулга
- Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн яам, тэдгээрийн цахим хуудас, тайлан
- Цахим хуудас, блог, видео бүртгэл, олон нийтийн цахим сүлжээгээр байршуулсан мэдээлэл
- Олон нийтийн цахим сүлжээн дэх бүлэг, хамт олнууд

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт

20. СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд нь холбогдох ёс зүйн зарчмуудыг хэр зэрэг хүндлэн дээдэлж байгаа байдал (хүрсэн түвшин)

Үнэлгээ хийх хүчин зүйлүүд

Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний хоёр хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:

20.1 Соёлын биет бус өвийг хамгаалахтай холбоотой ёс зүйн зарчмуудыг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд хүндэтгэн авч үздэг байх.	ЁЗЗ
20.2 Ёс зүйн зарчмууд, ялангуяа холбогдох мэргэжлийн ёс зүй болон стандартуудад тусгагдсан зарчмуудыг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаандаа хүндэтгэн авч үздэг байх.	ҮАУ 103

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь бусад үзүүлэлтүүдийн адил 'дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 11.4-ийг дэмжиж байна.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэ үзүүлэлт нь мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлж буй арга хэлбэр, ялангуяа хэрэгжүүлэхдээ холбогдох ёс зүйн зарчмуудыг баримталж байгаа эсэхэд төвлөрч байна. Энэ нь мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхтэй холбоотой дөрвөн үзүүлэлтүүдийн багцыг хамран авч үзнэ (Үзүүлэлт 17-20). Үзүүлэлт 17 нь хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн өргөн оролцоог харуулдаг бол Үзүүлэлт 18 нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэгт анхаарлаа төвлөрүүлж, харин Үзүүлэлт 19 нь агуулга, нөлөөллийг авч үздэг. СББӨ-ийг хамгаалах ёс зүйн зарчмууд нь судалгаа шинжилгээ, баримтжуулалттай холбоотой тул Үзүүлэлт 9-д мөн хамааралтай; хөгжлийн төлөвлөгөө, бодлого, хөтөлбөрийн хүрээнд Үзүүлэлт 13-д; хувийн хэвшлийн хамгаалалтын хүчин чармайлтын хүрээнд Үзүүлэлт 21-д тус тус мөн хамаарч байна.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

Зүйл 1(с)-д заасны дагуу Конвенцийн дөрвөн зорилгын нэг нь 'соёлын биет бус өв, түүнийг харилцан хүлээн зөвшөөрөхийн чухлыг орон нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд ойлгуулах' явдал юм. СББӨ-ийг хамгаалах ёс зүйн зарчмууд нь мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөр зэрэг хамгаалалтын бүхий л хүчин чармайлтыг удирдан чиглүүлэх хэд хэдэн үндсэн үнэт зүйлийг тусгасан болно. Эдгээр зарчмууд нь сэтгүүлчид болон бусад хэвлэл мэдээллийн ажилтнууд, музейн мэргэжилтнүүд зэрэг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд оролцдог мэргэжлийн байгууллага, холбоодын гишүүдийн боловсруулсан ёс зүйн хэм хэмжээний дүрэм, стандартаар нөхөгдөж байдаг.

Түлхүүр нэр томъёо

- Соёлын биет бус өвийг хамгаалах ёс зүйн зарчим
- Мэргэжлийн ёс зүйн дүрэм эсвэл стандарт

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус	СББӨ-ийг хамгаалах ёс зүйн зарчим, бусад мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, стандартууд нь маш чухал ач холбогдолтой тул ёс зүйгүй үйл ажиллагаа, зан авир нь СББӨ-д өөрт нь болон түүнтэй холбоотой хамт олон, бүлэг, эсвэл хувь хүмүүст сөрөг үр дагавар авчирдаг. Үзлэг шалгалт нь ийм ёс зүйн зарчмуудыг хэр зэрэг хүндэтгэдэг болохыг үнэлэхэд эсвэл тухайн ёс зүйн зарчмуудыг бататгах, бэхжүүлэхийн тулд засч залруулах арга хэмжээ авах шаардлагатай байгааг Оролцогч улсад анхаарахад нь тусална. Дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт хийх нь ийм ёс зүйн зарчмуудын талаархи ерөнхий ойлголт хэр зэрэг байгааг, мөн чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлтыг ийм ойлголтыг бэхжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлж чадна.
Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах	Ихэнх тохиолдолд чухал мэдээллийн эх сурвалжийг мэдээлэл, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн салбарын эрх бүхий удирдах байгууллагууд эзэмшиж байж болно. Хэрэв Оролцогч улс нь зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизмтай бол үүнд мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд оролцогчдыг бүрэлдэхүүндээ хамруулж болох бөгөөд тэд нэмэлт мэдээлэл өгөх боломжтой. Холбогдох ёс зүйн зарчмыг дагаж мөрдөхгүй байх нь олон нийтийн маргаан, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрсдийн эрхийн хүрээнд ажиллахад хүргэж болзошгүй; Судлаачдын зүгээс мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажилд оролцож буй хүмүүс нь эдгээр зарчмуудад бүрэн хүндэтгэлтэй хандаагүй байж болох тохиолдлуудад анхаарлаа хандуулж болно. Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд <ul style="list-style-type: none"> ● Хэвлэл мэдээлэл, тайлан болон мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх материалын цуглуулга ● Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд оролцдог хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагын ёс зүйн дүрэм, удирдамж ● Хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн дунд тэдний СББӨ-ийн талаар хийсэн судалгааны үр дүн ● Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн яам, тэдгээрийн цахим хуудас, тайлан ● Цахим хуудас, блог, видео бүртгэл, олон нийтийн цахим сүлжээгээр байршуулсан мэдээлэл ● Олон нийтийн цахим сүлжээн дэх бүлэг, хамт олнууд

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	21. СББӨ-ийг хамгаалахад оролцогч талуудын оролцоог хэр зэрэг нэмэгдүүлж байгаа байдал (хүрсэн түвшин)	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	21.1 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийг ерөнхийд нь болон зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн бүх нийтийн оролцоог боломжийн хэрээр хамгийн өргөн хүрээгээр хамруулдаг байна.	Зүйл 15 ҮАУ 1, ҮАУ 2, ҮАУ 7, ҮАУ 79, ҮАУ 101(b), ҮАУ 171(a) ЁЗЗ 1, ЁЗЗ 2, ЁЗЗ 9
	21.2 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран СББӨ-ийг ерөнхийд нь болон зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад ТББ болон иргэний нийгмийн бусад оролцогчид өргөнөөр оролцдог байна.	ҮАУ 90, ҮАУ 108, ҮАУ 157(e), ҮАУ 158(b), ҮАУ 162(d), ҮАУ 163(b)
	21.3 Жагсаалтад бүртгэгдсэн эсэхээс үл хамааран хувийн хэвшлийн байгууллагууд СББӨ-ийг хамгаалахтай холбоотой ёс зүйн зарчмыг хүндэтгэн үзсэний үндсэн дээр СББӨ-ийг ерөнхийд нь болон зарим онцгой өвийн зүйлийг хамгаалахад оролцдог байна.	ҮАУ 187
ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь өргөн цар хүрээтэй оролцогчдыг хамруулан СББӨ-ийн хамгаалалтад бүх нийтийн оролцоог хангах замаар 'бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох' гэсэн Зорилт 16.7, түүнчлэн 'төр, төр-хувийн хэвшил болон иргэний нийгмийн үр дүнтэй түншлэлийг хөхүүлэн дэмжиж, төлөвшүүлэх' гэсэн ТХЗ-ын Зорилт 17.17-г дэмжиж байна. Энэ нь мөн дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалахтай холбоотой ТХЗ-ын Зорилт 11.4-тэй уялдаж байна. Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: СББӨ-ийг хамгаалахад хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн өргөн оролцооноос үүдэн энэхүү үзүүлэлт нь тодорхой хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой хэд хэдэн үзүүлэлтийг нөхөж дэмжиж байна: Үзүүлэлт 4 (боловсрол), Үзүүлэлт 8 (тооллого), Үзүүлэлт 11 (Соёлын бодлого) ба Үзүүлэлт 17 (мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх). Хамгаалалтанд оролцдог янз бүрийн оролцогчид, үүнд олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс, төрийн бүс байгууллагууд, иргэний нийгмийн оролцогчид, хувийн хэвшлийн байгууллагууд хоорондоо уялдаатай байх талаарх энэ үзүүлэлтийн үзэл санаа нь 25-р үзүүлэлтээр дэмжигдэж байгаа болно.	

**Үйл ажиллагаа
явуулах
үндэслэл**

Зүйл 15-д Оролцогч улс бүрийг СББӨ-ийн хамгаалалт, менежментэд “олон нийт, бүлгүүд, шаардлагатай бол хувь хүмүүсийн аль болох өргөн оролцоог хангахыг” хөхүүлэн дэмжиж байна. Энэхүү ерөнхий зарчмыг Үйл ажиллагааны Удирдамж болон ёс зүйн зарчмуудад нэвт шингээж нэгтгэж ирсэн болно. Энэ нь Төр ба эдгээр хамт олон бүлгүүдийн хоорондох хоёр талын түншлэл төдий гэсэн үг биш юм. Харин ч СББӨ-ийг хамгаалахад Үйл Ажиллагааны Удирдамж нь төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн бусад оролцогчид болон хувийн хэвшлийн оролцогчдод чухал үүрэг хүлээлгэсэн болно. Энэхүү өргөн хүрээний оролцогчдыг үр дүнтэй оролцуулах нь ерөнхийдөө СББӨ эсвэл СББӨ-ийн тодорхой зүйлүүдийн хувьд хамгийн сайн хамгаалагдах зайлшгүй шаардлага юм.

**Түлхүүр нэр
томъёо**

- Оролцогч талууд
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс
- Оролцоо
- Бүх нийтийн оролцоот / бүх нийтийг хамруулсан
- СББӨ-ийн зүйлүүд
- Бүртгэгдсэн (Жагсаалтад бүртгэгсэн эсэхээс үл хамааран)
- Төрийн бус байгууллагууд
- Иргэний нийгэм
- Оролцогчид
- Хувийн хэвшил
- Соёлын биет бус өвийг хамгаалах ёс зүйн зарчим

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

**Үзлэг шалгалт
хийх ашиг түс**

Зүйл 15-ын ач холбогдлыг анхааралдаа авч, үзлэг шалгалт хийх нь тухайн улс орон хамт олон, бүлгүүд, хувь хүмүүсийн аль болох өргөн оролцоотойгоор хамгаалах үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхийг үнэлэхэд тусална. СББӨ-ийн хамгаалалтад иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог үзэж шалгах нь төр, олон нийтийн хүчин чармайлтын үр нөлөөг нэмэгдүүлэх бололцоог олж тодорхойлоход туслахын хамт орон нутагт тохирсон арга замыг тодорхойлоход бас дэм үзүүлнэ. Дэлхийн түвшинд үзлэг шалгалт нь сайн туршлагын жишээг харилцан хуваалцаж, СББӨ-ийг хамтран хамгаалах үйлсэд оролцогч талуудыг өргөнөөр татан оролцуулж бүрэн амжаагүй байгаа улс орнуудад үлгэр дүүриал, сургамж өгч чадах юм.

**Мэдээллийн
эх сурвалж
ба мэдээлэл
цуглуулах**

Соёлын яам, эсвэл үндэсний болон орон нутгийн түвшинд СББӨ-ийг хамгаалах үйл ажиллагааг хариуцсан адил төстэй байгууллагууд нь янз бүрийн оролцогч талуудын өргөн оролцооны талаарх мэдээллийн чухал эх сурвалж байж болно. Хэрэв тухайн улс нь бүх нийтийн оролцоот зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизмтай бол хамгаалалтад оролцох оролцоо нь энэ үзүүлэлтэд хамаарах янз бүрийн салбарын төлөөллийг багтааж болно. Ийм яамд, зөвлөлдөх байгууллагууд эсвэл механизмуд нь ерөнхийдөө СББӨ эсвэл тодорхой өвийн зүйлүүдийг хамгаалах талаарх хүчин чармайлтын талаар одоо үеийн мэдээллээр хангаж чадах юм. Мөн төрөл бүрийн оролцогчдын хувьд туршлага солилцох, үр дүнтэй түншлэл хөгжүүлэх Чуулган болж үйлчилж болно. Хэрэв тухайн Оролцогч улс хамгаалалтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор санхүүжилтийн нэг буюу хэд хэдэн сүлжээтэй бол эдгээр механизм нь оролцогч талуудын өргөн оролцоо, үйл ажиллагааны жишээнүүдийг ил гарган танилцуулж болохсон билээ.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Соёлын яам болон/эсвэл бусад СББӨ-ийн хамгаалалтыг дэмжиж буй санхүүжилт олгодог байгууллагуудын төсөв, ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны тайлан
- СББӨ-ийн хамгаалалтад идэвхтэй оролцдог хамт олны холбоод, төрийн бус байгууллагуудын талаарх цахим хуудсууд болон бусад мэдээллийн эх сурвалжууд
- Хэрэв хамгаалалтын төлөвлөгөөнд шаарддаг бол улсын хэмжээний жагсаалт, эсвэл бүртгэлд оруулахаар санал болгосон өвийн зүйлсийн нэр дэвшүүлэх баримт материалууд
- Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад бүртгүүлэхээр бэлтгэсэн нэр дэвшүүлэх баримт материалууд
- Үндэсний жагсаалт эсвэл ЮНЕСКО-ийн аль нэг жагсаалтад бүртгэгдсэн өвийн зүйлийн талаар Оролцогч улсаас гаргаж өгсөн хугацаат тайлан

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	22. Иргэний нийгэм СББӨ-ийн хамгаалалтад хяналт тавихад хэр зэрэг хувь нэмэр оруулж байгаа байдал (хүрсэн түвшин)	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	22.1 Холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүс СББӨ-ийн хамгаалалтын хөтөлбөр, арга хэмжээний талаарх шинжлэх ухаан, техник, урлагийн чиглэлийн судалгаа хийх, хяналт тавих таатай орчин бүрдсэн байна.	ҮАУ 85, ҮАУ 151, ҮАУ 153(b)(ii)
	22.2 ТББ, иргэний нийгмийн бусад байгууллагууд СББӨ-ийн хамгаалалтын хөтөлбөр, арга хэмжээний талаарх шинжлэх ухаан, техник, урлагийн судалгаа хийх, хяналт тавих таатай орчин бүрдсэн байна.	ҮАУ 83, ҮАУ 151, ҮАУ 153(b)(ii)
	22.3 ТББ, иргэний нийгмийн бусад байгууллагууд СББӨ-ийн хамгаалалтын хөтөлбөр, арга хэмжээний талаарх шинжлэх ухаан, техник, урлагийн судалгаа хийх, хяналт тавих таатай орчин бүрдсэн байна.	ҮАУ 83, ҮАУ 84, ҮАУ 151, ҮАУ 153(b)(ii)
ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь үзүүлэлт 21-ийн адил, 'бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох' гэсэн Зорилт 16.7, түүнчлэн 'төр, төр-хувийн хэвшил болон иргэний нийгмийн үр дүнтэй түншлэлийг хөхүүлэн дэмжиж, төлөвшүүлэх' гэсэн ТХЗ-ын Зорилт 17.17-г дэмжиж байна. Энэ нь бусад үзүүлэлтийн адил мөн дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалахтай холбоотой ТХЗ-ын Зорилт 11.4-тэй үялдаж байна.</p> <p>Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Шалгуур үзүүлэлт 21 нь олон янзын оролцогчдын СББӨ-ийн хамгаалалтад хамгийн өргөн оролцоотой байх тухай ярьдаг бол энд СББӨ-ийн хамгаалалтад үзлэг шалгалт хийхэд тэдний оролцоонд анхаарлаа хандуулдаг. Нэмж дурдахад, энэ үзүүлэлт нь Шинжлэх ухаан, техник, урлагийн судалгааг харуулсан 9-р үзүүлэлттэй нийцэж байгаа боловч 9-р үзүүлэлт СББӨ-ийг өөрийг нь хамгаалахад голчлон анхаарч байгаа бөгөөд харин энэ үзүүлэлт СББӨ-ийг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг судлахад төвлөрөн анхаарч байгаа юм.</p>	

Үйл ажиллагаа явуулах үндэслэл

СББӨ-ийн хамгаалалтын хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөөг тэдгээрийг тогтмол үзэж шалгах, тэдгээрт чиглэсэн шинжлэх ухаан, техник, уран сайхны судалгааг нэмэгдүүлэх, сайжруулах замаар дээшлүүлэх боломжтой. Ийм үзлэг шалгалт, судалгаанаас аль хөтөлбөр, арга хэмжээ эерэг нөлөө үзүүлж байгаа талаар хариу мэдээлэл авч болно. Төрийн бус байгууллагууд болон иргэний нийгмийн бусад байгууллагууд голдуу ийм үзлэг шалгалт, судалгааг явуулах үедээ туршлага болон туршилтыг хамтруулж чаддаг давуу талтай. Энэ нь тэдгээр байгууллагуудыг дээр дурдсан үзлэг шалгалт, судалгаа хийх нэн чухал оролцогч болгож хувиарладаг билээ. Судалгааны байгууллагууд, мэргэжлийн шинжилгээний төвүүд нь улс бүрийн өвөрмөц нөхцөл байдлаас үүдэн төрийн эсвэл төрийн бус байж болох билээ. Эрдэмтэд, шинжээчид нь төрийн албан хаагчид эсвэл хувь хүмүүс байж болох юм. Гэсэн хэдий ч, ямар ч тохиолдолд ийм үүрэг гүйцэтгэгчид Конвенцийн хэрэгжилтийг улс орны түвшинд үзэж хянахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Түлхүүр нэр томъёо

- Иргэний нийгэм
- Таатай орчин
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс
- Шинжлэх ухаан, техникийн болон урлагийн судалгаа
- ТББ
- Судалгааны байгууллагууд
- Мэргэжлийн төвүүд

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус	Энэхүү үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь үзлэг шалгалтын үйл явцыг анхаарлын төвд шилжүүлж, тухайн үйл явц нь СББӨ-д хамрагдсан иргэний нийгмийн оролцогчдын оролцооноос ашиг тусаа авч байгаа эсэх, мөн үйл явц янз бүрийн зорилгоор явуулсан СББӨ-ийн судалгаанд мэдээлэгдсэн эсэхийг тодорхойлоход тухайн улсад тусална. Энэхүү үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь байнгын болон ирээдүйн үзлэг шалгалт, судалгаанд эдгээр оролцогчдын оролцоог бүрэн хангахад өөр бусад боломжийг илрүүлж чадна. Энэхүү үзүүлэлтийг дэлхийн түвшинд үзэж шалгах нь иргэний нийгмийг үзлэг шалгалтын үйл явцад татан оролцуулах үр дүнтэй механизмын жишээг санал болгож байна. Мөн улс орнууд иргэний нийгмийн оролцогчдын мэдлэг, хэтийн төлөвийн талаарх давуу талыг дэмжиж ашиглаж байна.
------------------------------------	---

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах	Энэ үзүүлэлт нь үзлэг шалгалт хийх үйл явцад анхаарлаа төвлөрүүлдэг тул төрийн өмнөөс хяналт тавьж, тайлагнах үүрэгтэй хүмүүс янз бүрийн түвшинд үзлэг шалгалт хийхдээ хувь нэмэр оруулж буй хамт олон, төрийн бус байгууллагууд болон бусад оролцогч талуудтай зөвлөлдөх шаардлага гарч ирж магадгүй юм. Хэрэв Зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизм нь байгаа бол тэдгээр нь үзлэг шалгалтын үйл ажиллагааг төлөвлөх, хянах, явуулах, үнэлэх олон талт оролцогчдыг нэгтгэх чухал талбар байж болох талтай.
	<p>Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд</p> <ul style="list-style-type: none"> • Үзлэг шалгалт явуулах, тайлан гаргах эрх үүрэг бүхий байгууллагын ажлын төлөвлөгөө • Зөвлөлдөх байгууллагын эсвэл зохицуулалтын механизмын ажлын төлөвлөгөө, хөтөлбөр, хурлын тэмдэглэл, • Ном зүй, хэвлэн нийтлэгчдийн каталог, эсвэл хэвлэгдсэн бүтээлүүдийн тойм • Чуулганы хөтөлбөр, хэлэлцэх асуудал, түүнчлэн төрийн бус байгууллагууд эсвэл иргэний нийгмийн бусад оролцогчдын илтгэл, үйл явдлыг тэмдэглэсэн баримт бичиг • Төрийн бус байгууллага эсвэл иргэний нийгмийн бусад оролцогчдын хийсэн судалгааны тайлан

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	23. Хорооноос зөвлөх болон зөвлөлдөх ажил үүрэгт татан оролцуулж байгаа ТББ, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, хувь хүмүүсийн тоо болон газарзүйн тархалтын байршил	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	23.1 Зөвлөх үйлчилгээ үзүүлэх батламжит ТББ-уудын тоо, газарзүйн тархалтын байршил болон СББӨ-ийн айнууд дахь байгууллагуудын төлөөлөл.	Зүйл 9 ҮАУ 93
	23.2 Конвенцийн удирдах байгууллагуудын хуралдаан, ажлын хэсэгт оролцож буй ЮНЕСКО-ийн батламжит ТББ-уудын хувь хэмжээ, тэдгээрийн газарзүйн тархалтын байршил.	ҮАУ 96
	23.3 Үнэлгээний механизмаас гадуур зөвлөлдөх зорилгоор Хорооноос батламжит төрийн бус байгууллагуудыг татан оролцуулсан тохиолдол болон үйл ажиллагааны тоо.	Зүйл 8 ҮАУ 96
ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь 'төр, төр-хувийн хэвшил болон иргэний нийгмийн үр дүнтэй түншлэлийг хөхүүлэн дэмжиж, төлөвшүүлэх' гэсэн ТХЗ-ын Зорилт 17.17-г шууд утгаар дэмжиж байгаа бөгөөд мөн 'бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох' гэсэн Зорилт 16.7-д хувь нэмэр оруулах боломжтой байна. Конвенцийн удирдлагад хувь нэмэр оруулах замаар энэ үзүүлэлт нь мөн дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалахтай холбоотой ТХЗ-ын Зорилт 11.4-ийг дэмжиж байна.	
	Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Бусад хэд хэдэн үзүүлэлтүүд нь улсын түвшний төрийн бус байгууллагуудын оруулсан хувь нэмрийг авч үздэг: Үзүүлэлт 4 (чадавхийг бэхжүүлэх), Үзүүлэлт 8 (тооллого хийх), Үзүүлэлт 21 (СББӨ-ийн ерөнхий болон тодорхой элементүүдийн хамгаалалт) ба Үзүүлэлт 22 (улсын хэмжээний үзлэг шалгалт). Энэхүү үзүүлэлт нь Хороонд зөвлөх эсвэл зөвлөлдөх эрхтэй ажилладаг ТББ болон бусад байгууллагын мэдлэг, түршлагыг хэр зэрэг ашиглаж байна вэ гэдэгт төвлөрдөг.	
Үйл ажиллагаа явуулах үндэслэл	Зүйл 9-д 'Соёлын биет бус өвийн чиглэлээр хүлээн зөвшөөрөгдсөн чадавхитай ТББ-уудыг Хороонд зөвлөх эрхтэйгээр ажиллах магадлан итгэмжлэл олгох' үйл явцыг тусгасан бол Зүйл 8.4 нь тийм төрийн бус байгууллагуудыг бусад "олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хувь хүмүүстэй хамт өөрийн хуралд урихыг Хороонд зөвшөөрч байгаа юм. Энэ нь Хороо тусгай асуудлуудад тэд нартай зөвлөлдөх зорилготой юм. ТББ-ууд болон бусад байгууллагууд нь номинациуд, санал, хүсэлтүүд болон тайлангуудаа (0D96)	

үнэлгээ хийх үүрэг бүхий Үнэлгээний байгууллагын ажилд тусгай үүрэг гүйцэтгэхийн дээр тэдгээр байгууллагуудад Хорооноос бас дээр дурдсан Зөвлөх эсвэл Зөвлөлдөх үүрэг даалгадаг юм.

Түлхүүр нэр томъёо

- ТББ
- СББӨ-ийн салбар/айнууд

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

Энэхүү үзүүлэлтэд дэлхийн түвшинд үзлэг шалгалт хийх нь төрийн бус байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, хувь хүмүүсийн санал болгож буй зөвлөх үйлчилгээнээс Хороо аль болох бүрэн ашиг тус авч байгаа эсэхийг үг Хороонд мэдээлэхэд тусалж байдаг. Түүнээс гадна дэлхийн түвшний үзлэг шалгалт нь Хороонд магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагууд дэлхийн янз бүрийн бүс нутгийг сайн төлөөлж байгаа эсэх, тэд СББӨ-ийн янз бүрийн айг зохих ёсоор төлөөлж байгаа эсэхэд үнэлгээ өгч чадах юм. Мөн Хороо дутуу төлөөлөлтэй байж болзошгүй бүс нутаг эсвэл айн төлөөллийг нэмэгдүүлэх талаар санаачилга гаргах эсэхийг үнэлж зөвлөгөө өгөх болно.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Энэхүү үзүүлэлтийг Хороонд зөвлөх үйлчилгээ үзүүлэх итгэмжлэгдсэн бүх төрийн бус байгууллагууд, тэдгээрийн оршин суугаа улс, үйл ажиллагааны цар хүрээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийн санг хөтлөн явуулдаг Нарийн бичгийн дарга нарын газар дэлхийн түвшинд үзэж хянаж байдаг. Нарийн бичгийн дарга нарын газар нь Хорооны болон Ерөнхий Ассамблейн хуралдаан, ажлын хэсгүүдэд ийм төрийн бус байгууллагуудын оролцоо, мөн Хорооноос зөвлөлдөх үйлчилгээг авч болох тохиолдлуудын талаар мэдээллийг хадгалж байдаг.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Нарийн бичгийн газраас хөтөлдөг мэдээллийн сан
- ТББ-уудын форумын болон СББӨ-д хамрагдсан бусад иргэний нийгмийн сүлжээнүүдийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн сайтууд

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт

24. СББӨ-ийг хамгаалах талаар бусад Оролцогч улс орнуудтай идэвхтэй хамтран ажиллаж байгаа Оролцогч улс орнуудын хувь хэмжээ (процент)

Үнэлгээ хийх хүчин зүйлүүд

Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний дөрвөн хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:

24.1 Ерөнхийдөө СББӨ-ийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс хоёр талт, олон талт, бүс нутгийн эсвэл олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж байна.	Зүйл 19 ҮАУ 86
24.2 СББӨ-ийн зарим онцгой өвийн зүйл, ялангуяа аюул занал учирч буй, нэгээс олон улсын нутаг дэвсгэрт байгаа болон хил дамнасан өвийн зүйлүүдийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор хоёр талт, олон талт, бүс нутгийн эсвэл олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.	Зүйл 19 ҮАУ 13, ҮАУ 14, ҮАУ 15
24.3 Хамгаалалтын сайн туршлагыг багтаасан СББӨ болон түүний хамгаалалтын талаарх мэдээлэл, туршлагыг бусад оролцогч улсуудтай солилцдог байна.	Зүйл 19 ҮАУ 156, ҮАУ 193
24.4 Өөр нэг оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа СББӨ-ийн зүйлийн талаарх баримт, мэдээллийг тэр Оролцогч улстай хуваалцдаг байна.	Зүйл 19 ҮАУ 87

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Бусад бүх үзүүлэлтүүдийн адилаар энэхүү үзүүлэлт нь мөн дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалахтай холбоотой ТХЗ-ын Зорилт 11.4-ийг дэмжиж байна.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Бусад олон үзүүлэлтүүд нь тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа СББӨ-ийг хамгаалах талаарх хүчин чармайлтад төвлөрч байгаа бол энэ үзүүлэлт нь нэгээс олон оронд байгаа СББӨ-ийг ерөнхийд нь бас онцгой өвийн зүйлүүд, тэрчлэн хил дамнасан өвийн зүйлүүдийг хамгаалах талаар тухайн улс орон бусад улс оронтой тогтоосон хамтын ажиллагааг авч үздэг юм. Ийнхүү энэ үзүүлэлт нь баримт бичигтэй холбоотой 9, 10-р үзүүлэлтүүд, түүнчлэн хамгаалалтын сайн туршлагүүдтай холбоотой 19-р үзүүлэлтүүдийг нөхөж дэмжиж байна. СББӨ-ийн хамгаалалт нь ихэнх үзүүлэлтүүдийг хамардаг тул энд дурдсан үйл ажиллагаа нь дотоодын хүчин чармайлтыг нөхөн дэмжиж өгдөг. Үзүүлэлт 25 нь олон улсын хамгаалалтын талаархи хамтын ажиллагаа явуулдаг байгууллага, оролцогчидтой холбоотой юм. Энд дурдсан бүх үйл ажиллагаа энд хамаарна.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл	Конвенцийн дөрвөн зорилгын нэг нь ‘олон улсын хамтын ажиллагаа, туслалцаа үзүүлэх’ явдал юм (1-р зүйлийн г). Энэхүү Конвенц нь олон улсын хамтын ажиллагааг ‘мэдээлэл, туршлага солилцох [болон] хамтарсан санаачлагууд’, бусад зүйлийг багтаасан болно (19-р зүйл). Улс орнууд ‘хоёр талын, дэд бүсийн, бүс нутгийн болон олон улсын түвшинд хамтран ажиллах үүрэг хүлээнэ’ (19 дүгээр зүйл), ингэснээр тэдний олон улсын хэмжээнд явуулах үйл ажиллагаа нь Конвенцийн үндсэн зарчимтай нийцэж байна. Улс хоорондын хоёр ба олон талт хамтын ажиллагаа нь мөн Конвенцийн хамтын ажиллагааны үзэл санааг илэрхийлдэг.
---------------------------------------	---

Түлхүүр нэр томъёо	<ul style="list-style-type: none"> • Бүс нутгийн • СББӨ-ийн зүйлүүд
---------------------------	---

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус	Энэхүү үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь улс бүр өөрийн хэрэгжүүлж буй хамгаалах арга хэмжээнээс гадна бусад улстай хамтран ажиллах боломжийг хэр зэрэг ашиглаж байгааг үнэлэхэд тусалж чадна. Үзлэг шалгалт хийх нь ийм хамтын ажиллагааны одоохондоо мэдэгдээгүй багаа цаашдын бололцоонуудыг нээн илрүүлэх болно. Дэлхийн түвшинд энэ үзүүлэлтэд үзлэг шалгалт хийх нь Конвенцийн үзэл санааны хүрээнд авч хэрэгжүүлснээс гадна Конвенцийн удирдах байгууллагуудаас тусдаа бие даан хэрэгжүүлж буй зэрэг хоёр талт болон олон талт үйл ажиллагааны олон тоо хэмжээг ялгаж гаргахад тус дэм өгнө.
------------------------------------	--

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах	Үзлэг шалгалт хийх, тайлан гаргах үүрэг бүхий хүмүүс нь Соёлын яам болон бусад салбар яамд, түүний дотор Гадаад харилцааны яамны бусад улстай хоёр ба олон талт хамтын ажиллагааны бүртгэл хөтөлдөг олон улсын хамтын ажиллагааны газартай зөвлөлдөх хүсэлт тавьж хамтран ажиллаж болно. Хэрэв тухайн улс нь зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулах механизмтай бол тэд нарын оролцож холбогддог олон улсын хамтын ажиллагааны талаар гишүүдтэйгээ зөвлөлдөх нь зүйтэй. Холбогдох баримт материал хадгалдаг байгууллагуудтай холбоо барьж бусад улстай баримт бичиг солилцох талаар мэдээлэл авах боломжтой.
--	--

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Соёлын яам болон бусад салбарын яамд, түүний дотор Гадаад харилцааны яамны олон улсын хамтын ажиллагааны газрын тайлан, бүртгэл
- Архив болон бусад баримтжуулалтын байгууллагуудын тайлан, бүртгэл
- СББӨ-ийн хамгаалалтад оролцогчдын сүлжээ, мэргэжлийн холбоод

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт	25. Олон улсын сүлжээ, байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд идэвхтэй оролцож байгаа Оролцогч улс орнуудын хувь хэмжээ (процент)	
Үнэлгээ хийх хүчин зүйлүүд	Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:	
	25.1 Оролцогч улс нь арга хэмжээг хүлээн авагч, зохион байгуулагч буюу ач тусыг хүртэгчийн хувьд ЮНЕСКО-ийн СББӨ-ийн 2-р ангиллын Төвүүдийн үйл ажиллагаанд оролцдог байна.	ҮАУ 88
	25.2 СББӨ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хамт олон, бүлэг, хувь хүмүүс, төрийн бүс байгууллагууд, шинжээчид, мэргэжлийн төвүүд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн дунд олон улсын сүлжээг хөхүүлэн дэмжиж ажилладаг байна.	ҮАУ 86
	25.3 Оролцогч улс нь ЮНЕСКО-оос бусад олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын СББӨ-тэй холбоотой үйл ажиллагаанд оролцдог байна.	

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал	Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): Энэхүү үзүүлэлт нь дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалахтай холбоотой ТХЗ-ын Зорилт 11.4-ийг дэмжиж байна. Түүнчлэн ‘төр, төр-хувийн хэвшил болон иргэний нийгмийн үр дүнтэй түншлэлийг хөхүүлэн дэмжиж, төлөвшүүлэх’ гэсэн ТХЗ-ын Зорилт 17.17-г мөн нөхөн дэмжиж байна.
--	---

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэхүү үзүүлэлт нь хамгаалалтын талаарх олон улсын хамтын ажиллагаанд хамаатай Үзүүлэлт 24-тэй нийцэж байна. Энд ийм үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд болон бусад оролцогчид анхаарлаа төвлөрүүлдэг. Эдгээр байгууллагууд нь Үзүүлэлт 1 (байгууллагын чадавхи), Үзүүлэлт 2 (чадавхийг бэхжүүлэх байгууллагууд) эсвэл Үзүүлэлт 6 (дунд сургуулийн дараахь шатны сургалтын байгууллагууд) гэх мэт бусад үзүүлэлтүүдэд дурдагдсан байгууллагуудын нэг байж болно.

Үйл ажиллагаа явуулах үндэслэл	24-р үзүүлэлттэй холбоотойгоор Конвенцийн дөрвөн зорилгын нэг нь ‘олон улсын хамтын ажиллагаа, туслалцаа үзүүлэх’ (Зүйл 1(d)) бөгөөд Конвенцид олон улсын хамтын ажиллагааг бусад санаачилгын дотор хамтарсан санаачилга хэмээн тодорхойлдог (Зүйл 19). Зүйл 19-д улс орнууд ‘Хоёр талын, дэд бүсийн, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд хамтран ажиллахыг’ шаарддаг бөгөөд ийм хамтын ажиллагааг энд дүрдсанчлан сүлжээ, институтын хамтын ажиллагааны хүрээнд албан ёсоор баталгаажуулж болно. 2-р ангиллын төвүүд нь ихэвчлэн олон улсын болон бүс нутгийн сүлжээг бэхжүүлэх, хамгаалалтын талаар туршлага солилцох, ялангуяа Конвенцийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийг дэмжих хүрээнд оролцдог. Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад агентлагууд болон бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагаа улам бүр СББӨ болон түүний хамгаалалтыг хамарч байгаа бөгөөд олон улс үүнийг олон улсын хамтын ажиллагааны чухал форум гэж үздэг болжээ.
---------------------------------------	---

Түлхүүр нэр томъёо

- 2-р ангиллын төвүүд
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс
- Төрийн бус байгууллагууд
- Мэргэжлийн төвүүд
- Судалгаа, шинжилгээний байгууллагууд
- Бүс нутгийн

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

Үзлэг шалгалт хийх ашиг тус

Олон улсын сүлжээ ба институтын хамтын ажиллагаанд үзлэг шалгалт хийх, тайлагнах нь тухайн улс Конвенцийн олон улсын хамтын ажиллагааг дэмжих үндсэн зорилгод хэр хариу өгч байгааг дүгнэхэд тусалж чадна. Ийм үзлэг шалгалт нь тухайн улс орон дахин сэргээж өргөжүүлэхийг хүсч байгаа хамтын ажиллагааны үр дүнтэй жишээг эргэн сэргээхэд тусалж чадна. Үүнтэй нэгэн адил дэлхийн хэмжээнд үзлэг шалгалт явуулах нь олон улсын хамтын ажиллагааны үр дүнгээ харуулсан туршлага, үлгэр жишээг олж тогтооход тусалж, цаашид ямар арга хэмжээ, арга хандлагыг үргэлжлүүлж болохыг харуулахад тусалж байгаа болно.

Мэдээллийн эх сурвалж ба мэдээлэл цуглуулах

Үзүүлэлт 24-ийн адил үзлэг шалгалт явуулах, тайлагнах үүрэг бүхий хүмүүс нь бусад улс орнуудтай институтын хамтын ажиллагааны бүртгэл хөтөлдөг Соёлын яамны олон улсын хамтын ажиллагааны албатай зөвлөлдөхийг эрмэлзэх нь зүйтэй. Гадаад харилцааны яам нь олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай тухайн улсын оролцооны талаар мэдээллийн тоймыг бүртгэн хөтөлдөг бол сайн талтай. Олон улсын тэдгээр байгууллагууд нь ерөнхийдөө СББӨ, түүний хамгаалалтыг хангах чиглэлээр улам бүр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг болоод байна. Хэрэв Оролцогч улс нь зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизмтай бол тэдгээрийн оролцож болох институтын хамтын ажиллагааны талаар гишүүдтэйгээ зөвлөлдөж байх шаардлагатай.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Соёлын яам болон бусад салбарын яамд, түүний дотор Гадаад харилцааны яамны олон улсын хамтын ажиллагааны газрын тайлан, бүртгэл
- Холбогдох 2-р ангиллын төвийн мэдээллийн товхимол, цахим хуудас
- Төрийн бус байгууллага, мэргэжлийн төв, судалгааны хүрээлэнгийн мэдээллийн товхимол, цахим хуудас
- Тухайн улс нэгдэн орсон олон улсын гэрээ, олон улсын гэрээний эмхэтгэл, албан ёсны сонин/сэтгүүл

ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Үзүүлэлт

26. СББӨ-ийн олон улсын Сан нь хамгаалалт ба олон улсын хамтын ажиллагааг дэмжиж ажилладаг байна.

Үнэлгээ хийх хүчин зүйлүүд

Оролцогч улс бүр үзэж шалгаад, тайлагнасан улсын-хэмжээний гурван хүчин зүйлийг үндэслэн энэхүү үзүүлэлтийг тодорхойлно:

26.1 Оролцогч улсууд СББӨ-ийн сангаас санхүүгийн болон техникийн туслалцаа хүсч, ийм тусламжийн үр дүнд СББӨ-ийг хамгаалах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.	Зүйл 19, Зүйл 21
26.2 Оролцогч улсууд эсвэл бусад байгууллагууд ерөнхий болон тодорхой зорилгоор, ялангуяа олон улсын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрт зориулж СББӨ-ийн Санд сайн дураараа нэмж хандив өгдөг байна.	Зүйл 25.5, Зүйл 27 ҮАУ 68-71
26.3 Хөгжиж буй орнуудын СББӨ-ийн мэргэжилтнүүд, батламжит ТББ, төрийн болон хувийн байгууллагууд, Хорооны хурлуудад зөвлөх эрхтэйгээр уригдсан хамт олон, бүлгүүдийн гишүүдийн Конвенцийн удирдах байгууллагуудын хуралдаанд оролцох зардлыг дэмжихэд хэрэглэгддэг байх.	Зүйл 8, Зүйл 9 ҮАУ 67

ТХЗ болон бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ): ТХЗ-үүд нь олон улсын хамтын ажиллагаа, тусламжийг (санхүүгийн туслалцааг оруулан) дэмжихэд анхаарч байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь хэд хэдэн зорилго, зорилтыг дэмжиж байна. Жишээлбэл, ТХЗ-ын Зорилт 1.а нь 'ядуурлын бүх хэлбэрийг арилгах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор хөгжиж буй орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудад хүртээмжтэй, урьдаас тодорхой арга хэрэгслээр хангах үүднээс хөгжлийн хамтын ажиллагааг сайжруулах замаар төрөл бүрийн эх үүсвэрээс хөрөнгө мөнгийг үлэмж хэмжээгээр бүрдүүлэх' зорилт тавьж байна. ТХЗ-ын Зорилт 10.б нь 'хэрэгцээ шаардлага өндөр байгаа улс орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй орнууд, Африкийн орнууд, жижиг арлын хөгжиж буй орнууд, далайд гарцгүй орнууд'-д санхүүгийн туслалцаа үзүүлэхийг нэн тэргүүнд тавьдаг бол ТХЗ-ын Зорилт 17.3 нь 'төрөл бүрийн эх үүсвэрээс хөгжиж буй орнуудад зориулан нэмэлт санхүүгийн хөрөнгө бүрдүүлэх'-д анхаарч, мөн ТХЗ-ын Зорилт 17.9 нь 'хөгжиж буй орнуудад чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон улсын дэмжлэгийг нэмэгдүүлэх'-ийг хөхүүлэн дэмжиж байна. Үнэлгээ хийх хүчин зүйл 26.3 нь 'дэлхийн засаглалын үйл ажиллагаанд хөгжиж буй улс орнуудыг оролцуулах явдлыг нэмэгдүүлэх, сайжруулах' гэсэн ТХЗ-ын Зорилт 16.8-ыг дэмжиж байна. Мэдээжийн хэрэг, энэ үзүүлэлт нь дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалахтай холбоотой ТХЗ-ын Зорилт 11.4-ийг мөн дэмжиж байна.

Бусад үзүүлэлтүүдтэй холбогдох байдал: Энэхүү үзүүлэлт нь хамгаалалтын тодорхой үйл ажиллагаатай холбоотой бусад хэд хэдэн үзүүлэлтийг дэмжиж байгаа юм. Учир нь Соёлын биет бус өвийг хамгаалах сангийн (ICH Fund) тусалцааг бүх төрлийн хөтөлбөрийг хамгаалахад ашиглаж болно. Дэлхийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх хүрээнд энэ үзүүлэлт нь Үзүүлэлт 2 ба 3-ыг нөхөн дэмжиж байна. Үнэлгээ хийх хүчин зүйл 26.3 нь Хорооноос зөвлөх эсвэл зөвлөлдөх эрхтэйгээр оролцохыг урьсан оролцогчдод хамааралтай Үзүүлэлт 23-тай нийцэж байна.

**Үйл ажиллагаа
явуулах
үндэслэл**

Үзүүлэлт 24, 25-д дурдсанчлан Конвенцийн дөрвөн зорилгын нэг нь 'олон улсын хамтын ажиллагаа, тусалцаа үзүүлэх' (Зүйл 1(d)) бөгөөд Конвенцид цаашид 'соёлын биет бус өвийг хамгаалахад чиглэсэн оролцогч талуудын хүчин чармайлтад тусламж үзүүлэх механизмыг бий болгох'-ыг тодорхойлсон болно (Зүйл 19). Ийм тусламжийг дэмжихийн тулд Конвенц нь СББӨ-ийн Санг байгуулж, улс орнуудыг жил бүр төлөх хандиваас гадна сайн дураараа нэмэлт хандив өргөхийг уриалж (Зүйл 27), цаашид энэхүү хандивыг ерөнхий болон тодорхой зорилгоор ашиглаж болохыг заажээ (Зүйл 25.5). Удирдах байгууллагууд чадавхийг бэхжүүлэхэд ийм нэмэлт хандив оруулахад онцгой ач холбогдол өгдөг. Эцэст нь Хороо нь 'Хороонд газарзүйн янз бүрийн бүсэд шударга төлөөллийг бий болгохын тулд' Дүрэмдээ СББӨ-ийн олон төрлийн оролцогчдод, ялангуяа хөгжиж буй орнуудад санхүүгийн тусалцаа үзүүлэх боломжтой гэж тусгасан болно.

**Түлхүүр нэр
томъёо**

- Оролцогч талууд
- Төрийн бус байгууллагууд
- Хамт олон, бүлгүүд эсвэл, зарим тохиолдолд хувь хүмүүс

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ХУГАЦААТ ТАЙЛАН ГАРАХ ТАЛААРХИ ТУСГАЙ ЗААВАР

**Үзлэг шалгалт
хийх ашиг тус**

Энэ үзүүлэлтэд дэлхийн хэмжээний үзлэг шалгалт хийх нь Хороонд СББӨ-ийн сангаар дамжуулан үзүүлж буй тусламжийн үр нөлөөг үнэлэхэд тусалж, нэг буюу өөр бүс дэх хөгжиж буй орнуудын оролцоог хязгаарлаж буй боломжит саад бэрхшээлүүдэд анхаарал хандуулахад тус болно. Дэлхийн хэмжээний үзлэг шалгалт нь хандивлагч орнуудын чиг хандлагыг тодруулж, санхүүжилтийн дутагдал, гачигдалтай талбаруудыг олж тогтоож, Хорооноос нэмэлт хандивын хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах боломжийг нээхэд тус болно. Эцэст нь Конвенцийн удирдах байгууллагуудын уулзалтад оролцох оролцогч талуудыг өргөн хүрээнд хамруулахыг дэмжихэд тусалцаа үзүүлэхэд үзлэг шалгалт хийх нь хамгийн өргөн оролцоог хангаж өгөхөд туслах болно.

**Мэдээллийн
эх сурвалж
ба мэдээлэл
цуглуулах**

Энэхүү үзүүлэлтийн хувьд СББӨ-ийн Сан, түүний орлого (сайн дурын нэмэлт хандивыг оролцуулаад) болон түүний зарцуулалт (Олон улсын тусламж болон хуралд оролцох зардлыг дэмжих зорилгоор) зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан мэдээллийн сан болон бусад хэрэгслийг хөтлөн явуулдаг Нарийн бичгийн дарга нарын газраас дэлхийн хэмжээнд үзлэг шалгалтыг явуулдаг. Нарийн бичгийн дарга нарын газрын мэдээллийн сан нь Конвенцийн цахим хуудас дээр санхүүжилт хүсэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нийтлэхийг мөн дэмжиж ажилладаг. Олон улсын тусламжийн үр дүнд бий болсон үйл ажиллагаа нь ашиг хүртэгч Оролцогч улсаас Хороонд тогтмол тайлагнах сэдэв болдог (24.3 дугаар зүйл); ийм тайланг Конвенцийн цахим хуудас дээр байрлуулсан болно.

Мэдээлэл авах боломжтой эх сурвалжууд

- Нарийн бичгийн дарга нарын газраас хөтлөн явуулдаг мэдээллийн сан болон бусад хэрэгслүүд
- Олон улсын тусламж хүлээн авсан ашиг хүртэгч Оролцогч улсуудаас Хороонд ирүүлсэн тайлан



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization
유네스코
교육과학문화기구

ichcap

International Information and Networking Centre
for Intangible Cultural Heritage in the Asia-Pacific Region
유네스코 아시아태평양권역
무형유산센터

Соёлын биет бус өвийг
хамгаалах тухай 2003
оны Конвенцийн үр
дүнгийн хүрсэн түвшинг
тодорхойлох удирдамж

**GUIDANCE NOTES
FOR THE OVERALL
RESULTS FRAMEWORK
FOR THE 2003
CONVENTION FOR THE
SAFEGUARDING OF THE
INTANGIBLE CULTURAL
HERITAGE**



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Intangible
Cultural
Heritage